


Жилийн
тайлан | 2016


 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ

Агуулга



| | |
|--|----|
| Эрхэмсэг оршихуй, алсын хараа | 2 |
| Голомт банкны 2016 оны амжилтын товчоон | 4 |
| ТУЗ-ийн даргын мэндчилгээ | 6 |
| Голомт банкны засаглалын тайлан | 10 |
| Засаглалын тогтолцоо | |
| Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн | |
| ТУЗ-ийн бүрэлдэхүүн | |
| Удирдлагын баг | 16 |
| Голомт банкны бүтэц, зохион байгуулалт | |
| Монгол Улсын 2016 оны эдийн засгийн тойм | 20 |
| Монгол Улсын эдийн засгийн орчин | |
| Банкны системийн 2016 оны гүйцэтгэл | |
| Голомт банкны 2016 оны санхүүгийн үзүүлэлт | 26 |
| Голомт банкны амжилтын товчоон | 30 |
| Иргэдийн сегмент | |
| Байгууллагын сегмент | |
| Голомт банкны харилцагчдын амжилтаас | |
| Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа | |
| Банкны үйл ажиллагаа | 44 |
| Хүний нөөцийн хүрээнд хийгдсэн гол ажлууд | |
| Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гол ажлууд | |
| Эрсдэлийн удирдлага | 48 |
| Эрсдэлийн удирдлагын тогтолцоо | |
| Эрсдэлийн засаглал | |
| Зээлийн эрсдэлийн удирдлага | |
| Зах зээлийн эрсдэлийн удирдлага | |
| Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага | |
| Тусгай активын үйл ажиллагаа | |
| Актив, пассивын хосолсон удирдлага | 56 |
| Харилцагч банкууд | 58 |
| Худалдааны санхүүжилтээр хамтран ажиллагч | |
| банк санхүүгийн байгууллагууд | |
| Аудитын тайлан | 63 |





Эрхэмсэг оршихуй
Алсын хараа

Хөгжлийн голомт

Дэлхийн жишиг Монголын банк



Голомт банкны 2016 оны амжилтын товчоон

American Express®GreenCard-ыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлээ.



Голомт банк Монгол Улсын Top-100 компанийн Top-8-д шалгарлаа.



2016



Үндэсний тэргүүлэгч ажил олгогч, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч шилдэг байгууллагаар шалгарлаа.



Голомт банк нь Үндэсний хуримтлалын хөтөлбөрийг 2015.11.02-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд асар богино хугацаанд өндөр амжилтыг үзүүлж 45000 гаруй харилцагч нэгдээд байна.

Монгол Улсад анх удаа Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажилд зориулж Эм-Си-Эс Проперти ХХК-д 4 тэрбум төгрөгийн зээлийн баталгаа гарган ажиллалаа.



Голомт банк нь 2016 онд Customer centered branch business model, Shared back office, Eco digital banking, Credit process redesign, Credit card төслүүдийг амжилттай хэрэгжүүлэв. Ингэснээр ажилтны зүгээс бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад илүү ойлгомжтой хүргэх, аливаа эрсдэлээс сэргийлэх, банкны борлуулалт өсөх, ажилтны механик ажил буурах, эрсдэлийг хамгийн бага түвшинд барих зэрэг өргөн боломж нээгдээд байна.



Голомт банкны Зэс кредит карт нь дэлхийд алдартай Виза олон улсын байгууллагаас 2016 оны Шилдэг инновацитай бүтээгдэхүүн, МҮХАҮТ-аас 2016 оны Шилдэг инноваци нэвтрүүлэгч онцлох энтрепренер гэсэн нэр хүндтэй шагналуудыг гардан авлаа.

Голомт банк нь 15 дахь жилдээ Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг амжилттай зохион байгуулла. Өнгөрсөн 22 жилийн хугацаанд нийт 1300 оюутанд 1 тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг олгожээ.



Дэлхийн кино театрын хөгжлийг Монголд авчрах үйлсийг дэмжин IMAX кино театрыг санхүүжүүллээ.



Голомт банк жилийн 5 хувийн хүүтэй Оюутны хөгжлийн сургалтын зээл олгож эхэллээ.



Голомт банк нь ХАА-н салбарт бизнес эрхэлж буй харилцагчдад Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн зээлийг олгож эхэллээ.



Аль ч банкны харилцагч авах боломжтой дараа төлбөрт Зэс кредит картыг зах зээлд нэвтрүүллээ. Тус карт нь харилцагч төвтөй шинэлэг загвар бүхий тусгай ухлаадастай, 5 хүртэлх сая төгрөгийн зээлийн эрхтэй, 45 хүртэл хоног хүүгүй ашиглах боломжтой, харилцагчийн санхүүгийн гэнэтийн хэрэгцээг хангаж чадсан бүтээгдэхүүн гэдгээрээ давуу талтай.



Голомт банк Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-тай хамтран Скай Хайпермаркет ХХК-ийн eMart сүлжээ дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний татан авалтыг санхүүжүүллээ.



Голомт банк нь БНХАУ-ын Bank of Inner Mongolia-тай хоёр улсын гадаад худалдааг нэмэгдүүлэх, экспортлогч болон импортлогчдыг дэмжих зорилготой 15 сая ам.долларын Худалдааны санхүүжилтийн зээлийн гэрээг үзэглэв.




2016 оны ToC манлайлагч байгууллага болох Голомт банк нь ToC-ийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, түнш байгууллагууд, хамтран ажиллагсад аа

2016 онд Монгол Улсын эдийн засагт тодорхой сорилт, шалгуур тулгарсан хэдий ч Голомт банк нь энэхүү нөхцөл байдлыг сөрөн давж, зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлж ажиллалаа. Өнгөрсөн онд Голомт банк нь дунд хугацааны стратегиа Дэлхийн жишиг Монголын банк хэмээн баталж, алсын хараагаа тодорхойлов. Тиймээс бидний гаргах шийдвэр, хийх үйлдэл бүхэн дэлхийн жишигт хүрэх зорилго руу чиглэж байна. Үр дүнд нь өндөр хариуцлага, илүү хичээл зүтгэлээр төгөлдөржсөн засаглалыг бид хэрэгжүүлж чадах юм.



Бидний хичээл зүтгэлийн үр дүн банкны дотоод үйл ажиллагаанд эхнээсээ өгөөжөө өгч байна. Харин харилцагч таны хувьд 2018 онд дунд хугацааны стратеги төлөвлөгөө хэрэгжсэнээр банкны гол үзүүлэлтүүдэд илрэн харагдах юм.

Голомт банкны ТУЗ-өөс 2016 онд гаргасан онцлох шийдвэрийн нэг нь чадварлаг Гүйцэтгэх захирлыг томилсон явдал байсан бөгөөд гүйцэтгэх захирал өөрийн удирдлагын багийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр нэр хүндтэй, туршлагатай чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлсэн юм.

ТУЗ нь тус гүйцэтгэх удирдлагын багийг Голомт банкны дунд хугацааны стратегид тусгасан зорилтод хүрч, Монголын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байр сууриа улам бататгахад шаардагдах ур чадвар, зорилго эрмэлзлээр дүүрэн байгаа гэдэгт итгэл төгс байна.

ТУЗ нь өөрийн дэргэдэх хороодын дүрэм, журмыг олон улсын хамгийн сүүлийн үеийн чиг хандлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгон ажиллаж байна.

Бидний эхлүүлсэн шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын түвшний байнгын хороодын тоог цөөлсөн бөгөөд ингэснээр шийдвэр гаргалт хурдсан, хариуцлагын соёл сайжирсан.

Банкны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах үйл явц үргэлжилж буй энэ цагт гүйцэтгэх удирдлагын багаас Бизнесийн процессын ре-инженерчлэлийн төслийг санаачилсныг ТУЗ-ийн зүгээс санал нэгтгэйгээр дэмжин ажиллалаа.

Нэгжийн бүтцийн өөрчлөлт нь харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн Харилцагч төвтэй бизнес моделийг хэрэгжүүлэхэд чиглэсэн юм. Ингэж Голомт банк нь дижитал платформоо тэлж байгаа нь нөгөө талдаа зохистой эрсдэлийн удирдлагыг шаарддаг.

Тиймээс ТУЗ нь 2016 онд Эрсдэлийн аппетитийн тогтолцоо бичиг баримтаа шинээр боловсруулан баталж, эрсдэлийн метрикс үзүүлэлтүүдээ шинэчлэн, эрсдэлээ ухаалгаар удирдан, тооцоолох бодлогыг баримтлан ажиллалаа.

Бидний хичээл зүтгэлийн үр дүн банкны дотоод үйл ажиллагаанд эхнээсээ өгөөжөө өгч байна. Харин харилцагч таны хувьд 2018 онд дунд хугацааны стратеги төлөвлөгөө хэрэгжсэнээр банкны гол үзүүлэлтүүдэд илрэн харагдах юм.

2017 онд бид өмнөө маш энгийн бөгөөд томоохон зорилго тавьсан.

Энэ бол бид харилцагчийн хүлээлтээс давсан, тэр ч байтугай төсөөлөлд нь ч байгаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх, мэргэжлийн зөвлөх, үнэнч түнш нь байж, найдвартай, ашигтай, тогтвортой үйл ажиллагаагаар банкны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм.

Бид аливаа зорилгыг дэвшүүлэхдээ нөхцөл байдлыг бүтнээр нь үнэн бодитой харахыг чухалчилдаг юм. Ялангуяа эх үүсвэрээ нэмэгдүүлэхдээ өвлөн авсан муу зээлүүдэд анхаарч, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхдээ зардлыг бууруулан, үр бүтээлтэй ажиллахыг эрмэлзэхийн зэрэгцээ хяналт, комплаенсийн бодлогыг сайжруулан ажилладаг.

Голомт банкны ТУЗ нь эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн сорилтуудыг амжилттай даван туулж, урдаа тавьсан стратеги зорилгодоо хүрч, банкны бүх оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлж, урт хугацаанд тогтвортой ажиллахад шаардлагатай бүх дэмжлэг чиглэлийг ханган ажиллах болно гэдгээ илэрхийлье.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга



Ч.МӨНХЦЭЦЭГ



Голомт банкны засаглалын тайлан

Засаглалын тогтолцоо



Голомт банкны засаглалын хамгийн дээд эрх баригч Хувьцаа эзэмшигчид, засаглалын цөмд орших Төлөөлөн удирдах зөвлөл, үйл ажиллагааны дээд шийдвэр гаргагч Гүйцэтгэх удирдлага гээд бүгд зохистой засаглалыг хэрэгжүүлэх нь Голомт банк болон нийт оролцогч талуудын эрх ашигт нийцсэн, урт хугацаанд тогтвортой ажиллах ашигт ажиллагааны хамгийн чухал үндэс юм.

Тиймээс Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллага болох Монголбанкнаас гаргасан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам болон Голомт банкны Засаглалын кодекс зэрэг бичиг баримтуудыг мөрдлөг болгон ажиллахаас гадна банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос банкуудад зориулж гаргасан Засаглалын зарчмууд зэрэг олон улсын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийг зорин ажилласаар ирсэн.

Голомт банкны Дэлхийн жишиг Монголын банк болох алсын хараа нь зөвхөн бизнесийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд засаглалын тогтолцоогоороо ч салбартаа тэргүүлэгч байж, цаашлаад дэлхийн улс орнуудын шилдэг туршлагыг бүрэн хэрэгжүүлж, бусдад үлгэр дууриалал болох хэмжээнд хүрэх зорилт тавин ажиллаж байна.

Голомт файнэншил групп ХХК нь Дэлхийн эдийн засгийн чуулганаас Дэлхийн хурдацтай хөгжиж буй компаниудын нэгээр тодорсон нь тус компанийн үйл ажиллагаа дэлхийд үнэлэгдэж буйн илрэл юм.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн

- Голомт файнэншил групп ХХК - 83.76%
- Swiss-MO Investment AG - 9.98%
- Trafigura Beheer B.V. - 4.93%
- Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хувьцаа эзэмшигчид - 1.33%

Голомт банкны толгой компани болох Голомт файнэншил групп ХХК нь хөрөнгө оруулалт, банк, даатгал, брокер зэрэг зөвхөн санхүүгийн чиглэлээр дагнасан компаниудыг эгнээндээ нэгтгэсэн, 2000 орчим ажилтантай санхүүгийн томоохон байгууллага юм. Голомт файнэншил групп ХХК нь Дэлхийн эдийн засгийн чуулганаас Дэлхийн хурдацтай хөгжиж буй компаниудын нэгээр тодорсон нь тус компанийн үйл ажиллагаа дэлхийд үнэлэгдэж буйн илрэл юм.

Голомт банкны гадаад хөрөнгө оруулагч компаниудын нэг болох Swiss-MO Investment AG нь дэлхий даяар хөрөнгө оруулалт, түүний удирдлага болон худалдааны үйл ажиллагаа явуулдаг Швейцарийн Грizonсд үүсгэн байгуулагдсан хөрөнгө оруулалтын сан бөгөөд тус сангийн эзэн Ноён Урс Э.Шварценбах нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр нэр хүндтэй хөрөнгө оруулагч юм.

Trafigura Beheer B.V. нь 1993 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн газрын тосны гурав дахь том төмөр агуулаагүй баяжмал арилжаалагч олон улсын корпораци юм. Тус компанийг үүсгэн байгуулагчид нийт хувьцааны 20-иос бага хувийг эзэмшдэг бол удирдлагын багийн 700 орчим гишүүд бусад хувьцааг нь эзэмшдэг, шилдэг засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Голомт банк нь чадварлаг ажилтнуудаа урт хугацаанд тогтвортой ажиллах хөшүүрэг болгож Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд эдүгээ Хувьтай Голомт ТББ-д 150 гаруй ажилтан хамрагдаад байна. Ингэснээр ажилтнууд бусад хувьцаа эзэмшигчидтэй сонирхол нэгтэй болж, компанидаа эзний үүднээс хандах болсон. Хэдийгээр ажилтнууд 1.33 хувийн цөөнх хувьцааг эзэмшдэг ч ТУЗ-д нэг гишүүн томилох эрхтэй юм.

Голомт банкны хувьцааны төвлөрлөөс үл хамааран ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь томоохон хувьцаа эзэмшигчийн нөлөөнд орох эрсдэлгүй, хараат бус, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг. Учир нь ТУЗ-ийн нийт 6 гишүүний тал хувь нь хараат бус болон жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл

байдгаараа онцлогтой. Энэ нь аливаа шийдвэр тэдгээрийн оролцоогүйгээр гарахгүй гэсэн үг юм.

Тогтмол, идэвхтэй үйл ажиллагаатай Голомт банкны ТУЗ нь 2016 онд нийт 11 удаа хуралдаж, нийт 45 асуудлыг хэлэлцсэн байна. ТУЗ-ийн хуралдааны ирц дунджаар 94 хувьтай байсан болно.

ТУЗ хуралдсан огноо:

| | | |
|------------|------------|------------|
| 2016.02.04 | 2016.05.02 | 2016.10.13 |
| 2016.03.24 | 2016.06.28 | 2016.12.20 |
| 2016.03.29 | 2016.07.07 | 2016.12.22 |
| 2016.04.08 | 2016.09.13 | |

ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга хатагтай

Ч.Мөнхцэцэг

ТУЗ-ийн гишүүн ноён

Урс Э. Шварценбах

ТУЗ-ийн гишүүн ноён

З.Тэмүүн



ТУЗ-ийн гишүүн ноён

Д.Мөнхтөр

ТУЗ-ийн хараат бус гишүүн ноён

Ж.Үнэнбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн ноён

Антонио Л. Абелло

Ч. Мөнхцэцэг

Хатагтай Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи Улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн. 1996 онд ажлын гараагаа Монголын хөрөнгийн биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг газруудад ажиллаж байсан. 2010 оноос Тойм сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12 сараас Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12 сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Урс Э. Шварценбах

Ноён Урс.Э.Шварценбах нь Швейцарь Улсын Зюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Зюрих, 1972 онд Лондон дахь Юнион банкинд ажилласан. 1976 оноос өөрийн бизнесийг эхэлсэн бөгөөд 2000 онд Канадын Нова Скотиагийн St. Francis Xavier University-ийн хүндэт доктор цолоор шагнагдсан. Ноён Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1 сараас Швейцарь Улсад амьдарч байгаа ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын Хүндэт консулаар өргөмжлөгдсөн. Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр 2011 оноос эхлэн ажиллаж байна.

3. Тэмүүн

Ноён 3.Тэмүүн нь 2006 онд АНУ-ын Виржиниагийн Стрэйр их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2012 онд Вашингтоны Жорж мэсоны их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. Бодь группын охин компаниудад ажиллаж байсан туршлагатай. 2012 оны 12 сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон.

Д. Мөнхтөр

Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн. 1996 оноос Голомт банкинд туслах ажилтнаас эхлэн эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, Тэргүүн дэд захирлын үүрэгт ажлыг хашиж байсан. 2012 оноос ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ж. Үнэнбат

Ноён Ж.Үнэнбат нь 1985 онд ОХУ-ын Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжлээр төгссөн. 1994 онд АНУ-ын Колумбын их сургуульд олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой.

1990 оноос Монголбанкинд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996–2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 2000–2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж ирсэн. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийсэн, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.

Антонио Л. Абелло /Хараат бус гишүүн/

Ноён Антонио Л.Абелло нь Испанийн Барселоны их сургуулийг хуульч мэргэжлээр, IESE бизнесийн сургуулийг бизнесийн удирдлагын магистр цолтойгоор төгссөн. Барселоны хуулийн холбооны мэргэшсэн хуульч, CEFFAS стандартын дагуу Мэргэшсэн санхүүгийн аналит (CFA) зэрэгтэй.

Кредит свисс, Голдмэн сакс болон Парибас банкуудад бонд болон хөрөнгийн санхүүжилт хариуцсан удирдах түвшний албан тушаалуудыг хашиж байсан. Сингапур болон Лондон хотын хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудад 20 гаруй жил ажилласан, олон улсад өндрөөр үнэлэгддэг туршлагатай банкируудын нэг юм. Тэрбээр Turms Advisors LLP фирмийг үүсгэн байгуулагч, партнераар ажилладаг. 2014 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон.

Зохистой засаглалын тогтолцоог сайжруулахаар хийгдсэн ажлууд

Мэргэжлийн чадварлаг Гүйцэтгэх удирдлагын баг бүрдүүлэлт

ТУЗ нь 2016 онд Голомт банкны Гүйцэтгэх захирлаар Өлзийбаяр овогтой Ганзоригийг томилсон бөгөөд тэрбээр удирдлагын багаа олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

Тухайлбал Citigroup, EBRD зэрэг олон улсын томоохон банкуудад ажиллаж байсан туршлагатай Томаш Бравенец Холзхакерыг Гүйцэтгэх захирлын орлогчоор томилоод байна.

Засаглал, Стратеги

Тайлант хугацаанд Голомт банкны 2016–2018 оны дунд хугацааны стратегийг баталсан. Энэхүү стратеги нь Голомт банкны ирээдүйн ололт амжилтын бодитой төлөвлөгөө болж чадсанаас гадна засаглал, хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам төгөлдөржүүлэхэд чиглэсэн бодлогын бичиг баримт болсон.

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэхийн тулд олон улсын санхүүгийн корпорацитай хамтран компанийн Зохистой засаглалыг сайжруулах төслийг хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнд Голомт банкны засаглалын тогтолцоо дэлхийн жишигт бүрэн нийцэх юм.

ТУЗ-ийн сургалт хөгжил, үнэлгээ

Голомт банкны ТУЗ-ийн гишүүн бүр Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын сургалтанд хамрагдсан. Харин 2016 онд олон улсын санхүүгийн корпорациас Зохистой засаглал, Эрсдэлийн засаглал, Эрсдэлийн удирдлага чиглэлээр ТУЗ-ийн нийт гишүүдэд сургалт авч, шилдэг туршлага, сүүлийн үеийн чиг хандлагуудын талаар мэдээлэл авсан.

ТУЗ нь өөрийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцоогоо сайжруулах үүднээс жил бүр өөрийгөө үнэлдэг ба үнэлгээний дагуу дараагийн жилд хийх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Аудитын хороо нь Дотоод аудитын газраас хийж буй хараат бус шалгалтын тайланг хянаж, зохих шийдвэр зөвлөмжөөр ханган ажилладаг бөгөөд дотоод үйл ажиллагааны хяналтын хүрээнд, хөндлөнгийн аудитын компани болон банк хоорондын хамтын ажиллагааг удирддаг.

Үйл ажиллагааны хараат бус, бодит баталгаажуулалт нь засаглалын тогтолцооны салшгүй нэг хэсэг юм. Голомт банкны Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэх зорилготойгоор ТУЗ-д шууд ажлаа тайлагнадаг.

Голомт банкны Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аудитын аргачлалыг олон улсын стандартын дагуу ашигладаг ба газар нэгжээс гадна бүтээгдэхүүн, процессын шалгалтыг хийдэг. Мөн хагас жил тутамд 6+6 зарчмаар эрсдэлийн үнэлгээг хийж, аудитын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлдэг.

Голомт банк нь Дотоод аудиторуудын институт /TheIA/, Мэдээллийн системийн аудит болон Хяналтын холбооны /ISACA/ гишүүн болно.

Аудитын хороо нь 2 хараат бус гишүүн, нийт 5 гишүүнтэйгээр 2016 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 13 удаа хуралдаж, 84 асуудлыг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийг хянах, удирдах, дотоод хяналт, комплаенсийн тогтолцоог сайжруулах тал дээр анхаарч, ТУЗ-д зөвлөж ажилладаг. 2016 онд Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ нь Эрсдэлийн аппетитын тогтолцоо (Risk Appetite Framework/Statement) бодлогын бичиг баримтыг боловсруулан баталсан бөгөөд олон улсын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 40 гаруй жил ажилласан туршлагатай зөвлөх дэмжлэг үзүүлсэн юм. Үүний дагуу Голомт банкны эрсдэлийн удирдлагын метриксүүд шинэчлэгдэн, олон улсын хамгийн сүүлийн үеийн чиг хандлагад нийцэх бичиг баримттай болсон.

Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны үйл ажиллагаанд дааж болох эрсдэлийн хэмжээний дээд хязгаарыг тогтоож ТУЗ-өөр батлуулж ажилладаг. Энэхүү батлагдсан эрсдэлийн хязгаарлалтын түвшинд Гүйцэтгэх удирдлагаас эрсдэл өгөөжийн харьцааг зөв удирдаж байгаа эсэхийг тогтмол хянаж байна. Мөн гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалах эрсдэлийн төлөв байдлыг харгалзан үзэж, эрсдэлийн лимитийг улирал бүр эргэцүүлэн шинэчилж, стратеги бодлогоор хангадаг.

2016 онд тус хороо нь нийт 7 удаа хуралдаж, 24 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо (ЗЁЦУНДХ) нь банкны хүний нөөцийн бодлого, урамшууллын системийг боловсруулахаас гадна ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагын гол гишүүд зэрэг банкны удирдлагын чухал албан тушаалтнуудын томилгоонд оролцдог. Мөн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах ажлууд өрнүүлэхээс гадна ёс зүйн хэм хэмжээг зохистой түвшинд тодорхойлж, ТУЗ-д зөвлөн ажилладаг хороо болно.

Тайлант хугацаанд тус хороо нь Голомт банкны Гүйцэтгэх захирлын болон Аудит хариуцсан захирлын томилгоог амжилттай хэрэгжүүлж, банкны залгамж халааны бодлогыг боловсронгуй болгох тал дээр анхаарч ажиллалаа.

2016 онд тус хороо нь нийт 8 удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

Удирдлагын баг



Ө. Ганзориг
Гүйцэтгэх захирал



Г. Ганболд
Ерөнхийлөгч



Т. Нямсүрэн
Гүйцэтгэх захирлын орлогч
/Зээл хариуцсан/



Бравенец Томаш
Гүйцэтгэх захирлын орлогч
/Санхүү, нөөцийн удирдлага хариуцсан/



Н. Цэрэндаваа
Гүйцэтгэх захирлын орлогч
/Мэдээлэл технологи хариуцсан/



Ж. Сэлэнгэ
Гүйцэтгэх захирлын орлогч
/Үйл ажиллагаа хариуцсан/



А. Энхбаяр

Эрсдэлийн удирдлагын газрын захирал



Б. Баяртбилэг

Зээлийн газрын захирал



М. Чимэгмөнх

Санхүүгийн удирдлагын газрын захирал



Б. Энхтуяа

Бизнес хөгжлийн газрын захирал



Ч. Даваадаш

Харилцагчийн үйлчилгээний газрын захирал



У. Хосжаргал

Сувгийн удирдлагын газрын захирал



Д. Бадрал

Байгууллагын банкны газрын захирал



М. Сайнбилэг


Мэдээллийн технологийн газрын захирал




Ё. Пүрэвбат

Бүртгэл тооцооны газрын захирал

Голомт банкны бүтэц, зохион байгуулалт





Монгол Улсын 2016 оны эдийн засгийн тойм


Монгол Улсын эдийн засгийн орчин

2016 онд Монгол Улсын эдийн засаг 1 хувиар өслөө

2016 онд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байсан хэдий ч сүүлийн улиралд сэргэж эхэлсэн. Эдийн засгийн өсөлт 2016 оны эцэст 1 хувьтай, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 23,9 их наяд төгрөгөөр хэмжигдэв.


НДНБ

(их наяд ₮)




БДНБ өсөлт

(хувиар)




Ажилгүйдлийн түвшин

(хувиар)




Инфляци

(хувиар)




M2 мөнгөний нийлүүлэлт

(их наяд ₮)




M2 мөнгөний жилийн өсөлт

(хувиар)




Гадаад худалдааны тэнцэл

(сая ам.долл)



Төлбөрийн тэнцэл

(сая ам.долл)



Сүүлийн улирлын нөлөөллийг эс тооцвол хоёр, гуравдугаар улиралд сөрөг утга үзүүлж, албан ёсоор хямралын үетэй нүүр тулсан. Энэ үед эдийн засгийн голлох салбар болох барилга, боловсруулах

1 Улирлын нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 улирлын гулсах нийлбэр
2 Оны эхний хуримтлуулан тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлт
3 Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт

2016 онд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байсан хэдий ч сүүлийн улиралд сэргэж эхэлсэн. Эдийн засгийн өсөлт 2016 оны эцэст 1 хувьтай, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 23,9 их наяд төгрөгөөр хэмжигдэв.

Үйлдвэрлэл болон худалдааны салбарын бууралт хамгийн өндөр байсан. Түүнчлэн 2016 оны нэгдүгээр улиралд ажилгүйдэл 11.6 хувьд хүрч, 2010 оноос хойшхи хамгийн өндөр цэгт хүрсэн юм. Мөн 8-10-р сард өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ буурч, дефляци болсон нь хямралын шинж бий болсныг илтгэж байв.


Гэвч оны эцэст хямралын шинж тэмдгүүд аажмаар арилж, дөрөвдүгээр улиралд 14.7 хувийн өсөлтийг Монголын эдийн засаг үзүүлээ. Энэ нь суурь эдийн засаг сайжирсан гэсэн үг биш ч эерэг дохио юм. Дөрөвдүгээр улирлын өсөлтийг бий болгоход хөдөө аж ахуй, уул уурхай, тээврийн салбар голлох нөлөөллийг үзүүлэв. Мөн 2016 оны төгсгөлд хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт ч эргэн инфляцийн түвшинд орж ирсэн нь эерэг үзүүлэлт байв.

Улсын төсвийн алдагдал түүхэн дээд хэмжээнд хүрэв


Улсын төсөв 2016 онд 3,67 их наяд төгрөгийн алдагдалтай байсан нь түүхэн дээд хэмжээнд хүрсэн үзүүлэлт юм. Алдагдлын хэмжээг ДНБ-тэй харьцуулбал 15.4 хувьтай тэнцэж байна.

Төсвийн орлого сүүлийн 4 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой хадгалагдсан хэдий ч төсвийн зардал 2016 онд их хэмжээгээр өссөн. Үүнд урсгал зардал өмнөх жилээс 17 хувь, хөрөнгийн зардал 72 хувиар тус тус өслөө.

Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт



БДНБ-ий өсөлт, Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ (2010 оны үнээр)




Мөн тус онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилготой дотоодын засгийн газрын үнэт цаасны өгөөжийг өсгөж, 2,61 их наяд төгрөгийн үнэт цаас санал болгосон. Тус үнэт цаасны дийлэнх нь богино хугацаанд зарлагдав.

Гадаад өрийн асуудал хүндрэв


Манай улсын өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд их хэмжээгээр өсөж байна. 2010 оны эцэст гадаад өр, жилийн экспортын орлогын 175 хувь, ДНБ-ий 77 хувьтай тэнцэж байсан бол 2016 оны эцэс гэхэд жилийн экспортын орлогын 494 хувь, ДНБ-ий 248 хувьтай тэнцүү байсан юм.

Гадаад өр 2016 онд 2,6 тэрбум ам.доллараар өсч, 24,3 тэрбум ам.долларт хүрлээ. Үүнтэй холбогдуулан 2016 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын үнэлгээний байгууллагууд удаа дараа буулгасан. Ийнхүү оны эцсийн байдлаар улсын урт хугацааны зээлжих зэрэглэл В- (S&P), Саа1 (Moody's), В- (Fitch) гэсэн үнэлгээтэй байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцэл
(Их наяд төгрөг)



Нийт гадаад өр
(ДНБ болон экспортод харьцуулснаар)



Уул уурхайн салбараар дамжин гадаад худалдааны тэнцэл сайжрав

Монгол Улсын эдийн засгийн 20 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Уул уурхайн салбарын өсөлт сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 11.7 хувь өссөн.

Харин 2016 оны 3-р улиралд өсөлт 0.1 хувьд хүрч, салбарын удаашрал ажиглагдаж эхэлсэн. Гэвч 2016 оны 6-р сараас хойш 5 сарын дотор нүүрсний үнэ олон улсын зах зээлд 2 дахин өсч, улмаар 4-р улиралд уул уурхайн салбарт өндөр өсөлтийг бий болгосон.

Уул уурхайн салбар нь Монгол Улсын экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг онцлогтой. 2016 оны эцсийн байдлаар экспортын бүтцэд өөрчлөлт орж, үнийн дүнгээр экспортын 31 хувийг нүүрс дангаар, 28 хувийг алт, 17 хувийг зэс бүрдүүлсэн байна.

Биет хэмжээний хувьд нүүрсний экспорт жилийн 78 хувиар өссөн нь экспортын бүтцийг ийнхүү өөрчиллөө. Оны эцсийн байдлаар ам.долларын ханш төгрөгийн эсрэг жилийн өмнөхөөс 25 хувиар чангарсан үзүүлэлттэй байгаа нь импортыг бууруулсан. Эдгээр өөрчлөлтийн улмаас цэвэр экспорт оны эцэст 1,56 тэрбум ам.долларт хүрч, түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

Төлбөрийн тэнцлийн хувьд 2016 онд 2012 оноос хойш хамгийн бага алдагдалтай гарч, валютын ханшийн эрсдэл цаашид буурах суурь нөхцөлийг бүрдүүлээд байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2013 оны үетэй ижил түвшинд хүрлээ

2016 онд мөнгөний нийлүүлэлт 12,1 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 23 хувиар өссөн үзүүлэлт юм. Тус онд бодлогын хүүг 3 удаа өөрчилсөн.


5-р сард бодлогын хүүг 12 хувиас 10.5 хувь болгон бууруулсан нөлөөлөл нь 6-р сард мөнгөний нийлүүлэлт сарын 5 хувиар өссөнөөр илэрсэн. Үүний дараагаар валютын ханшийн чангаралтыг намдаах зорилготойгоор бодлогын хүүг 15 хувь болгосон.

Үр дүнд нь 8 болон 10-р сард мөнгөний нийлүүлэлт өсөлтгүй гарсан. Мөн валютын ханшийн дарамт буурсан гэж үзэн 12-р сард бодлогын хүүг 14 хувь болгосон нь жилийн 3 дахь өөрчлөлт болсон юм. Жилийн явцад бодлогын хүү харьцангуй өндөр байснаас үл хамааран 2016 оны мөнгөний нийлүүлэлт өмнөх 2 жилийн өсөлтөөс өндөр байлаа.

Бүтцийн хувьд төгрөгийн хадгаламж 47.8 хувь, гадаад валютын хадгаламж 23 хувь, төгрөгийн харилцах 12.6 хувь, гадаад валютын харилцах 11.9 хувь, банкнаас гадуурх мөнгө 4.7 хувийг тус тус эзэлж байна. 2016 онд төгрөгийн хадгаламжийн M2 мөнгөнд эзлэх хувь буурч, валютын харилцах, хадгаламж аль нь өссөн.


Гадаад худалдааны тэнцэл

(Тэрбум ам.доллар)




● Экспорт ● Импорт — Цэвэр экспорт /баруун тэнхлэг/

Хадгаламжийн хүү



— Төгрөгийн хадгаламжийн хүү
— Валютын хадгаламжийн хүү (баруун тэнхлэг)

M2 мөнгөний задаргаа (Хувиар)



● Банкнаас гадуурх мөнгө ● Гадаад валютын харилцах данс
● Төгрөгийн харилцах данс ● Гадаад валютын хадгаламж
● Төгрөгийн хадгаламж

Энэ нь гадаад валютын ханш төгрөгийн эсрэг эрчимтэй чангарсантай холбоотой. Энэхүү бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 8-р сараас төгрөгийн хадгаламжийн хүү өсч, валютын хадгаламжийн хүү буурч эхэлсэн юм. Үр дүнд нь нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх валютын хадгаламж 21 хувь болж буурсан. Гэвч 11-р сараас эхлэн төгрөгийн хадгаламжийн хүү буурч, улмаар валютын хадгаламж эргээд 23 хувьд хүрсэн юм.

Банкны системийн 2016 оны гүйцэтгэл

Банкны салбарын үзүүлэлт өсөж байна


2016 оны эцсийн байдлаар нийт 14 банк идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт активийн хэмжээ 25,3 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь өмнөх оноос 18 хувиар өссөн үзүүлэлт юм. 2013 оноос хойш банкуудын активийн өсөлтийн хувь саарсан хэдий ч 2016 онд эргэн өсөх хандлагатай байна. Өмнөх оны эцэст M2 мөнгө жилийн 6 хувиар буурч байсан бол 2016 онд 20 хувиар өсөөд байна. Энэ нь сүүлийн 3 жилийн хугацааны хамгийн өндөр өсөлт юм.

Банкны системийн эх үүсвэрийн 34 хувийг хадгаламж, 21 хувийг гадаад пассив, 12 хувийг харилцах данс, 12 хувийг өөрийн хөрөнгө, 22 хувийг бусад эх үүсвэр тус тус эзэлж байна. 2016 онд хамгийн өндөр өсөлтийг гадаад пассив үзүүлсэн нь банкууд гадаадаас эх үүсвэр татах нь ихэссэнийг илтгэж байна. Тус онд хадгаламж болон харилцах дансны үлдэгдлийн өсөлт 16 хувь, 34 хувь тус тус байв.

Банкуудын нийт актив
(Их наяд төгрөг)




Банкны эх үүсвэрийн задаргаа
(Их наяд төгрөг)




2016 онд өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 21 хувиар өсч, 2,9 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс тухайн жилийн ашиг нь 6 хувийг бүрдүүлж байгаа юм. Мөнгөн дүнгээр авч үзвэл банкууд 176,5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь сүүлийн 6 жилийн хамгийн бага үзүүлэлт боллоо.

Банкуудын актив хөрөнгийн 49 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, 14 хувийг засгийн газрын үнэт цаас, 8 хувийг гадаад актив, 29 хувийг бусад хөрөнгүүд эзэлж байна. Өмнөх оноос зээлийн өрийн үлдэгдэл 6 хувиар, засгийн газрын үнэт цаас 37 хувиар, гадаад актив 111 хувиар тус тус өслөө. Гадаад актив болон гадаад пассив аль аль нь хамгийн өндөр өсөлтийг үзүүлж буй нь Монголын банкууд гадаад зах зээлээс илүү их хамааралтай болж буйг илтгэж байна.


Тухайн жилийн ашиг, алдагдал
(Тэрбум төгрөг)



Банкны активийн задаргаа
(Их наяд төгрөг)



Чанаргүй зээлийн хувь (Эдийн засгийн салбараар)



Нийт зээлийн 32.6 хувийг ипотекийн зээл, 14.1 хувийг худалдааны салбар, 10.8 хувийг барилгын салбар, 10.5 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 6.2 хувийг уул, уурхайн салбар, үлдсэн хувийг бусад салбарт тус тус олгосон байна. Эдгээр салбаруудын чанаргүй зээлийг салган харвал уул уурхайн салбарт олгосон зээлийн 29.8 хувь нь чанаргүйдсэн байна. Харин ипотекийн зээлийн чанаргүйдэл 1.4 хувьтай тэнцэж байгаа юм. 2016 онд системийн хэмжээнд нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.5 хувь байлаа.

Голомт банкны 2016 оны санхүүгийн үзүүлэлт

Санхүүгийн үр дүн


Он дамнасан эдийн засгийн таагүй нөхцөл байдалд банк харилцагчдынхаа итгэлийг хүлээн харилцах хадгаламжийн хэмжээгээ 35 хувиар өсгөн, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэн, санхүүгийн хүчирхэг үзүүлэлтүүдээ хадгалсан амжилттай жил болж өнгөрлөө.

Балансын үзүүлэлт


НИЙТ АКТИВ

Голомт банкны нийт актив 22 хувиар өсч 4,7 их наяд төгрөгт хүрсэн. Банкны системд эзлэх хувь өсч 18.5 хувь боллоо.

Нийт актив
(тэрбум төгрөг)



Харилцах, хадгаламж
(тэрбум төгрөг)



ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ


Харилцах, хадгаламж 35 хувь өссөн нь сүүлийн таван жилд байгаагүй өсөлтийг үзүүлж, 2,8 их наяд төгрөгт хүрсэн. Банкны системд эзлэх хувь өсч 24.1 хувь боллоо. Нийт өсөлтийн 67 хувь нь иргэдийн эх үүсвэр, 33 хувь нь байгууллагын эх үүсвэр эзэлж байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ


Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр Монголбанкны шаардлагыг хангаж ажилласан.

Он дамнасан эдийн засгийн таагүй нөхцөл байдалд банк харилцагчдынхаа итгэлийг хүлээн харилцах хадгаламжийн хэмжээгээ 35 хувиар өсгөн, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэн, санхүүгийн хүчирхэг үзүүлэлтүүдээ хадгалсан амжилттай жил болж өнгөрлөө.

Нийт өөрийн хөрөнгө
(тэрбум төгрөг)




Өөрийн хөрөнгийн хүрэлцээ > 14%
(МБ-ны шаардлага 2013 онд 13%-14% болж нэмэгдсэн)




ЦЭВЭР ЗЭЭЛ

Төлбөрийн чадвартаа онцгой анхаарч, зээлийн багцаа өнгөрсөн 2015 оны түвшинд барьж ажиллалаа.

Цэвэр зээл
(тэрбум төгрөг)



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа > 25%



Ашигт ажиллагаа


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ

Эх үүсвэрийн огцом өсөлттэй холбоотой цэвэр хүүгийн орлого өнгөрсөн оноос буурсан боловч банк хүүгийн бус орлогоо 8 хувиар өсгөж 63 тэрбум төгрөгт хүргэсэн. Сүүлийн хоёр жилд зардлын хяналтыг сайжруулж үйл ажиллагааны зардлын өсөлтийг сааруулсан.

Үйл ажиллагааны орлого
(тэрбум төгрөг)




Үйл ажиллагааны зардал
(тэрбум төгрөг)




АШИГ

Банк сүүлийн хоёр жилд зээлийн эрсдэлээс хамгаалж их хэмжээний сан байгуулсан нь ашигт ажиллагаанд нөлөөлсөн.

Эрсдэлийн сангийн зардал
(тэрбум төгрөг)



Татварын өмнөх ашиг
(тэрбум төгрөг)



ГОЛОМТ БАНК
5 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

| Үзүүлэлтүүд (сая.төг) | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|--|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг) | | | | | |
| Нийт актив | 2,526,945 | 3,749,806 | 4,053,153 | 3,804,842 | 4,658,343 |
| Нийт харилцагчийн харилцах, хадгаламж | 2,056,728 | 2,161,779 | 2,232,270 | 2,079,801 | 2,803,328 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 112,840 | 1,032,319 | 1,011,499 | 1,014,935 | 1,195,870 |
| Цэвэр зээл | 1,427,852 | 2,199,228 | 2,461,920 | 2,013,611 | 2,034,860 |
| Нийт өөрийн хөрөнгө | 221,501 | 329,740 | 391,825 | 417,909 | 441,489 |
| Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг) | | | | | |
| Хүүгийн орлого | 200,245 | 290,945 | 338,366 | 314,830 | 331,900 |
| Хүүгийн зардал | (143,127) | (184,701) | (209,312) | (213,295) | (246,416) |
| Цэвэр хүүгийн орлого | 57,118 | 106,245 | 129,054 | 101,534 | 85,484 |
| Цэвэр хүүгийн бус орлого | 31,932 | 59,774 | 36,197 | 58,454 | 63,200 |
| Үйл ажиллагааны орлого | 89,050 | 166,019 | 165,251 | 159,988 | 148,684 |
| Үйл ажиллагааны зардал | (45,419) | (67,116) | (73,068) | (75,362) | (77,251) |
| Үйл ажиллагааны ашиг | 43,631 | 98,903 | 92,182 | 84,626 | 71,433 |
| Эрсдэлийн сангийн зардал | (10,790) | (27,940) | (27,900) | (51,900) | (58,686) |
| Татварын өмнөх ашиг | 32,841 | 70,963 | 64,283 | 32,726 | 12,746 |
| Татварын зардал | (6,694) | (14,106) | (14,455) | (6,742) | (7,473) |
| Татварын дараах ашиг | 26,146 | 56,857 | 49,828 | 25,985 | 5,274 |
| Санхүүгийн бүтцийн харьцаанууд | | | | | |
| Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%) | 81.4% | 57.7% | 55.1% | 54.7% | 60.2% |
| Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл) / Нийт актив (%) | 7.4% | 6.6% | 7.2% | 8.3% | 6.5% |
| Цэвэр зээл / Нийт актив (%) | 56.5% | 58.6% | 60.7% | 52.9% | 43.7% |
| Хөшүүргийн харьцаа (Нийт пассив / Нийт Капитал) (дахин) | 10.4 | 10.4 | 9.3 | 8.1 | 9.6 |
| Ашигт ажиллагааны харьцаанууд | | | | | |
| Дундаж активын өгөөж (%) | 1.2% | 1.9% | 1.4% | 0.7% | 0.1% |
| Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%) | 15.1% | 26.8% | 19.1% | 8.7% | 1.7% |
| Цэвэр хүүгийн ахиуц (%) | 3.5% | 4.6% | 4.5% | 4.2% | 2.8% |
| Зардал, орлогын харьцаа (%) | 51.0% | 40.4% | 44.2% | 47.1% | 52.0% |
| Шалгуур үзүүлэлтүүд | | | | | |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >14% (МБ-ны шаардлага 2013 онд 13%-14% болж нэмэгдсэн) | 13.3% | 16.7% | 17.1% | 16.6% | 14.8% |
| Нэг зээлдэгчид олгосон зээлийн харьцаа <20% | 19.0% | 15.9% | 15.8% | 18.2% | 17.1% |
| Холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа <5% | 3.5% | 3.0% | 4.6% | 3.9% | 4.3% |
| Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа <20% | 9.5% | 8.2% | 15.8% | 17.0% | 15.8% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >25% | 41.1% | 43.3% | 38.2% | 38.1% | 44.8% |
| Үндсэн хөрөнгийн харьцаа <8% | 1.5% | 1.4% | 2.3% | 4.7% | 5.1% |

Голомт банкны амжилтын товчоон

Иргэдийн сегмент

Үндэсний хэмжээнд 45000 иргэн хуримтлах зуршилтай боллоо

Голомт банк 2015 оноос иргэдийн хуримтлуулах зуршлыг дэмжих, улс орны эдийн засгийг дархлаатай болгох зорилгоор Үндэсний хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2016 онд ч амжилттай үргэлжиллээ. Энэ хугацаанд нийт 45000 иргэн тус хөтөлбөрт нэгдэж, банк санхүүгийн салбарын хамгийн өндөр өгөөж болох 20 хувийн урамшууллыг авч эхэлсэн бөгөөд энэ хирээр үндэсний хуримтлалын түвшин нэмэгдэж байна.

Шинээр 2825 өрх орон сууцтай боллоо

Сайн сайхныг санхүүжүүлнэ уриатай Голомт банк нь 2002 оноос орон сууцны урт хугацаатай зээлийг иргэд харилцагчдадаа олгож эхэлсэн ууган, туршлагатай банкуудын нэг бөгөөд энэ хугацаанд нийт 28 мянга гаруй өрхийг орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлсэн байна.

2016 оны байдлаар нийт 28564 өрхөд орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлсэн байна



Хувийн банкны харилцагчдад зориулан Үл хөдлөх хөрөнгийн зөвлөх үйлчилгээг анх удаа нэвтрүүлсэн бөгөөд доорх үндсэн чиглэлийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөгөө өгч байна.

Үүнд:

- Улаанбаатар хотын орон сууцны зах зээл
- Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт
- Барилгын хөгжлийн шинэ тренд
- Түрээсийн зах зээл

Голомт банкнаас гаргасан Зэс кредит карт нь харилцагчдын талархалыг хүлээсэн төдийгүй дэлхийд алдартай Виза олон улсын байгууллагаас Оны шилдэг инновацитай бүтээгдэхүүн, МҮХАҮТ-аас 2016 оны Инноваци нэвтрүүлэгч энтрепренер шагналыг тус тус хүртсэн юм.

- Бүсчлэл зэрэг харилцагчдын ихээхэн сонирхдог сэдвийн хүрээнд судалгаа хийж харилцагчдад хүргэсэн. Мөн харилцагчдын хүсэлтийн дагуу үл хөдлөх хөрөнгийн зөвлөх үйлчилгээг үзүүлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Кредит карт эзэмшигчдийн тоо 135 хувиар нэмэгдэв

2016 онд Голомт банк нь American Express® Green card болон Зэс кредит картыг зах зээлд шинээр гаргаж, хэд хэдэн шинэлэг үйлчилгээг банкны системд давхар нэвтрүүлэв.

Үүнд:

- Кредит карт захиалах, хүлээн авах, холбогдох материалыг судлах, карт олгох зэрэг үйл ажиллагааг хялбарчилж, харилцагчийн хүсэлтийг www.zescard.com сайтаар хүлээн авдаг болсон.
- Зэс кредит картаар дамжуулан харилцагчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, сахилга батыг төлөвшүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Зэс кредит карт нь харилцагч өдөр тутам ашиглахад хамгийн энгийн ойлгомжтой байхуйц технологийн дэвшилд суурилсан ухлаадас бүхий өвөрмөц хийцтэй юм.

Харилцагч төвтөй банк байх зорилтын хүрээнд хийгдсэн тус ухлаадас нь харилцагч картаа хэтэвчнээсээ хялбархан сугалж авах боломжийг бүрдүүлж өгснөөс гадна ухлаадасны сумын дагуу картаа АТМ болон ПОС машинд хийнэ.

Дээрх ажлуудын үр дүнд кредит карт эзэмшигчдийн тоо 135 хувиар, кредит картаар хийгдсэн гүйлгээний тоо 165 хувиар өссөн байна.

Голомт банкнаас гаргасан Зэс кредит карт нь харилцагчдын талархалыг хүлээсэн төдийгүй дэлхийд алдартай Виза олон улсын байгууллагаас Оны шилдэг инновацитай бүтээгдэхүүн, МҮХАҮТ-аас 2016 оны Инноваци нэвтрүүлэгч энтрепренер шагналыг тус тус хүртсэн юм.

И-банк, Смарт, Мобайл банкны үйлчилгээг шинэчилээ

Банкны системд цахим банкаар хийгдэж буй төлбөр тооцоонд тэргүүлэгч байр сууриа хадгалах, харилцагчдын хүсэл зорилгод нийцсэн, орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурласан цахим сувгийн шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхэд чиглэн ажиллалаа. Тухайлбал Смарт банкны 4.0 хувилбарыг шинэчлэн зах зээлд нэвтрүүллээ.

Ингэснээр Голомт банкны данс хооронд хийгдэх гүйлгээний хурдыг 93 хувиар өсгөж сайжрууллаа.



Шинэчлэгдсэн Смарт банк 4.0

Энэ нь өмнөх хувилбараас харилцагчийн хийх үйлдлийг 3 дахин багасгасан, дэвшилтэд 3D touch-той болсон юм. Мөн харилцагч аппликэйшнийг нээхээс өмнө ямар үйлдэл хийхээ сонгох боломжийг нэвтрүүлсэн.

Слайд гүйлгээ буюу харилцагч данс хооронд хялбараар гүйлгээ хийх, банк харилцагчийн өмнөөс гүйлгээний тохирох утгыг бөглөх, тогтмол гүйлгээ хийдэг дансыг дахин бичих шаардлагагүйгээр дансны дэвтрээс сонгох, шуурхай гүйлгээ хийх давуу талтай болсон юм.

Мөн харилцагч картаа гээгдүүлсэн тохиолдолд интернэт банкаар дамжуулан блок хийх, гүйлгээгээ лавлан харах, баталгаажуулах боломжуудыг нэвтрүүллээ. Ингэснээр интернэт банкаар Голомт банкны данс хооронд хийгдэх гүйлгээний хурдыг 93 хувиар өсгөж сайжруулаад байна.

Мобайл банк 2.0 шинэ боломжийг нээж байна

Мобикомын сүлжээний хэрэглэгчдэд Монголд анх удаа USSD (Unstructured Supplementary Service Data) протокол ашиглан Мобайл банк 2.0 үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн бөгөөд энэхүү үйлчилгээгээр дамжуулан цаг алдалгүй гар утсаараа дамжуулан дансны мэдээлэл, үлдэгдэл шалгах, Голомт банкны данс хооронд болон банк хооронд гүйлгээ хийх, Мобикомын ярианы төлбөр, дата, нэгж худалдан авах, кредит картын төлбөр төлөх боломжуудыг бий болголоо.

Банкны Core system–д хийгдсэн шинэчлэл

Банкны үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, банкны үндсэн бүртгэлийн системийн үйлчилгээний хурдыг нэмэх, найдвартай төлбөр тооцоог гүйцэтгэх, олон улсын шаардлагад нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Нууцлал аюулгүй байдал

Олон улсын стандартад нийцсэн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын төв байгуулах төслийг эхлүүллээ.

Дата анализ

Банк санхүүгийн салбарт анх удаа өгөгдлийн ахисан түвшний анализийн мэргэжлийн нэгж байгуулж, банкны бизнес, харилцагчийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажиллаж эхэллээ.



Автодилерийн үйлчилгээг нэвтрүүлээ

Голомт банк Монгол Улсад анх удаа Автодилерийн үйлчилгээг нэвтрүүлээ. Тус үйлчилгээний гол онцлог нь иргэн өөрийн унаж буй машинаа урьдчилгаа болгох, баталгаат автомашинаар солих, зээлийг газар дээр нь шийдэх зэрэг боломжийг харилцагчдад олгож буй харилцагч төвтэй үйлчилгээ юм.

Даатгалын зуучлалын үйл ажиллагаа

Голомт банк 2016 онд даатгалын зуучлалын үйл ажиллагаагаа өргөжүүллээ. Ажилтнуудаа сургалтанд хамруулж, болзошгүй эрсдэлээс сэргийлэх заавар, зөвлөмжийг нийт харилцагчдадаа тогтмол хүргэсэн.

Мөн Монгол Улсад анх удаа харилцагч хэрэгцээндээ тохируулан даатгуулах боломжтой Тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн нь харилцагчдын талархалыг хүлээгээд байна.

Банкны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг стандартчилав

Голомт банк 2016 онд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн модельтой болсон. Энэ нь аливаа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх ажлын дэс дараалал, заавал хийх, тусгах ажлуудыг нэг бүрчлэн зааж, стандарт тогтоож өгснөөрөө онцлогтой. Уг моделийн дагуу хөгжүүлж, сайжруулсан бүтээгдэхүүний гүйцэтгэлийг 80 хувиас илүү байлгахар төлөвлөн ажиллаж байна.

Бусад үйл ажиллагаа

- Дижитал оффис төслийн хүрээнд интранет болон асуудал шийдвэрлэх системийг шинэчлэн нэвтрүүлээ.
- Үндэсний хуримтлалын хөтөлбөрийн хүрээнд www.hurimtlal.com вэбийг нэвтрүүлээ.
- Голомт банкны үндсэн вэб www.golombank.com-ыг шинэчилж нэвтрүүлээ.
- Гадаад төлбөр тооцооны системийг шинэчилж SWIFT Alliance Access хувилбарыг нэвтрүүлээ.

Харилцагч төвтэй банкны үйлчилгээг хөгжүүлж байна

Харилцагч төвтэй бизнес моделийн хүрээнд Салбарын бизнес удирдлагын хэлтсийг Борлуулалтын хэлтэс болгож бүтэц, чиг үүргийг нь өөрчиллөө.

Тус хэлтэс нь утсан, агентын борлуулалтын үйлчилгээг шинээр нэвтрүүлснээр харилцагчдад хүрч үйлчлэх, хэрэгцээ шаардлагад нь тохирсон бүтээгдэхүүнийг цаг алдалгүй санал болгох, олгох ажил эрчимжлээ.



Зээлийн төв бизнес төвийн засварыг олон улсын онгоцны буудлын стандарт, аэро-динамикийн дагуу засаж тохижуулж, бусад салбар тооцооны төвүүдэд байгууллага иргэд, вип үйлчилгээний төрөлжсөн танхимыг нэмэгдүүллээ.



Харилцагчдадаа хүрч үйлчлэх, олон улсын үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх зорилгоор дэлхийн брэнд Шангри-Ла худалдааны төвд салбар тооцооны төвөө нээлээ.

Гадаад харилцагчдадаа хүрч үйлчлэх зорилгоор Хятад, Япон, Солонгос, Орос, Англи хэлээр 8 салбарт үйлчилгээ үзүүлж, бүтээгдэхүүний танилцуулга, мэдээллээ тухайн хэлээр хүргэж байна. Голомт банк нь сар бүрийн борлуулалт, үйл ажиллагааны стандартыг тогтоосноор харилцагчдад үйлчлэх хурд нэмэгдэж байна.

Мөн 2016 онд орон сууц, бизнесийн зээл авах, хөрөнгө оруулалтын зах зээлд эрсдэлгүй оролцоход нь харилцагчдадаа туслах үүднээс мэргэжлийн зөвлөх үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг сайжруулах, эрсдэлээс сэргийлэх, олон улсын түвшинд хүрсэн орлогыг бүрдүүлэх зэрэг уриа бүхий 23 удаагийн сургалтыг 1000 орчим ажилтанд хийснээс гадна баруун бүсийн аймгийн Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан чуулга уулзалтыг зохион байгууллаа.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврийн, оюутны, авто машины зээл авах үйлчилгээг амжилттай нэвтрүүлснээс гадна Монгол Улсын Засгийн газраас олгосон Эрдэнэс таван толгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны 30 хувийг худалдан авч мөнгөжүүлэх ажлыг бүх салбар тооцооны төвөөрөө явууллаа.

2016 онд салбарын биет эрсдэл болоод цахим халдлагаас сэргийлж харилцагчийн мэдээллийг чандлан нууцалж, кибер хамгаалалтыг сайжруулснаар ATM, CDM, ПОС-ын үйлчилгээнд эрсдэлгүй ажиллав.

Монгол Улсад анх удаа Бизнес процесс ре-инженеринг /BPR/ хэрэгжүүлээ

Голомт банк 2016 онд Харилцагч төвтэй бизнес загварыг бий болгох зорилгоор олон улсын тэргүүн туршлагаудыг судалж, үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэв. Банкны зээл, төлбөр тооцоо, кредит карт, цахим бүтээгдэхүүн үйлчилгээ болон салбарын дотоод үйл ажиллагааг сайжруулснаар харилцагчийн цаг хугацааг хэмнэх, зардлыг бууруулах, санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн юм.

Дэлхийн жишиг Монголын банк болох зорилтын хүрээнд Голомт банкинд хэрэгжүүлсэн Бизнес процесс ре-инженерингээр дамжуулан банкны 250 гаруй гүйцэтгэлд нарийн шинжилгээ, дүгнэлт хийсний үр дүнд харилцагчийн үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэх, зардлыг бууруулах, ажлын урсгалыг конвейрийн системд оруулах, салбарын бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, технологийн шинэлэг шийдлийг нэвтрүүлэхэд чухал суурь нь болсон юм.

Харилцагч төвтэй бизнес загварыг бий болгосноор

- **Харилцагчдад:** Банкны үйлчилгээ харилцагчдад илүү энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй болсон. Мөн харилцагч салбар харгалзахгүйгээр үйлчлүүлдэг болсноор үйлчилгээ авах хурд нь 27 хувиар өссөн.
- **Ажилтанд:** Ажилтны ажлын чиг үүргийг дахин төрөлжүүлж, үйл ажиллагааны явцыг хөнгөвчилснөөр харилцагчдад үйлчлэх, борлуулалт хийх боломж улам нэмэгдээд байна. Ажлын гүйцэтгэлийн стандарт нормуудыг шинэчилж, цалингийн системтэй уялдуулсан нь ажилтны сэтгэл ханамж 30 хувиар өсөхөд нөлөөлсөн.
- **Банкинд:** Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтыг хийж, эрсдэлийг бууруулан, тасралтгүй, найдвартай, хэвийн үйл ажиллагааны түвшинг нэмэгдүүлсний үр дүнд банкны ажилтнуудын бүтээмж 30 хувиар өсч, банкны ашигт ажиллагаа сайжрах боломж бүрдсэн.

Төвлөрсөн Shared Back Office байгуулагдлаа

Харилцагч төвтэй бизнес загварын төслийн хүрээнд банкны хэмжээнд төвлөрсөн Shared back office-ийг байгууллаа. Ингэснээр банкны салбар, тооцооны төвүүдэд харилцагчтай харьцахгүйгээр хийгдэх боломжтой, дахин давтагддаг бүхий л ажлуудыг нэг дор төвлөрүүлсэн. Энэ нь салбарын ажилтнуудад харилцагчдадаа илүү их цагийг зарцуулах, хүрч үйлчлэх боломжийг олгож байна.

Түүнчлэн Shared back office-т төвлөрсөн ажлуудыг төрөлжүүлж, нэгдсэн стандартын дагуу гүйцэтгэснээр үйл ажиллагааны эрсдэл буураад зогсохгүй гүйцэтгэл өндөр байгаа юм. Shared back office байгуулагдахтай зэрэгцэн харилцагчийн хувийн хэргийг цахимжуулах DMS–Document Management System буюу OMNIDOCs програмыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Байгууллагын сегмент

Байгууллагын банкны үйл ажиллагаа

Голомт банк нь тэргүүлэгч корпорейт банкны хувьд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн томоохон корпорациудад байгууллагын банкны цогц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэж ажиллалаа.

Банкны байгууллагын бизнесийн үйлчилгээг дэлхийн жишигт нийцүүлэх, мэргэшсэн түвшинд хүргэх зорилготойгоор корпорейт харилцагч бүрийн бизнесийн мөчлөг, онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн Tailor-made шийдлийг хүргэсний үр дүнд банкны корпорейт зах зээлд эзлэх байр суурь улам батжив.

Нийт корпорейт эх үүсвэрийг өмнөх оноос 34 хувь, корпорейт зээлийн багц 5 хувь, корпорейт баталгааны багцыг 20 хувиар өсгөсөн амжилт үзүүлсэн юм.

2016 онд харилцагч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтыг дэмжих, мөнгөн урсгалын менежментийг хөгжүүлэхийн тулд уламжлалт зээлийн санхүүжилтээс гадна гадаад худалдааны санхүүжилт, бүх төрлийн баталгаа, авлага санхүүжилт, төслийн санхүүжилт болон цахим үйлчилгээг өргөжүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэсэн бөгөөд И-КҮБ, Захиалгат шилжүүлэг, Cash pooling, Байгууллагын дебит карт, Корпорейт овердрафт, Дата майнинг зэрэг шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг байгууллага бүрийн онцлогт нийцүүлэн хүргэж ажиллав.



Уул уурхай, дэд бүтцийн салбарт

Голомт банк нь Монголбанк, Уул уурхайн яам, Сангийн яам, Монголын арилжааны банкуудын хамтран хэрэгжүүлсэн Алт хөтөлбөрийн цорын ганц хэрэгжүүлэгч банкаар ажиллалаа.

Мөн нүүрсний салбарын экспортын 75 хувийг тус банкны харилцагчид бүрдүүлжээ. Оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт, барилга байгууламжийн гүйцэтгэгч үндэсний болон гадаадын аж ахуйн нэгжүүдэд банкны цогц үйлчилгээг үзүүллээ.

Японы хамгийн том худалдааны компани болох Марубени корпорацийг Монгол Улсад 18 жилийн дараа дахин хөрөнгө оруулалт хийж, уул уурхайн салбарт технологийн шинэчлэлийг нэвтрүүлэхэд нь хамтран ажиллалаа.

Монгол зэсний дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт үйлдвэрийн хяналтын системийг сайжруулах Питрам системийг нэвтрүүлэх төсөлд санхүүжилт олгов. Ингэснээр харилцагчийн үйл ажиллагааны зардлыг 15 хувь бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлж чадлаа. 147км-ийн урт бүхий өндөр хүчдэлийн шугамын төслийг санхүүжүүлснээр зүүн бүсийн эрчим хүчний найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулаад байна.

Цогтцэций суманд баригдаж буй Оюу толгой, Таван толгой, Ухаа худаг, Цагаан суварга зэрэг томоохон уурхайг цахилгаанаар хангах Монгол Улсын хоёр дахь 50 мвт хүчин чадал бүхий салхин цахилгаан станцын ерөнхий, туслан гүйцэтгэгч үндэсний болон гадаадын компаниудад банкны төлбөр тооцоо, мөнгөн урсгалын менежментийн шийдэл, худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээг үзүүлж, сэргээгдэх эрчим хүчний салбарыг дэмжин ажиллалаа.

Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөг 30 гаруй хувиар давуулан биелүүлэхэд хувь нэмрээ оруулснаас гадна Монгол Улсад анх удаа шинэ үеийн турбопроп ATR72 маркийн агаарын хөлгийг хүлээн авахад корпорейт банкны шийдлийг санал болгож, агаарын тээврийн салбарын парк шинэчлэлтийг ахиулж ажиллалаа.

Барилгын салбарт

Монгол Улсын цементийн үйлдвэрлэлийг жилд 30 хувиар нэмэгдүүлэх хүчин чадал бүхий Хөх цавын Цементийн үйлдвэрийн төсөл болон Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын барилгын ажлын гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн цогц үйлчилгээг үзүүллээ. Засгийн газрын Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд батлагдсан 3000 айлын цогцолбор орон сууцны барилгын төслийн санхүүжилт болон агент банкны үйлчилгээг нэвтрүүлэв.

Төрийн захиргаа удирдлагын байгууллага, их дээд сургуулийн багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1800 гаруй айлын орон сууцны санхүүжилтийг амжилттай шийдвэрлэлээ.

Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт

Голомт банк нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах салбаруудыг дэмжих зорилгоор ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зээлийн болон гадаад худалдааны санхүүжилт, мөнгөн урсгалын менежментийн үйлчилгээ үзүүллээ. Ингэснээр өнгөрөгч онд нийт 160 гаруй тэрбум төгрөгийн эцсийн бүтээгдэхүүнийг БНХАУ, Итали, Шотланд, Англи зэрэг улс руу экспортлоод байна. Үндэсний худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчдэд зориулан хүнсний зориулалтын зоорь агуулахын төсөл, олон улсын сүлжээ дэлгүүр, дэвшилтэт технологийн кино үзвэрийн үйлчилгээ зэрэг төслүүдэд хамтарч ажиллалаа.

Голомт банкны харилцагчдын амжилтаас



Дархан нэхий ХК

БНБАУ-ын техник, эдийн засгийн тусламжтайгаар байгуулагдсан тус компани нь нэхий дээл, гутал болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ алдартай. Голомт банктай хамтарсан хэд хэдэн удаагийн техник технологийн шинэчлэлийн хүрээнд боловсруулах үйлдвэрийн хүчин чадал нь нэмэгдэж, арьс ширний салбартаа тэргүүлэн ажиллаж байна.



Дашваанжил ХХК

38

Дашваанжил ХХК нь 20 гаруй жилийн турш Голомт банктай хамтран ажиллаж ирсэн бөгөөд ТоС-ийн бодлогыг хэрэгжүүлэгч шилдэг компани юм. Дашваанжил ХХК нь Голомт банкны санхүүжилтээр байгаль орчинд хор нөлөөгүй, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор орон нутаг болон Улаанбаатар хотод автомашин, ахуйн хийн баллон цэнэглэх станц байгуулах төслийг хэрэгжүүлж, шингэрүүлсэн хийн сүлжээг бүтээн байгуулж байна.



Ногоон сор ХХК

2009 онд үүсгэн байгуулагдсан Ногоон сор ХХК нь 2010 оноос эхлэн жимс жимсгэнэ, хүнсний нарийн ногоог жилийн дөрвөн улиралд дулаан хүлэмжинд тариалж, хэрэглэгчдэдээ байгалийн цэвэр экологийн бүтээгдэхүүнээ дээжлэн барьсаар байна.

Тус компани нь хэрэглэгчдийнхээ эрүүл мэндэд нэн тустай, амин дэмээр баялаг хүнсний ногоо, жимс жимсгэнийг тариалахдаа ямар ч химийн бордоо ашигладаггүйгээрээ онцлогтой.



Ноос ирээдүй ХХК

Монгол Улсад аж үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй Ноос ирээдүй компани нь бүтээгдэхүүнийхээ 30 хувийг дотоодын зах зээлд нийлүүлж, 70 хувийг экспортолж байна.

Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа

Өнгөрч буй 2016 онд түнш, харилцагч байгууллагуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлснээс гадна гадаад дотоод бодлого, чиглэлд өндөр дэвшилт гарч, цаашдын алсын хараагаа тодотгон ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам.долларын бондын хамтарсан менежерээр ажиллалаа

Голомт банк нь андеррайтерын үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсын Засгийн газраас олон улсын хөрөнгийн зах зээл, Сингапурын хөрөнгийн биржид гаргасан Mongol 2021, 500 сая ам.долларын бондын андеррайтерын багт хамтарсан менежер /Joint Lead Manager/-ээр олон улсын томоохон 4 банк, дотоод гадаадын нэр хүнд бүхий хуулийн фирмүүдтэй нягт хамтран ажиллаж, 2016 оны 4 дүгээр сард хэлцлийг амжилттай хаав.



Компанийн бонд гаргах 2 хэлцлийг амжилттай гүйцэтгэв

Голомт банк андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд Монголын хөрөнгийн зах зээлд анхдагч болсон бүрэн даатгалтай Эрчим бонд, мөн хаалттай хүрээнд хэрэгжүүлсэн ММФ бондын хүүгийн төлбөр болон эргэн төлөлтийг хугацаанд нь бүрэн хангуулж дуусгав. Ингэснээр 2016 онд компанийн бондын 2 хэлцлийг амжилттай гүйцэтгэж, хөрөнгө оруулагчид болон хамтран ажиллагсдынхаа итгэлийг баталгаажуулж чадлаа.

Монголын хөрөнгийн биржид IPO болон давхар бүртгэл хийх хэлцлүүдэд зөвлөв

Банк нь мөн онд харилцагч компанийн хувьцааг Монголын хөрөнгийн зах зээл дээр анх удаа олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэхээр андеррайтерийн гэрээ байгуулав. Энэ ажлын хүрээнд харилцагчаа олон нийтэд нээлттэй компани болоход бэлтгэх, мөн IPO хийх бэлтгэлийг хангаж ажиллалаа. Түүнчлэн дотоодын томоохон үйлдвэрлэгч компанийг олон улсын зах зээлд гарахад нь дөхөм болоход чиглэсэн давхар бүртгэлийн ажлыг судлан, харилцагчдадаа зөвлөж байна.

Монголын анхны IMAX кинотеатрын төслийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэв

Монголын кинотеатрын хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэх төслийг Өргөө кино театр сүлжээнээс хэрэгжүүлсэн бөгөөд Голомт банк төслийн санхүүжилтийн зөвлөхийн хувьд уг төслийг хамтран боловсруулсан юм. Улмаар олон улсын экспортын даатгалын агентлагтай хамтран санхүүжилт олгосон. Тус төсөл нь Монголын кино урлагийн хөгжлийг дараагийн шатанд гаргахад өндөр хувь нэмэр үзүүлсэн төсөл юм.

Олон улсын Экспорт санхүүжилтийн агентлагуудтай анхдагч харилцааг тогтоон ажиллаж байна

Голомт банк нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх зорилготой санхүүжилт олгож ирсэн юм. Өнгөрөгч онд ч олон улсын экспорт санхүүжилтийн агентлаг (ECA)-уудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэв. Мөн Чех, Канад, Япон, Словак, Беларусь зэрэг орнуудын экспорт санхүүжилтийн агентлагуудтай санхүүжилтийн гэрээг шинээр нэмж байгуулаад байна.

Ногоон байгаль, экологийн тэнцвэрт байдлыг дэмжигч-Голомт банк

Голомт банк нь үйл ажиллагааныхаа тэргүүнд ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг дэмжигч төслүүдийг дэмжих зорилт тавьдаг. Үүний хүрээнд 2016 онд Олон улсын ногоон уур амьсгалын сан (Green Climate Fund)-д гишүүнээр элсэх эхний алхамаа тавилаа. Тус төсөл нь ногоон ирээдүй, байгаль дэлхий, уур амьсгалыг хамгаалах төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг юм. Мөн Монголын банкуудын холбооноос санаачлан Байгаль орчин аялал жуулчлалын яам, Олон улсын ногоон хөгжлийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй Ногоон зээлийн санг үүсгэн байгуулах ажлын хэсэгт ажиллан, олон талт уулзалт хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санаачлагыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Оюу толгой төслийн ханган нийлүүлэгчдэд тусгай санхүүжилтийн бүтээгдэхүүн санал болголоо

Оюу толгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил эхэлснээр 2016 онд л гэхэд дотоодоос 403,3 сая ам.доллар буюу 800,0 тэрбум төгрөгийн худалдан авалтын хэрэгцээ үүссэн. Голомт банк нь тус төслийн ханган нийлүүлэгчдийн мэдээллийн санг үүсгэн байгуулж, Олон улсын хөгжлийн санхүүжилтийн байгууллага (DFI)-уудтай хамтран тусгай боломж, санхүүжилтийн бүтээгдэхүүнийг санал болгож эхэллээ.

Азийн хөгжлийн банкны 35,0 сая ам.долларын төслийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх эрх аван, амжилттай хэрэгжүүлж байна

Голомт банк нь Азийн хөгжлийн банкнаас ХАА-н агробизнесийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн төслийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх эрхийг авсан юм. 2016 онд тус эх үүсвэрээс ХАА-н бизнес эрхлэгчдэд дамжуулан зээл олгосон бөгөөд 2017 онд хямд эх үүсвэртэй тус санхүүжилтийг илүү олон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдэд хүргэхээр ажиллаж байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүллээ

Олон улсын санхүүгийн корпораци /ОУСК/-тай Гадаад худалдааны санхүүжилтийн баталгаа гаргах хамтын ажиллагааг эхлүүлээ.

Голомт банк нь 2016 оны 8 дугаар сард Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай Гадаад худалдааны санхүүжилтийн баталгаа гаргах гэрээг үзэглэлээ. Улмаар эрчим хүч, хөдөө аж ахуй, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, ялангуяа жижиг дунд бизнес эрхлэгчдэд экспорт, импортын бараа эргэлтээ сайжруулах боломжийг бий болгов.

Голомт банк Монгол Улсаас анх удаа олон улсын Factor chain international (FCI)-д гишүүнээр элслээ

Голомт банк нь экспорт, импортын бизнес эрхлэгч харилцагчдадаа зориулан дэлхийд алдартай 260 гаруй банк, санхүүгийн байгууллагатай хамтран богино болон дунд хугацаат, хөнгөлөлттэй нөхцөл бүхий гадаад худалдааны санхүүжилт, төлбөр тооцооны шийдлийг санал болгон ажилладаг.

Энэхүү үйл хэргээ өргөжүүлэн 2016 оны 4 дүгээр сард Монгол Улсаас анх удаа олон улсын Factor chain international-д гишүүнээр элслээ.

Голомт банк нь Factor chain international /FCI/ байгууллагад гишүүнээр элссэнээр Импорт факторинг буюу богино хугацаат гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээг үзүүлж байна. Энэ хүрээнд Хятадын ICBC, Bank of communications, China merchants банкуудтай Inter factor agreement байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлээд байна.

Гадаад худалдааны санхүүжилтийн шугам, ашиглалтаа нэмэгдүүлэв

Голомт банк ХБНГУ-ын АКА, Berliner sparkasse болон ВНФ банкуудтай худалдааны санхүүжилтийн гэрээг шинээр байгуулсан нь харилцагчдад өргөн сонголтыг олгож байна. Энэ нь тухайн улс, бүс нутгаас бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортолж байгаа болон бизнес эрхлэгчидтэй хамтарч буй аж ахуйн нэгжүүдэд зах зээлийн нөхцөлөөс хямд өртөг бүхий санхүүжилтийн боломжуудыг нээж өгч буйгаараа өндөр ач холбогдолтой юм.

Голомт банк нь БНХАУ-ын Bank of inner Mongolia, China trade solutions зэрэг банк санхүүгийн байгууллагатай гадаад худалдааны санхүүжилтийн хамтын ажиллагааг эхлүүлснээр, дотоодын харилцагчдын импортын худалдан авалтыг гадны эх үүсвэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх боломжоо нэмэгдүүллээ.

Мөн Хятадын Baoshang банктай хамтран Монгол Хятад хоёр улсын арилжааны банк хоорондын анхны төслийн санхүүжилтийг амжилттай гүйцэтгээд байна. Ингэснээр хоёр улсын эдийн засаг, банк санхүүгийн хамтын ажиллагаа дахин нэг шат ахиж байгаа юм.

ИВ Олон улсын хөрөнгө оруулалтын банкны шугамын хүрээнд Чех улсын CSOB банктай хамтран анх удаа UPAS LC нээсэн ба цаашид энэ төрлийн санхүүжилтийн нөхцөлөөр харилцагчдынхаа худалдан авалтыг санхүүжүүлэх боломж бүрдэж байна.

Гадаад төлбөр тооцоо, валютын арилжааны чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлээ

БНХАУ-ын Bank of China-тай хамтран Монгол, Хятад хоёр улсын хооронд анх удаа Төгрөгийн арилжааг гүйцэтгэж, олон улсын хэмжээнд идэвхжүүлэх анхны алхмыг тавилаа. Bank of China, Bank of inner Mongolia банкууд Голомт банкиг сонгон төгрөгийн дансаа нээснээр үндэсний мөнгөн тэмдэгт болох Төгрөг олон улсын төлбөр тооцоонд оролцох боломжийг бүрдүүлээ.

Мөн олон улсад салбар бүхий Raiffeisen банкны ОХУ дахь салбартай арилжааны гэрээ байгуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлээд байна.

Олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран сургалт явууллаа

Голомт банк нь боловсон хүчнийхээ мэдлэг чадварыг нэмэгдүүлэхэд байнга анхаардаг ба энэ зорилтынхоо хүрээнд United overseas bank-ны Нью-Йорк дахь болон Хонгконг дахь Мөнгөн тэмдэгт хариуцсан захирлууд Давид Вилленс болон Денис Чан Квок нарыг урин, хуурамч валютыг таних сургалтыг амжилттай зохион байгуулж, хамгийн сүүлийн үеийн бодит жишээ баримт бүхий мэдээлэл өгсөн юм. Мөн ажилчдынхаа мэдлэг ур чадварт үнэтэй хөрөнгө оруулалт хийж, China citic bank, Bank of communications банкуудад сургалтанд хамрууллаа.

Олон улсын үнэлгээ

S&P: /B-/ Outlook Negative


2016 оны 8 сард Олон улсын үнэлгээний байгууллага болох Standard and Poor's агентлаг нь Монголын Улсын эдийн засгийн байдалтай холбоотойгоор Голомт банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шатаар буюу B- /Тогтвортой/ байсныг B- /Сөрөг/ болгож бууруулсан.

Moody's: /Caa1-Local currency deposit/, Outlook- Stable

Олон улсын үнэлгээний байгууллага болох Moody's нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B3 /Тогтвортой/ -аас Caa1 болгож бууруулсантай холбоотойгоор 2016 оны 11 сард Голомт банкны урт болон богино хугацааны эрсдэлийн үнэлгээнд Caa1, дотоод валютын эх үүсвэрт Caa1, гадаад валютын эх үүсвэрт Caa2 гэсэн үнэлгээнүүдийг тус тус өгөөд байна.

Банкны үйл ажиллагаа

Хүний нөөц



2016 онд хэрэгжүүлсэн онцлох хөтөлбөрүүд

Зан төлөв, сэтгэл зүйд суурилсан хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан. Бүтээмж 30 хөтөлбөр, Sales platform төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Тэтгэврийн ууган сан

Тэтгэврийн ууган сан нь 2016 онд 1200 орчим гишүүнтэй болж, хуримтлалын сан өмнөх жилээс 17 хувиар өсч 7 тэрбум төгрөгт хүрсэн.

Кайзен, бүтээмжийн хөтөлбөр

Голомт банкинд банкны ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлэх зорилготой Кайзен саналын систем 8 дахь жилдээ хэрэгжиж байна. 2016 онд 323 кайзен санал ирснээс 9 санал чанарын дугуйлан болж амжилттай хэрэгжсэн.

Голомт банкны нэрэмжит Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг 2016 онд 15 дахь удаагаа зарласан бөгөөд 173 оюутны 109 бүтээл ирсэн юм. Энэ удаагийн эрдэм шинжилгээний бага хурлын онцлог нь ерөнхий чиглэлийн хүрээнд зарлагдсан тул оюутнуудын оролцоо өндөр, өргөн сэдвийг хамарч чадсанаараа хүчтэй өрсөлдөөн дунд явагдсан.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гол ажлууд

Санхүүгийн боловсролыг дэмжигч Голомт банк

- Голомт банк харилцагчдад санхүүгийн боловсролыг олгох зорилгоор МҮОНП-той хамтран бүтэн жилийн турш Харилцагчийн санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг хүргэлээ.
- Мөн харилцагчийн санхүүгийн боловсролыг дэмжих ажлын хүрээнд 10 цуврал радио жүжгийг бэлтгэн олон нийтэд хүргэлээ.
- Эдийн засгийн мэдлэг мэдээлэл, хувь хүний болон өрхийн санхүүгийн хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх талаарх цогц мэдлэгийг олгох зорилгоор Бизнес радио 98,9 радиотай хамтран 2016 оны турш Таны санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байна.
- Монголын хамгийн олон уншигчтай Өдрийн сонинтой хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор Монгол Улсад анх удаа Гурван гийгүүлэгч реалити цуврал нийтлэлийг бэлтгэн, уншигчдын хүртээл болголоо.
- Голомт банк Монгол Улсад анх удаа ЖДБ эрхлэгчдэд зориулсан www.sme.golomtbank.com сайтыг нээсэн бөгөөд 2016 онд тус сайтын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн, контент хөгжүүлэлтийг идэвхжүүлэн ажиллалаа.

Боловсролыг дэмжигч Голомт банк

- Голомт банкны нэрэмжит Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг 2016 онд 15 дахь удаагаа зарласан бөгөөд 173 оюутны 109 бүтээл ирсэн юм. Энэ удаагийн эрдэм шинжилгээний бага хурлын онцлог нь ерөнхий чиглэлийн хүрээнд зарлагдсан тул оюутнуудын оролцоо өндөр, өргөн сэдвийг хамарч чадсанаараа хүчтэй өрсөлдөөн дунд явагдсан.
- Улсын хэмжээнд суралцаж буй нийт оюутнуудын 49 хувь нь 2015-2016 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрөө төлөөгүй байна гэсэн судалгаа бий. Үүнээс үүдэн оюутан залуус хичээл завсардах, ирээдүйдээ итгэл алдрах зэрэг бэрхшээл тулгардаг тул Голомт банк Оюутны хөгжлийг дэмжих зээлийг олгож байна.

Голомт банк спорт, соёл урлагийн хөгжилд

- Голомт банк нь Бразил Улсад зохиогдсон зуны олимпийн XXX1, паралимпийн XV наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох баг тамирчдаа дэмжин Монгол Улсын ерөнхий сайдын нэрэмжит цомыг хүлээн авч өөрийн салбар тооцооны төвүүдээрээ аялуулсан бөгөөд олимпизмыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилтын хүрээнд ТВ-9 телевизийн АХА танин мэдэхүйн нэвтрүүлэгт оролцон, олимпод оролцсон тамирчидтай уулзалт хийн 5 сая төгрөгийн хандив өргөлөө.



- Монгол Улсад зохион байгуулагдсан Ази тивийн Оюутны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах 6 дахь удаагийн тэмцээнийг Голомт банк ивээн тэтгэлээ. Тус тэмцээнд Монгол, БНСУ, БНХАУ, Макао, Тайвань, Казакстан, Хонг-Конг зэрэг нийт 7 орны 160 гаруй тамирчид хурд хүч авъяас чадвараа сорин өрсөлдсөнөөс Монгол Улсын баг тэргүүн байрыг эзэлсэн юм.
- 2016 онд банкны уламжлалт спортын арга хэмжээг илүү өргөн хүрээнд зохион байгуулснаас гадна Монголын оюутны спортын холбоотой хамтран Дэлхийн оюутны аварга шалгаруулах байт харваа, Азийн оюутны аварга шалгаруулах эрэгтэй сагсан бөмбөгийн тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.
- Монголын хүүхэд залуучуудын Соробан сампингийн холбооноос зохион байгуулдаг Соробаны баяр, Соробан сампингийн үндэсний аварга шалгаруулах тэмцээнийг Голомт банк ивээн тэтгэлээ. Соробан сампин нь хүүхэд өсвөр үеийн оюуны чадамжийг дээшлүүлэх, тархины хоёр тал бөмбөлгийг хөгжүүлэх, дүн шинжилгээ хийх чадварыг нь хөгжүүлэх, ой тогтоолт сайжруулах зэрэг ач тустай юм.
- Монгол үндэстний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах үйлсэд Голомт банк нь өөрийн хувь нэмрээ оруулан, Монгол Улсын морин хуурын чуулгатай 5 дахь жилдээ хамтран ажиллаж байна.
- Голомт банк сонгодог урлагийг дэмжих түгээн дэлгэрүүлэх үүднээс УДЭТ, УДБЭТ-тай хамтран ажиллаж байна.

Голомт банк ногоон хөгжлийн төлөө

- Голомт банк нь Монгол Улсаас анх удаа НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга буюу UNEP FI-д нэгдэж, гишүүнээр элслээ.
- Голомт банк эх дэлхийгээ хайрлах, байгаль орчноо хамгаалах зорилтын хүрээнд Цаасгүй цахим банк аяныг өрнүүллээ.
- Голомт банк ТоС сар-2016 аяны хүрээнд эх дэлхийгээ хайрлан хамгаалах, эрүүл эдийн засаг, зөв нийгмийн хөгжлийг хангахад шаардлагатай зөв ойлголт мэдээллийг банкны нийт ажилтан албан хаагчид болон харилцагчид, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгууллаа.



- Голомт банк нь ТоС-ийн бодлогын хүрээнд жирэмсэн болон 0-2 насны хүүхэдтэй эхчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалалгүй үйлчилж байна.
- 2016 оны ТоС манлайлагч байгууллага болох Голомт банк нь Монголын банкны холбоо (МБХ)-той хамтран харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд Голомт банкны харилцагч болох Түмэн шувуут ХХК-ийн тэжээлийн үйлдвэр, шувууны эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах сайн туршлагатай танилцсан юм.

Голомт банк эх орны хөгжлийн төлөө


- Голомт банк улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 26000 гаруй аж ахуйн нэгжээс Үндэсний тэргүүлэгч ажил олгогч-Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч шилдэг байгууллагаар шалгарлаа. Голомт банк нь үүсгэн байгуулагдсан 21 жилийн түүхэндээ улсын төсөвт аж ахуйн нэгжийн орлогын албан татвар хэлбэрээр 80 орчим тэрбум төгрөг, эрүүл мэнд, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татвар хэлбэрээр 20 гаруй тэрбум төгрөгийг тушаажээ.

Эрсдэлийн удирдлага

Банкны алсын хараа, бизнесийн зорилгод нийцсэн үр ашигтай эрсдэлийн удирдлага нь эдийн засгийн өсөлттэй болон удаашралтай аль ч нөхцөлд амжилттай ажиллах гол үндэс болдог төдийгүй банкны стратеги зорилтуудыг биелүүлэх гол хөшүүрэг юм. Энэхүү ойлголтыг банкны шат шатны удирдлагууд бүрэн ойлгож, ажилтан бүрт эрсдэлийг ухамсарлах сэтгэлгээг төлөвшүүлж, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх замаар харилцагч, хадгаламж эзэмшигчид, хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг үргэлж хамгаалдаг хүчирхэг эрсдэлийн соёлыг банкны хэмжээнд бүрэн хэрэгжүүлэн амжилттай ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Голомт банкны эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн хязгаарлалтуудын хүрээнд банкны ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурийг тогтвортой өсгөх, хувьсан өөрчлөгдөх бизнесийн орчинд амьдрах чадвартай эрсдэлийн хүчирхэг соёлыг түгээх голомт байхад оршино.



- Эрсдэлийн үндсэн *аппетиттай* нийцтэй бизнесийн *стратеги*, эрсдэлийн *хязгаарлалтууд*
- **1-р шугам:** Бизнес нэгж
2-р шугам: Эрсдэлийн удирдлагын газар
3-р шугам: Дотоод аудитын газар
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх, эргэн хянах, хязгаарлах түвшин
- Банкны ажилтан бүр эрсдэлийн менежер, эрсдэлийн соёлыг түгээгч байх

ТУЗ-өөс баталсан эрсдэлийг хязгаарлах түвшин буюу эрсдэлийн аппетитын хүрээнд бизнесийн стратегийг хэрэгжүүлэхэд оновчтой эрсдэлийн засаглал, хүчирхэг эрсдэлийн удирдлагын соёл зайлшгүй шаардлагатай.

Голомт банкны шат шатны удирдлагууд хүчтэй эрсдэлийн соёлыг бүрдүүлэх замаар банкны ажилтан бүрийг өөрийн хариуцсан чиглэлийн дагуу эрсдэлийн удирдлагын зохих мэдлэгтэй болгож, удирдлагаас өгөгдсөн эрх хэмжээний дагуу өөрийн гаргасан шийдвэрт хариуцлага хүлээх, эрсдэлийн удирдлагыг банкны хэмжээнд хэрэгжүүлэн, амжилттай ажиллаж байна.

Тасралтгүй хувьсан өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд банк эрсдэлийн чиг хандлагад үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай тохиолдолд эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн хөгжүүлдэг. 2016 онд Голомт банкны ТУЗ нь банкны стратеги, бизнесийн үйл ажиллагаанд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн төрөл, түвшинг тодорхойлсон Эрсдэлийн аппетитийн тогтолцоо, Эрсдэлийн аппетитийн тунхаглалыг баталсан.

Голомт банкны Эрсдэлийн аппетитийн тогтолцоо нь банкны стратеги төлөвлөгөө болон эрсдэлийн аппетитийг боловсруулах, бодит эрсдэлийн түвшин эрсдэлийн хязгаарлалттай нийцтэй байгаа эсэхэд хяналт тавих, стратегийн үнэлгээ дүгнэлтийг стресс тестийн гол төсөөллүүд дээр үндэслэн хийж, шийдвэр гаргах гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Эрсдэлийн аппетитийн тунхаглалын хүрээнд банкны хэмжээнд хэмжиж, удирдахаар ажиллаж буй үндсэн эрсдэлүүд болох зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, комплаенс эрсдэл, гэрээлэгч тал ба гуравдагч этгээд, хууль, нэр хүнд, технологийн эрсдэл болон бусад эрсдэлүүд зэрэг нийт 15 төрлийн эрсдэлийн хувьд хэм хэмжээг тодорхойлсон.

Эрсдэлийн засаглал

Голомт банк нь гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн засаглалын бүтцийн дагуу эрсдэлийн аппетитын тогтолцоог хэрэгжүүлж, нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог улам сайжруулан ажилласаар байна. Үүний томоохон жишээ нь 2016 онд банкны нэгж бүр өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг оновчтой үнэлэх Өөрийн үнэлгээний аргачлалыг амжилттай нэвтрүүлсэн.

Ашгийн төлөө ажиллаж буй бизнесийн нэгжүүд нэгдүгээр хамгаалалтын шугам, Эрсдэлийн удирдлагын хороо ба Эрсдэлийн удирдлагын газар хоёрдугаар хамгаалалтын шугамыг үүсгэж, Дотоод аудитын газар гуравдугаар хамгаалалтын шугам болно.

1. Бизнесийн нэгжүүд

- Нэгж бүр өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг хариуцах
- Аливаа шийдвэр гаргалтандаа эрсдэл, өгөөжийг тооцох
- Нэгжийн үйл ажиллагаа нь банкны эрсдэлийн удирдлагын бодлого, аппетит, журамтай нийцэж байгаа эсэхийг тогтмол хянаж, баталгаажуулах
- Нэгжийн KPI-д бизнес болон санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна эрсдэлийн аппетитыг хангах үзүүлэлтүүдийг тусгах

2. Эрсдэлийн Удирдлагын Газар

- Эрсдэлийн удирдлагын үр ашигтай хэрэгжилтэнд банкны бусад нэгжүүдээс хараат бусаар хяналт тавих
- Эрсдэлийн удирдлагын бодлого, хяналт болон эрсдэлийн хязгаарыг тодорхойлж, тайлагнах
- Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд бизнесийн нэгжүүдэд шаардлага тавих
- Банкны бодлого журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах

3. Дотоод Аудитын Газар

- Банкны үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлэх
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хяналтын системийн зөв зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
- Аудитын хороо болон удирдлагуудад банкны үйл ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнах

Үр ашигтай эрсдэлийн удирдлага нь байгууллагад зохицсон эрсдэлийн удирдлагын хүчтэй засаглалд суурилдаг тул Голомт банкны ТУЗ нь өөрийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд шууд тайлагнах үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын газрын дэмжлэгтэйгээр эрсдэлийг удирдахад идэвхтэй оролцдог.

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь Эрсдэлийн удирдлагын бодлого, хязгаарлалтуудыг баталж хэрэгжилтийг улирал бүр Эрсдэлийн хороогоор дамжуулан хянан баталгаажуулдаг. 2016 онд ТУЗ-өөс нийт 16 төрлийн эрсдэлийн метрикийг нарийвчлан тодорхойлсон.

Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх удирдлагууд нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн метриксүүдийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын газар нь банкны нэгж, ажилтнууд эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, Гүйцэтгэх захирал түүний дэргэдэх Удирдлагын хорооноос гадна ТУЗ –ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд шууд тайлагнадаг.

Эрсдэлийн удирдлагын газар

Эрсдэлийн удирдлагын газар нь банкны эрсдэлийн удирдлага, түүний тогтолцоо, хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг бизнесийн нэгжүүдээс хараат бусаар хэрэгжүүлдэг.

Удирдлагын хороо

ТУЗ-өөр батлах банкны стратеги, бодлого, бизнес төлөвлөгөө, бусад баримт бичгүүдийн төсөлд эрсдэлийн удирдлагатай холбоотой шийдвэрлэх асуудлыг тусган, эрсдэлийн хязгаарлалтын хэрэгжилт, хяналт, санхүүгийн гүйцэтгэлийг үнэлэн, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар хэлэлцэн зохистой шийдвэрийг гарган ажилладаг.

Зээлийн хороод

Зээлийн хороод нь зээлийн хэмжээнээс шалтгаалан Зээлийн хороо болон Зээлийн дэд хороо гэсэн бүтцээр ажилладаг. Эдгээр хороод нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлого, зээлийн хязгаарлалтын хүрээнд шийдвэр гарган, зээлийн үйл ажиллагааны журам заавар стандартыг батлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг.

Актив, пассивийн хороо

Банкны актив, пассивийг оновчтой удирдах замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн хамт холбогдох эрсдэлийн хязгаарлалтуудыг хангах чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд дэмжлэг болон ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын соёл

Голомт банкны шат шатны удирдлагууд хүчтэй эрсдэлийн соёлыг бүрдүүлэх замаар банкны ажилтан бүрийг өөрийн хариуцсан чиглэлийн дагуу эрсдэлийн удирдлагын зохих мэдлэгтэй болгож, удирдлагаас өгөгдсөн эрх хэмжээний дагуу өөрийн гаргасан шийдвэрт хариуцлага хүлээх, эрсдэлийн удирдлагыг банкны хэмжээнд хэрэгжүүлэн, амжилттай ажиллаж байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг банкны хүлээн зөвшөөрөгдөх зээлийн эрсдэлийн аппетитийн түвшинд барих, урьдчилан тодорхойлон, тэдгээрээс сэргийлэн ажилладаг бодлогын нэгж юм. Нэгжийн зорилтын хүрээнд харилцагчийн зээлийн багцын чанарын үзүүлэлтийн шинжилгээ хийн, дүгнэлт гаргах, зээлийн эрсдэлийн стратеги, бодлого журмыг боловсруулан ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилладаг.

Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь олон улсын болон дотоодын удирдах байгууллагын гаргасан эрсдэлийн удирдлагын стандарт, зөвлөмжийг банкны үйл ажиллагаанд нийцүүлэн нэвтрүүлдэг бөгөөд Монголбанкнаас тогтоосон зохистой хэрэглээний шалгуур үзүүлэлтүүд болон 2016 онд шинэчлэн баталсан Активийг ангилах, активийн эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2016 онд Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь илүү судалгаан дээр суурилсан арга аргачлал, бодлого зөвлөмжийг боловсруулах зорилт тавин ажилласан. Тус зорилтын хүрээнд бид банкны түүхэн өгөгдөлд үндэслэсэн харилцагчийн зээлжих зэрэглэлийг (Credit rating/Credit scoring) тогтоох загварыг хөгжүүлэн, амжилттай нэвтрүүллээ. Манай банк нь уг систем дээрээ үндэслэн зээлийн бүтээгдэхүүний үнэнд багтах эрсдэлийн шагналыг тогтоож, харилцагчдад хамгийн ихээр тохирох зээлийн бүтээгдэхүүн, нөхцөлийг санал болгож эхэллээ.

Credit rating/credit scoring систем нь зээлийг шуурхай шийдвэрлэх зах зээлийн шаардлагад нийцсэн, зээлийн эрсдэлийн удирдлагын илүү боловсронгуй тогтолцооны ердөө эхлэл юм.

Бид 2017 онд олон улсын тайлагналын стандарт болох IFRS 9, Базелийн хорооны бодлого журам, хяналтын стандартчилал Basel III – н шинэчлэлийг банкны зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журмуудад тусган, тус өөрчлөлтийн бэлтгэл ажил хийхээр төлөвлөөд байна.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Голомт банкны зах зээлийн эрсдэлийн удирдлага нь банкны арилжаа, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд валютын ханш, хүү, түүхий эдийн үнэ зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан үүсэх эрсдэлийг бууруулж, үр ашигтай эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн зорилготой.

Бид макро эдийн засгийн үзүүлэлтүүд, ирээдүйд гарч болзошгүй эрсдэлүүдийг судлан банкны бизнес төлөвлөгөөнд тусгаж, шийдвэр гаргалтанд ашигласаар ирсэн. 2016 оноос эхлэн эдийн засагт тулгараад буй эрсдэлүүдийг олон нийтэд таниулах зорилгоор банкны Ерөнхий эдийн засагчтай хамтран макро эдийн засгийн судалгаа, таамаглалыг хэвлэл мэдээллийн сувгаар дамжуулан нийтэд түгээж байна.


Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь эдийн засгийн дэд секторуудын судалгааг нарийвчлан хийж, зах зээлийн чиг хандлага, баримтлах бодлого, шинээр зах зээлд нэвтрүүлэх боломжтой бүтээгдэхүүн үйлчилгээний саналыг боловсруулсан.

Бид 2016 онд шинэчлэн тодорхойлогдсон банкны эрхэм зорилго, зорилтод нийцүүлэн зах зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлтүүдийг тусгасан. Мөн банк санхүүгийн байгууллага, улсын эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн сайжруулсан нь хөрөнгө зохицуулалт болон худалдааны санхүүжилтийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг болж өгсөн.

Хөрвөх чадварын эрсдэл

Голомт банк нь хөрөнгийн хөрвөх чадварыг зохистой түвшинд хангах ажлын хүрээнд Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон хөрвөх чадварын бусад үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



● Монголбанкны зохистой шаардлага ● Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Монголбанкны тодорхойлсон зохистой харьцаа үзүүлэлтээс гадна 2016 оноос эхлэн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд банкны эрсдэл, хяналт шалгалтын стандарт Базел III-ын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын чиглэлд зөвлөсөн LCR/Liquidity coverage ratio/, NSFR/Net stable funding ratio/ гэсэн хоёр харьцаа үзүүлэлтийг шинээр нэвтрүүлж тооцож эхэлсэн. LCR харьцаа нь хямралын нөхцөл байдлын үед банкууд доод тал нь 30 хоногийн турш өөрсдийн хүлээсэн богино хугацааны төлбөрийн үүргийг биелүүлэх чадвартай болохыг баталгаажуулах зорилготой.

NSFR харьцаа нь банкуудын богино хугацааны тогтворгүй эх үүсвэрээс хамаарсан хамаарлыг багасгах, урт хугацааны санхүүжилтийг хангахуйц хэмжээний урт хугацааны, тогтвортой эх үүсвэртэй болохыг баталгаажуулах зорилготой. Эдгээр хоёр харьцааг бид 2016 оноос эхлэн Базелийн хорооноос зааварчилсан аргачлалын дагуу тооцож, тогтмол хянаж эхэлсэн бөгөөд аль аль харьцааны хувьд заагдсан лимит, хязгаарыг бүрэн хангаж ажиллаж байна.

Стресс тест

Эрсдэлийн удирдлагын газар нь гэнэтийн хүчин зүйлсийн улмаас банканд үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор, тусгайлсан болон системчилсэн стресс сценариудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөллүүдийг тогтмол хийж, дүгнэлт гарган ажилладаг.

2016 онд бид актив пассив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны зөрүү (maturity gap) тооцоолол дээр стресс тест хийж, амжилттай нэвтрүүлсэн. Суурь төсөөлөл нь харилцах, хадгаламжийн гадагшлах урсгал нэмэгдэж, пассив талын хөрөнгөнд хүндрэл учирна гэж үзсэн бол стресс нөхцөл байдалд макро эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан активын чанар муудаж, эх үүсвэрийн гадагшлах урсгалын шок зэрэг учирна гэж үзсэн. Уг стресс тестийн үр дүнгээс харахад суурь болон макро эдийн засгийн стресстэй төсөөллийн аль алинд нь Голомт банк хэвийн үйл ажиллагаагаа үргэлжүүлэх чадвартай гэсэн үр дүн гарсан.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Голомт банк нь дотоод үйл ажиллагаа, хүмүүс, системийн хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл, үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийн үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлсээр ирсэн.

Бид эрсдэлийн удирдлагын соёлыг түгээж, банкны ажилтан бүрийг эрсдэлд суурилсан сэтгэлгээнд суралцуулах ажлын хүрээнд Эрсдэлийн форум-2016 арга хэмжээг салбар нэгжийн бүртгэлийн ажилтнуудын дунд анх удаа зохион байгуулав. Уг форумын эхний өдрүүдэд салбарын ажилтнууд онол аргазүйн сургалтад хамрагдсан ба сүүлийн өдөр эрсдэлийн үнэлгээ хийх төлөвлөгөөт ажлуудыг багаараа хийж гүйцэтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Онол практикт суурилсан энэхүү форум нь эрсдэлийг удирдах арга барилыг банк даяар түгээх нэгэн хөшүүрэг болж өгсөн.

2016 онд үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сайжруулах зорилгоор Базелийн хорооноос санал болгосон Advanced measurement approach аргачлалыг ашиглан үйл ажиллагааны эрсдэлийн түүхэн мэдээлэлд тулгуурлан тухайн жилийн үйл ажиллагааны эрсдэлийн хэмжээг тооцож гаргасан ба энэхүү тооцоололд тулгуурлан хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагааны эрсдэлийн хэмжээг тодорхойлж сан байгуулсан.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор и-мэйл хэрэглэгч нарын зохистой хэрэглээг хэмжиж, и-мэйл симуляци зохион байгуулсан. Уг ажлын үр дүнд банкны мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бодит амьдрал дээр үзүүлсэн ба банкны мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад ажилтан бүрийн оролцоо нэмэгдэж эхэлсэн.

Бид банкны харилцагчийг эрсдэлээс хамгаалахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээг зохион байгууллаа. Тухайлбал yahoo и-мэйл хэрэглэгчдийн мэдээлэл алдагдсантай холбоотойгоор харилцагчдад нарт нууц үгээ шинэчлэх талаарх анхааруулга мэдээлэл аюулгүй байдлын зөвөлгөө илгээж харилцагчдад чиглэсэн цахим халдлагуудын талаар мэдээлэх ажлуудыг зохион байгуулж, амжилттай ажилласан.

Тусгай активийн үйл ажиллагаа

Банкны тусгай активийн хэлтэс нь чанаргүй ангилалд бүртгэгдсэн, эргэн төлөлтөд тодорхой асуудал үүссэн зээл, авлагыг хянах болон төлүүлэх үйл ажиллагааг хариуцдаг.

Бид зээл, авлага эргэн төлөгдөх явцад асуудал үүсэх нь тодорхой болоход тусгай активийн хэлтсийн менежерүүд тухайн зээл, авлагыг хариуцсан харилцааны менежер, ажилтан, Зээлийн газрын эрсдэлийн мэргэжилтнүүдтэй хамтран зээл, авлагыг хариуцагч этгээдийн үйл ажиллагаа, эргэлтийн хөрөнгө, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бусад үнэ цэнэтэй хөрөнгөнд үнэлгээ хийж, ямар арга хэмжээ авах талаар төлөвлөгөө боловсруулдаг.

Асуудалтай зээл, авлагыг аль болох богино хугацаанд төлүүлэх, хөрөнгийг найдвартай хамгаалах үүднээс банк бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Зээл, авлагыг шүүхийн бус болон шүүхийн замаар төлүүлэх ажиллагааг тусгай активийн хэлтсийн мэргэжилтнүүд гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд гэрээт өр барагдуулагч нарыг томилон ажиллуулдаг. Өр барагдуулагч нарын үйл ажиллагаанд тогтмол хяналтыг Тусгай активийн хэлтсээс тавьж ажилладаг.

Тусгай активийн хэлтэс нь зээлийн гэрээний үүргийг хангуулах зорилгоор зээлдэгчтэй уулзаж, харилцан тохиролцон үйл ажиллагааны бүтээмж үр ашгийг нь сайжруулах, авлага цуглуулах, илүүдэл бэлэн бүтээгдэхүүн, бараа материал, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах байдлаар хамтран ажилладаг. Зээлдэгчийн банктай харьцаж байсан түүх, зээлийг эргэн төлөх чадвар, банкнаас санал болгож буй эргэн төлөх нөхцлийг хүлээн зөвшөөрөх байдал зэргээс шалтгаалан банк дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Шаардлагатай тохиолдолд бид зээлийн нөхцөлийг өөрчлөх бодлого баримтлана. Энэ тохиолдолд тусгай активийн хэлтэс нь зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүнээс чөлөөлөх, хугацааг сунгах, үндсэн зээлийн төлбөрийн хуваарийг өөрчлөх зэрэг зээлдэгчид аль болох зээл, зээлийн хүүг эргэн төлөх боломжийг олгох байдлаар хамтран ажилладаг. Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах болсон тохиолдолд Эрсдэлийн удирдлагын газрын захиралд танилцуулах бөгөөд зээлийн хэмжээнээс хамааран Зээлийн хороо, Зээлийн дэд хороогоор хэлэлцүүлж батлуулна.

Тусгай активийн хэлтсийн хариуцсан зээл нь чанаргүй ангиллаас хэвийн ангилалд шилжсэн тохиолдолд тухайн зээлд 3-6 сарын турш үргэлжлүүлэн хяналт тавьж ажилладаг.

Зээл, авлагыг хариуцагч нь төлбөрийг сайн дураар буюу шүүхийн бус аргаар төлөхгүй тохиолдолд шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлдэг. Шүүхийн шийдвэрийг үндэслэн өр төлбөрийг барагдуулах ажиллагааг явуулах ба зайлшгүй шаардлага гарвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын туслалцаатай өрийг төлүүлдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, эрхзүйн бусад бичиг баримтад үндэслэгдэн тодорхой цаг хугацаа, зардал шаардагддаг. Шүүхийн журмаар өрийг төлүүлэхээс өмнө банк нь мэргэжлийн экспертээр тусгай үнэлгээ хийлгүүлж, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломж, барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ зэргийг тогтоолгож, зөвлөгөө авдаг.

Зээл, авлагыг хариуцагч нь олдохгүй болсон, нас барсан, шүүхийн шийдвэр гарснаас хойш төлбөр хийлгүй удсан тохиолдолд Хөнгөлөлт чөлөөлөлтийн комиссын хурлаар хэлэлцүүлж, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар батлагдсан активийг ангилах, сан байгуулах, зарцуулах журмыг мөрдлөг болгон сангаас хааж, балансын гадуур бүртгэл болон Black list-д бүртгэн өр төлбөр барагдуулах ажиллагааг үргэлжлүүлэн хийдэг.

Бид 2017 онд үүссэн тусгай активийг бууруулах, нийт ажилтнуудад тусгай актив үүсэх нөхцөл байдал бий болохоос сэргийлэх зорилгоор холбогдох заавар зөвлөмжийг хүргүүлэн нягт уялдаа холбоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Актив, пассивийн хосолсон удирдлага



Голомт банк нь Монголд анх удаа актив, пассивийн хосолсон удирдлагын менежментийг нэвтрүүлж, хосолмол, харилцан уялдаатай удирдлагыг хэрэгжүүлэх, оновчтой бөгөөд шуурхай хариу үйлдэл үзүүлэх, ирээдүйн ашигт ажиллагааг тогтмол хангахуйц шийдвэрүүдийг гаргах үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Бид 2018 он хүртэл баримтлах актив, пассивийн бодлогоо боловсруулж, бүтээгдэхүүний үнэ тогтоох, хөрвөх чадвар, балансын удирдлагын цогц шийдэл болсон Funds transfer pricing аргачлалыг нэвтрүүлэхэд шаардлагатай бүхий л ажлыг хийж гүйцэтгэсний үндсэн дээр 2017 онд бүрэн хэмжээгээр ашиглахад бэлэн болоод байна. Түүнчлэн дэлхийн жишиг Монголын банк болох зорилгын хүрээнд олон улсын стандартад нийцсэн /BASEL III/ үйл ажиллагааны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Гишүүнчлэл нь банкны дээд удирдлагуудаас бүрдсэн Актив, пассивийн хороо Гүйцэтгэх захирлын дэргэд ажилладаг бөгөөд уг хороогоор банкны актив, пассив, тэдгээрийн бүтэц, өгөөж, эрсдэл зэрэг үзүүлэлтийн шийдвэрийг гаргадаг.

Голомт банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангалттай түвшинд хадгалахад онцгой анхаарал хандуулсаар ирсэн ба Монголбанк, Базелийн хорооноос арилжааны банкуудад тавьдаг шаардлагуудыг тогтмол ханган ажиллалаа. Манай банкны оны эцсийн байдлаарх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 44.89 хувьтай байна
















Харилцагч банкууд

| № | УЛС | ХАРИЛЦАГЧ БАНКУУД | СВИФТ БОЛОН ТЕЛЕКС ДУГААР | МӨНГӨНИЙ НЭГЖ | НОСТРО ДАНС |
|-----|------------------|--|---|------------------|---|
| 1. | Australia | AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP ANZ CENTRE MELBOURNE, LEVEL 9, 833 COLLINS STREET DOCKLANDS, VICTORIA, AUSTRALIA, 3008 | ANZBAU3M | AUD | 920660AUD00001 |
| 2. | Austria | RAIFFEISEN BANK INTERNATIONAL AG VIENNA 1030 VIENNA AUSTRIA | RZBAATWW | EUR | 1-55 076 335 |
| 3. | Canada | CANADIAN IMPERIAL BANK OF COMMERCE TORONTO M5G 2M8, CANADA | CIBCCATT | CAD | 1818910 |
| 4. | China | AGRICULTURAL BANK OF CHINA (Beijing) INT.L DEPT. 5/F, JIN YU PLAZA ROAD, BEIJING100036, P.R.CHINA | ABOCCNBJ | USD | 8211000908 |
| 5. | | AGRICULTURAL BANK OF CHINA (Huhhot) (NEIMENGGU BRANCH) HUHEHAOTE, INNER MONGOLIA, P.R.CHINA | ABOCCNBJ050 | USD CNY | 05999914040000049 05999901040000053 |
| 6. | | BANK OF CHINA INNER MONGOLIA BRANCH ERLIAN SUB- BRANCH, P.R.CHINA | BKCHCNBJ880 | USD CNY | 155605293946 154005293944 |
| 7. | | BAOSHANG BANK INNER MONGOLIA BRANCH BAOTOU, P.R.CHINA | BTCBCNBJ | CNY USD | 002105599800010 002105599800020 |
| 8. | | CHINA CONSTRUCTION BANK NEIMENGGU BRANCH, P.R.CHINA | PCBCCNBJNME | USD CNY | NRA15014150500220100181 15001658408052502177 |
| 9. | | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK INNER MONGOLIA BRANCH NO.105, XILIN NORTH ROAD HOHHOT, INNER MONGOLIA, P.R.CHINA | ICBKCNBJNMA | USD CNY | 0610040629200061234 0610040609200054391 |
| 10. | | BANK OF INNER MONGOLIA 33 TENG FEI ROAD, HUHROT, INNER MONGOLIA, P.R.CHINA 010020 | HSSYCNBH | USD CNY | 115914236000000184 115901236000000122 |
| 11. | | BANK OF COMMUNICATIONS INNER MONGOLIA BRANCH, NO.18, HOHHOT, INNER MONGOLIA, P.R.CHINA 010010 | COMMNSH | CNY | 151899991010003021570 |
| 12. | | CHINA CITIC BANK HUHEHAOTE BRANCH HUHEHAOTE, P.R.CHINA | CIBKCNBJ010 Bank Code: 302191027101 | USD CNY | 7271111486000000181 7271110186000000155 |

| | | | | | |
|-----|------------|---|-----------------|----------------------------|--|
| 13. | Germany | COMMERZ BANK AG, FF/AM MAIN 60261 FRANKFURT AM MAIN FRANKFURT AM MAIN | COBADEFF | USD EUR CHF GBP JPY CNH | 400 878 506 500 400 878 506 501 400 878 506 500 400 878 506 500 400 878 506 500 400 878 506 508 |
| 14. | | DEUTSCHE BANK AG 60262, FRANKFURT AM MAIN, GERMANY | DEUTDEFF | EUR | 100-9517673-0000 |
| 15. | | BERLINER SPARKASSE-LANDESBANK BERLIN AG ALEXANDERPLATZ 2, 10178 BERLIN, GERMANY | BELADEBE | USD EUR | 10050000/3270000250 10050000/6630008373 |
| 16. | Hong Kong | BANK OF CHINA (HONG KONG) LIMITED BANK OF CHINA TOWER, 1 GARDEN HONG KONG | BKCHHKHH | HKD CNY USD | 012-875-60115674 01287560118495 01287560121220 |
| 17. | Japan | MIZUHO BANK LTD MARUNOUCHI, CHIYODA-KU, TOKYO 100-8210 JAPAN | MHCBJPJT | JPY | 6740010 |
| 18. | | SUMITOMO MITSUI BANKING CORPORATION 1-2 YURAKUCHO 1-COME, CHIYODA-KU, TOKYO, JAPAN | SMBCJPJT | USD JPY | 3623 4374 |
| 19. | | BANK OF TOKYO MITSUBISHI JP TOWER, 2-7-2 MARUNOUCHI, CHIYODA-KU, TOKYO 100-0005, JAPAN | BOTKJPJT | USD JPY | 653-0455601 653-0432881 |
| 20. | Kazakhstan | KAZKOMMERTSBANK JOINT-STOCK COMPANY 135G, GAGARIN ST., ALMATY, 050060, REPUBLIC OF KAZAKHSTAN | KZKOKZKX | USD | KZ769260001000694001 |
| 21. | Korea | KEB HANA BANK 181, 2-KA, 181, EULJIRO 2-GA, JUNG-GU, C.P.O. BOX 2924, SEOUL 100-793, KOREA | KOEXKRSE | USD KRW | 963-THR-313-01-2 0963FRW001000054 |
| 22. | | SHINHAN BANK, SEOUL P.O.BOX 2997 SEOUL 100-629, KOREA | SHBKKRSE | USD KRW | 0102245USD01 0102245KRW01 |
| 23. | | KOOKMIN BANK, SEOUL 10, YEOUIDO-DONG, YOUNGDEUNGPO-GU, SEOUL, KOREA 150-868 | CZNBKRSE | USD KRW | 819-8-USD-0-15 819-8-KRW-0-17 |
| 24. | Taiwan | LAND BANK OF TAIWAN HEAD OFFICE 46, KUAN CHIEN ROAD, TAIPEI, TAIWAN, REPUBLIC OF CHINA | LBOTTWTP | USD | 088-185-00002 |
| 25. | Turkey | YAPI ve KREDİ BANKASI A.Ş YAPI KREDİ PLAZA D BLOK, LEVENT 34330 ISTANBUL, TURKEY | YAPITRIS | USD | 95711515 |

| | | | | | |
|-----|-----------------------|--|---|---------|--|
| 26. | Poland | mBANK 18 SENATORKA STREET,00-950 WARSAW, POLAND | BREXPLPW | PLN | IBAN: PL 52 114 000 000 000 114 851 001 001 |
| 27. | | SBER BANK, 31 DEPUTATSKAYA ST, 664047, IRKUTSK RUSSIA | SABRRU66 231231 | USD RUB | 30111840518000000003 30111810618000000001 |
| 28. | | SBER BANK, MOSCOW 19 VAVILOVA STREET, 117997MOSCOW, RUSSIA | SABR RUM 012 | USD RUB | 30111840100000000840 30111810800000000840 |
| 29. | Russia | JSC BANK FOR FOREIGN TRADE BIK: 044525187, RUSSIA K/S: 30101810700000000187 | VTBRRUMM | RUB USD | 30111810655550000126 30111840155550000104 |
| 30. | | RUSSIAN AGRICULTURAL BANK 119034 MOSCOW, RUSSIA BIK: 044525111 K/S: 30101810200000000111 | RUAGRUMM | USD RUB | 30111840300000000006 30111810200000000013 |
| 31. | | UNITED OVERSEAS BANK LIMITED 80 RAFFLES PLACE, #05-00 UOB PLAZA 1 SINGAPORE 048624 | UOVBSGSG | SGD | 301-399-069-5 |
| 32. | Singapore | DBS BANK MARINA BAY FINANCIAL CENTRE, TOWER 3, SINGAPORE, 018982 | DBSSSGSG | USD | 0710-000182-01-5 |
| 33. | United Kingdom | BARCLAYS BANK PLC 1 CHURCHILL PLACE, LONDON E14 5HP, UK | BARCGB22 Sort Code: 20-32-53 | GBP | 43379779 IBAN:GB33BARC20325343379779 |
| 34. | | STANDARD CHARTERED BANK NEW YORK, NY 10036, USA | SCBLUS33 | USD | 3582-026934-001 |
| 35. | USA | DEUTSCHE BANK TRUST COMPANY AMERICA NEW YORK, NY 10004, USA | BKTRUS33 | USD | 04453138 |
| 36. | | MASHREQ BANK PSC 255 AVENUE, NY10016, USA | MSHQUS33 | USD | 70010461 |

Худалдааны санхүүжилтээр хамтран ажиллагч банк санхүүгийн байгууллагууд

| | |
|--|---|
| Commerzbank AG, Frankfurt am Main, Germany | COMMERZBANK  |
| Deutsche Bank AG, Frankfurt am Main, Germany | Deutsche Bank  |
| Atlantic Forfaitierungs AG, Zurich Switzerland | atlantic forfaitierungs ag |
| Asian Development Bank, Manila, Philippines | ADB |
| Industrial & Commercial Bank of China | ICBC  中国工商银行 |
| Baoshang Bank, China |  包商银行 BAOSHANG BANK |
| The Export-Import Bank of the ROC, Taiwan |  The Export-Import Bank of the ROC |
| BHF-Bank AG, Frankfurt am Main, Germany | BHF  BANK PRIVAT SEIT 1854 |
| The Export-Import Bank of Korea, Seoul |  한국수출입은행 THE EXPORT-IMPORT BANK OF KOREA |
| Nordea Bank Denmark | Nordea  |
| Unicredit Bank |  UniCredit Bank |
| Hungarian EXIM Bank |  e x i m EXPORT FINANCE INSURANCE |
| BGK, Bank Gospodarstwa Krajowego, Poland |  BANK GOSPODARSTWA KRAJOWEGO |
| Vnesheconombank, Russia |  VNESHECONOMBANK |
| International Investment Bank, Russia |  INTERNATIONAL INVESTMENT BANK |
| SACE, Italy |  SACE |
| CSOB, Czech Republic |  CSOB |
| Kuveyt Türk Katılım Bankası, Turkey |  КУВЕЙТТÜRK |
| RosExim, Russia |  РОСЭКСИМБАНК |



ГОЛОМТ БАНК ГРУПП

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу
бэлтгэгдсэн Санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан

2016 оны 12 дугаар сарын 31





ГОЛОМТ БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

Байгууллагын талаарх мэдээлэл

| | | |
|--------------------------|---|---|
| Үүсгэн байгуулах шийдвэр | <p>Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн 100 хувийн охин компани болон анх үүсгэн байгуулагдсан.</p> <p>Голомт Секюритиз ХХК (цаашид “Охин Компани” гэх) нь 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу Голомт Банкны 100 хувийн эзэмшлийн охин компани болон Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.</p> | |
| Гэрчилгээ ба лиценз | <p>Банк нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг авсан.</p> <p>Банк нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг авсан.</p> <p>Охин Компани нь 5481589 тоот регистрийн дугаар бүхий 9011287134 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр авсан.</p> <p>Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 317 тоот шийдвэрээр Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх 3/97 тоот тусгай зөвшөөрлийг охин компани нь эзэмшдэг.</p> | |
| Төлөөлөн удирдах зөвлөл | Ч.Мөнхцэцэг З.Тэмүүн Урс Е.Шварценбах Д.Мөнхтөр Ж.Үнэнбат Лопез Абелло | ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн Хараат бус гишүүн Хараат бус гишүүн |
| Гүйцэтгэх Удирдлага | Ө.Ганзориг Г.Ганболд Томас Бравенец Б.Энхтуяа Н.Цэрэндаваа Т.Нямсүрэн М.Чимэгмөнх А.Энхбаяр Ё.Пүрэвбат У.Хосжаргал Д.Бадрал М.Сайнбилэг А.Одонбаатар | Гүйцэтгэх захирал Ерөнхийлөгч Гүйцэтгэх захирлын орлогч Гүйцэтгэх захирлын орлогч Гүйцэтгэх захирлын орлогч Гүйцэтгэх захирлын орлогч Санхүүгийн удирдлагын газрын захирал Эрсдэлийн удирдлагын газрын захирал Бүртгэл тооцооны газрын захирал Сувгийн удирдлагын газрын захирал Байгууллагын банкны газрын захирал Мэдээллийн технологийн газрын захирал Дотоод аудитын газрын захирал |

Голомт Банк Групп

| | |
|---------|---|
| Хаяг | Голомт Банк Голомт Банкны төв байр Сүхбаатарын талбай 5, Ш/х-22 Улаанбаатар 15160, Монгол улс |
| Аудитор | ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК Сентрал Тауэр, 6 давхар, 601 Сүхбаатарын талбай, СБД-8 Улаанбаатар, 14200, Монгол улс |

Хараат бус аудиторын тайлан

Голомт банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөлд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр Голомт банк ХХК (“Банк” гэх) болон түүний охин компани болох Голомт Секюритиз ХХК (хамтад нь “Групп”)-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны бие даасан санхүүгийн байдлын тайлан болон Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон бие даасан үйл ажиллагааны үр дүн, нэгтгэсэн болон бие даасан мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон Банкны бие даасан санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон бие даасан орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон бие даасан өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон бие даасан мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй, мөн нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудын тодруулга.

Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Групп-с бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлангуудын олон улсын стандартын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэх нь удирдлагын үүрэг бөгөөд мөн ийнхүү бэлтгэхэд шаардлагатай гэж үзвэл дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Группийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Группийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.



АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Групп нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Группийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлангуудыг тодруулгын хамт бүтэц, агуулга, ерөнхий толилуулгын хувьд суурь ажил гүйлгээ болон үйл явдлуудыг илэрхийлж чадан үнэн зөв тайлагналыг хангаж буй эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргахын тулд Групп доторх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар хангалттай бөгөөд хүрэлцээтэй аудитын нотолгоо олж авдаг. Бид Групп аудитын чиглүүлэлт, хяналт болон гүйцэтгэлийг хариуцдаг. Бид зөвхөн гаргасан дүгнэлтдээ хариуцлага хүлээдэг болно.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын доголдол багтдаг.


Гарын үсэг зурсан:
Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Мэттью Поттл
Партнер
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2017 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот
Жанжин Д.Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо
Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068, www.pwc.com/mn

Голомт Банк Групп
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

| Мянган төгрөгөөр | Тод-руулга | Групп | | Банк | |
|--|------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| Хөрөнгө | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкнд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад) | 7 | 317,585,827 | 158,189,289 | 316,801,192 | 158,124,287 |
| Монголбанкнд байршуулсан зайлшгүй байлгах нөөц | 8 | 315,633,095 | 260,739,412 | 315,633,095 | 260,739,412 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 9 | 395,641,113 | 5,442,398 | 395,422,594 | 5,410,038 |
| Урвуу репо хэлцэл | 10 | 9,995,766 | - | 9,995,766 | - |
| Бусад банкуудад байршуулсан хөрөнгө | 11 | 792,154,555 | 349,234,005 | 792,154,555 | 349,234,005 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 12 | 2,034,859,755 | 2,013,610,787 | 2,034,859,755 | 2,013,610,787 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас | 13 | 41,979,911 | - | 41,979,911 | - |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 14 | 126,165,928 | 68,088,050 | 126,165,928 | 68,088,050 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 15 | 121,553,766 | 594,170,820 | 120,274,349 | 592,831,917 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 16 | 51,291,334 | 1,209,050 | 51,291,334 | 1,209,050 |
| Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | 17 | - | - | 1,200,000 | 1,200,000 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 40 | 177,021,621 | 40,207,014 | 177,021,621 | 40,207,014 |
| Бусад хөрөнгө | 18 | 28,381,165 | 22,786,957 | 28,333,835 | 22,738,029 |
| Биет бус хөрөнгө | 19 | 13,948,312 | 14,740,580 | 13,946,737 | 14,735,999 |
| Үндсэн хөрөнгө | 20 | 171,022,155 | 176,633,646 | 171,008,642 | 176,618,746 |
| Өмчлөх бусад хөрөнгө | 21 | 44,809,609 | 100,094,904 | 44,809,609 | 100,094,904 |
| Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө | 22 | 17,444,424 | - | 17,444,424 | - |
| Нийт хөрөнгө | | 4,659,488,336 | 3,805,146,912 | 4,658,343,347 | 3,804,842,238 |
| Өр төлбөр | | | | | |
| Бусад банкуудын байршуулсан хөрөнгө | 23 | 121,902,017 | 90,000,670 | 121,902,017 | 90,000,670 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 24 | 2,803,875,469 | 2,079,828,919 | 2,803,327,560 | 2,079,800,594 |
| Зээлийн бусад эх үүсвэр | 25 | 1,195,869,997 | 1,014,934,955 | 1,195,869,997 | 1,014,934,955 |
| Репо хэлцэл | 26 | 37,408,551 | 174,280,920 | 37,408,551 | 174,280,920 |
| Орлогын татварын өглөг | 34 | - | 2,014,343 | - | 2,014,312 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 34 | 10,678,082 | 3,077,512 | 10,679,318 | 3,072,994 |
| Зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн сан | 39 | 793,072 | - | 793,072 | - |
| Бусад өр төлбөр | 27 | 34,093,768 | 12,381,355 | 34,055,598 | 12,355,514 |
| Хоёрдогч өглөг | 28 | 87,733,803 | 70,060,229 | 87,733,803 | 70,060,229 |
| Нийт өр төлбөр | | 4,292,354,759 | 3,446,578,903 | 4,291,769,916 | 3,446,520,188 |
| Эзэмшигчдийн өмч | | | | | |
| Давуу эрхтэй хувьцаа | 29 | 25,778,900 | 25,778,900 | 25,778,900 | 25,778,900 |
| Хувьцаат капитал | 29 | 26,367,593 | 26,367,593 | 26,367,593 | 26,367,593 |
| Нэмэгдэж төлөгдсөн капитал | | 46,583,557 | 46,583,557 | 46,583,557 | 46,583,557 |
| Хуримтлагдсан ашиг | | 240,998,876 | 247,780,795 | 240,438,730 | 247,534,836 |
| Өмчийн бусад хэсэг | | 27,404,651 | 12,057,164 | 27,404,651 | 12,057,164 |
| Нийт эзэмшигчдийн өмч | | 367,133,577 | 358,568,009 | 366,573,431 | 358,322,050 |
| Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | | 4,659,488,336 | 3,805,146,912 | 4,658,343,347 | 3,804,842,238 |

70

2017 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Банкны Удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

Ч.МӨНХЦЭЦЭГ
ТУС-ийн дарга

Ө.ГАНЗОРИН
Гүйцэтгэх захирал
ТТГ1075-2075377

М.ЧИМЭГМӨНХ
Санхүүгийн удирдлагын
газрын захирал

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 11-114 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

| Мянган төгрөгөөр | Тодруулга | Групп | | Банк | |
|---|-----------|-------------------|--------------------|-------------------|-------------------|
| | | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Хүүгийн орлого | 30 | 332,107,188 | 314,978,219 | 331,899,510 | 314,829,554 |
| Хүүгийн зардал | 30 | (246,411,088) | (213,293,561) | (246,415,535) | (213,295,342) |
| Хүүгийн цэвэр орлого | | 85,696,100 | 101,684,658 | 85,483,975 | 101,534,212 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн (зардал)/буцаалт | 12 | (51,903,798) | (49,703,415) | (51,903,798) | (49,703,415) |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардлын дараах хүүгийн цэвэр орлого | | 33,792,302 | 51,981,243 | 33,580,177 | 51,830,797 |
| Хураамж, шимтгэлийн орлого | 31 | 28,441,027 | 21,438,789 | 27,982,366 | 21,044,025 |
| Хураамж, шимтгэлийн зардал | 31 | (7,699,015) | (6,949,406) | (7,608,826) | (6,886,011) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг оруулан бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз | 9, 40 | 137,719,657 | 30,796,564 | 137,713,871 | 30,796,564 |
| Гадаад валют болон үнэт металын арилжаанаас үүссэн олз | | 15,124,620 | 14,145,897 | 15,124,620 | 14,143,685 |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн гарз | | (111,669,509) | (5,227,275) | (111,710,252) | (5,235,619) |
| Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал | 18 | (3,646,340) | (1,245,821) | (3,644,340) | (1,245,821) |
| Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал | 21 | (2,345,199) | (950,575) | (2,345,199) | (950,575) |
| Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал | | (793,072) | - | (793,072) | - |
| Ногдол ашгийн орлого | | 306,444 | 213,933 | 306,444 | 213,933 |
| Үйл ажиллагааны бусад орлого | 32 | 1,397,036 | 4,378,078 | 1,391,723 | 4,377,442 |
| Удирдлага болон үйл ажиллагааны бусад зардал | 33 | (77,568,743) | (75,792,857) | (77,251,293) | (75,362,030) |
| Татварын өмнөх ашиг | | 13,059,208 | 32,788,570 | 12,746,219 | 32,726,390 |
| Орлогын албан татварын зардал | 34 | (7,471,460) | (6,746,118) | (7,472,658) | (6,741,579) |
| Тайлант жилийн ашиг | | 5,587,748 | 26,042,452 | 5,273,561 | 25,984,811 |
| Бусад дэлгэрэнгүй орлого: | | | | | |
| <i>Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдаж болзошгүй зүйлс:</i> | | | | | |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт: | | | | | |
| - Тухайн жилийн цэвэр олз | | 534,662 | 6,539,214 | 534,662 | 6,539,214 |
| Шууд дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн татварын зардал | | (295,339) | (1,311,457) | (295,339) | (1,311,457) |
| <i>Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдахгүй зүйлс:</i> | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | 2,738,497 | - | 2,738,497 | - |
| Тайлант жилийн нийт бусад дэлгэрэнгүй (зардал)/орлого | | 2,977,820 | 5,227,757 | 2,977,820 | 5,227,757 |
| Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | | 8,565,568 | 31,270,209 | 8,251,381 | 31,212,568 |

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 11-114 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Голомт Банк Групп

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

| Мянган төгрөгөөр | Группийн эзэдэд хамаарах | | | | | | | | | |
|--|--------------------------|----------------------|-------------------|----------------------------|------------------------------------|----------------------------------|--|-------------------|--------------------|------------------------------|
| | Тодруулга | Давуу эрхтэй хувьцаа | Хувьцаат капитал | Нэмэгдэж төлөгдсөн капитал | Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц | ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц | Бусад нөөц | Хуримтлагдсан ашиг | Эзэмшигчдийн өмчийн нийт дүн |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,217,093 | 44,699,421 | 1,176,486 | (646,693) | 7,844,139 | - | 222,858,983 | 327,928,329 |
| Тухайн жилийн ашиг | | - | - | - | - | - | - | - | 26,042,452 | 26,042,452 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 35 | - | - | - | - | 5,227,757 | - | - | - | 5,227,757 |
| 2015 оны нийт дэлгэрэнгүй орлого | | - | - | - | - | 5,227,757 | - | - | 26,042,452 | 31,270,209 |
| АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа | 29 | - | 150,500 | 707,650 | - | - | - | - | - | 858,150 |
| Хувьцаанд суурилсан төлбөрийн буцаалт | | - | - | 1,176,486 | (1,176,486) | - | - | - | - | - |
| Зарласан болон төлсөн ногдол ашиг | 36 | - | - | - | - | - | - | - | (1,488,679) | (1,488,679) |
| Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | - | - | - | - | - | (368,039) | - | 368,039 | - |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,367,593 | 46,583,557 | - | 4,581,064 | 7,476,100 | - | 247,780,795 | 358,568,009 |
| Тухайн жилийн ашиг | | - | - | - | - | - | - | - | 5,587,748 | 5,587,748 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 35 | - | - | - | - | 239,323 | 2,738,497 | - | - | 2,977,820 |
| 2016 оны нийт дэлгэрэнгүй орлого | | - | - | - | - | 239,323 | 2,738,497 | - | 5,587,748 | 8,565,568 |
| Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 36 | - | - | - | - | - | (569,729) | - | 569,729 | - |
| МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн нөөц (Тодруулга 12) | | - | - | - | - | - | - | 12,581,184 | (12,581,184) | - |
| Тусгай зориулалтын нөөцрүү шилжүүлсэн нөөц | 4.27 | - | - | - | - | - | - | 358,212 | (358,212) | - |
| 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,367,593 | 46,583,557 | - | 4,820,387 | 9,644,868 | 12,939,396 | 240,998,876 | 367,133,577 |

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 8-114 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

| Мянган төгрөгөөр | Банкны эзэдэд хамаарах | | | | | | | | | |
|--|------------------------|----------------------|-------------------|----------------------------|------------------------------------|----------------------------------|--|-------------------|--------------------|------------------------------|
| | Тодруулга | Давуу эрхтэй хувьцаа | Хувьцаат капитал | Нэмэгдэж төлөгдсөн капитал | Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц | ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц | Бусад нөөц | Хуримтлагдсан ашиг | Эзэмшигчдийн өмчийн нийт дүн |
| 2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,217,093 | 44,699,421 | 1,176,486 | (646,693) | 7,844,139 | - | 222,670,665 | 327,740,011 |
| Тухайн жилийн ашиг | | - | - | - | - | - | - | - | 25,984,811 | 25,984,811 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 35 | - | - | - | - | 5,227,757 | - | - | - | 5,227,757 |
| 2015 оны нийт дэлгэрэнгүй орлого | | - | - | - | - | 5,227,757 | - | - | 25,984,811 | 31,212,568 |
| АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа | 29 | - | 150,500 | 707,650 | - | - | - | - | - | 858,150 |
| Хувьцаанд суурилсан төлбөрийн буцаалт | | - | - | 1,176,486 | (1,176,486) | - | - | - | - | - |
| Зарласан болон төлсөн ногдол ашиг | 36 | - | - | - | - | - | - | - | (1,488,679) | (1,488,679) |
| Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | - | - | - | - | - | (368,039) | - | 368,039 | - |
| 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,367,593 | 46,583,557 | - | 4,581,064 | 7,476,100 | - | 247,534,836 | 358,322,050 |
| Тухайн жилийн ашиг | | - | - | - | - | - | - | - | 5,273,561 | 5,273,561 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 35 | - | - | - | - | 239,323 | 2,738,497 | - | - | 2,977,820 |
| 2016 оны нийт дэлгэрэнгүй орлого | | - | - | - | - | 239,323 | 2,738,497 | - | 5,273,561 | 8,251,381 |
| Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | - | - | - | - | - | (569,729) | - | 569,729 | - |
| МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн нөөц (Тодруулга 12) | | - | - | - | - | - | - | 12,581,184 | (12,581,184) | - |
| Тусгай зориулалтын нөөцрүү шилжүүлсэн нөөц | 4.27 | - | - | - | - | - | - | 358,212 | (358,212) | - |
| 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | 25,778,900 | 26,367,593 | 46,583,557 | - | 4,820,387 | 9,644,868 | 12,939,396 | 240,438,730 | 366,573,431 |

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 8-114 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

| Мянган төгрөгөөр | Тодруулга | Групп | | Банк | |
|---|-----------|--------------------|----------------------|--------------------|----------------------|
| | | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | | |
| Татварын өмнөх ашиг | | | | | |
| | | 13,059,208 | 32,788,570 | 12,746,219 | 32,726,390 |
| Тохируулгууд: | | | | | |
| Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны | | | | | |
| үнэ цэнийн бууралт | 12 | 51,903,798 | 49,703,415 | 51,903,798 | 49,703,415 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз | 9,40 | (137,716,201) | (30,796,564) | (137,713,871) | (30,796,564) |
| Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг | | - | (636) | - | - |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн | | | | | |
| цэвэр алдагдал | | 111,667,665 | 5,227,275 | 111,710,252 | 5,235,619 |
| Бусад хөрөнгийн үнэ цэний бууралт | 18 | 3,646,340 | 1,245,821 | 3,644,340 | 1,245,821 |
| Аккредитив, баталгааны үнэ цэнийн бууралтын сангийн зардал | | 793,072 | - | 793,072 | - |
| Элэгдлийн зардал | 20 | 9,665,371 | 9,252,991 | 9,661,969 | 9,248,578 |
| Хорогдуулалтын зардал | 19 | 2,849,105 | 4,503,962 | 2,845,311 | 4,499,708 |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө | 20 | (244,481) | 315,510 | (244,481) | 315,510 |
| Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн | | | | | |
| бууралт | 21 | 2,345,199 | 950,575 | 2,345,199 | 950,575 |
| Мөнгөн бусаар хүлээн авсан ногдол ашиг | | - | 213,933 | - | 213,933 |
| Хүүгийн орлого | 30 | (332,111,635) | (314,978,219) | (331,899,510) | (314,829,554) |
| Хүүгийн зардал | 30 | 246,415,535 | 213,293,561 | 246,415,535 | 213,293,342 |
| Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ | | | | | |
| | | (27,727,024) | (28,279,806) | (27,792,167) | (28,191,227) |
| Монголбанкинд байршуулсан, зайлшгүй байлгах нөөцийн цэвэр (өсөлт)/бууралт | | | | | |
| | | (54,893,683) | 17,978,675 | (54,893,683) | 17,978,675 |
| Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт) | | | | | |
| | | 59,837,125 | (199,047,369) | 59,837,126 | (199,047,369) |
| Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны цэвэр өсөлт | | | | | |
| | | (32,946,006) | (155,404,681) | (32,946,006) | (155,404,681) |
| Бусад хөрөнгийн цэвэр өсөлт | | | | | |
| | | (6,671,097) | (10,844,015) | (6,524,386) | (9,794,501) |
| Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр өсөлт | | | | | |
| | | (67,526,708) | - | (67,526,708) | - |
| Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн | | | | | |
| цэвэр өсөлт/(бууралт) | | 21,570,424 | (42,629,867) | 21,570,424 | (42,629,867) |
| Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт/(бууралт) | | | | | |
| | | 471,832,917 | (162,408,755) | 471,259,423 | (162,408,755) |
| Бусад санхүүгийн өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт) | | | | | |
| | | 18,644,377 | (14,994,007) | 18,664,629 | (14,954,876) |
| Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагаанаас орсон/ (үйл ажиллагаанд зарцуулсан) цэвэр мөнгө | | 382,120,325 | (595,629,825) | 381,648,652 | (594,452,601) |
| Төлсөн орлогын албан татвар | | | | | |
| | | (2,014,343) | (4,552,279) | (2,014,312) | (4,544,841) |
| Хүлээн авсан хүү | | | | | |
| | | 265,927,495 | 281,427,485 | 265,715,369 | 281,258,500 |
| Төлсөн хүү | | | | | |
| | | (243,138,932) | (204,155,776) | (243,138,932) | (204,153,925) |
| Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө | | 402,894,545 | (522,910,395) | 402,210,777 | (521,892,867) |

Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

| Мянган төгрөгөөр | Тодруулга | Групп 2016 | 2015 | Банк 2016 | 2015 |
|---|-----------|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | | | | |
| Санхүүгийн хөрөнгө оруулалтын | | | | | |
| худалдан авалт | | (252,257,181) | (96,781,862) | (252,257,181) | (97,781,862) |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт | | | | | |
| борлуулсны орлого | | 60,262,660 | 41,638,772 | 60,262,660 | 41,638,772 |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | | (5,093,775) | (94,013,459) | (5,091,827) | (93,996,055) |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 20 | 3,453,211 | 445,997 | 3,453,211 | 434,477 |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 19 | (2,056,837) | (5,434,785) | (2,056,049) | (5,426,390) |
| Хөрөнгө оруулалтад зарцуулсан цэвэр мөнгө | | (195,691,922) | (154,145,337) | (195,689,186) | (155,131,058) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | | |
| Нэмж гаргасан хувьцаанаас хүлээн авсан | | - | 858,150 | - | 858,150 |
| Репо хэлцлээс хүлээн авсан | | 610,385,555 | 1,067,333,211 | 610,385,555 | 1,067,333,211 |
| Репо хэлцлийн эргэн төлөлт | | (747,335,984) | (1,144,599,240) | (747,335,984) | (1,144,599,240) |
| Зээлийн бусад эх үүсвэрээс хүлээн авсан | | 268,144,839 | 664,996,430 | 268,144,839 | 664,996,430 |
| Зээлийн бусад эх үүсвэрийн эргэн төлөлт | | (156,480,679) | (224,354,043) | (156,480,679) | (224,354,043) |
| Ногдол ашгийн төлөлт | 28 | - | (1,488,678) | - | (1,488,678) |
| Санхүүгийн үйл ажиллагаанд (зарцуулсан)/орсон мөнгөн гүйлгээ | | (25,286,269) | 362,745,830 | (25,286,269) | 362,745,830 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлт | | | | | |
| | | (108,762,030) | 2,821,108 | (108,800,631) | 2,821,108 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт) | | | | | |
| | | 73,154,324 | (311,488,794) | 72,434,691 | (311,456,987) |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | | |
| | | 732,249,612 | 1,043,738,406 | 732,184,610 | 1,043,641,597 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 7 | 805,403,936 | 804,619,301 | 732,184,610 |

Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө шаардагдаагүй МИК-ТЗК-ийн хэлцлүүд нь Мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 3 болон 14-аас үзнэ үү.

1 Танилцуулга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Голомт Банк ХХК (“Банк”) болон Голомт Секюритиз ХХК (“Охин Компани”, хамтад нь “Групп” гэх)-ийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэгдсэн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкийг шууд хянадаг, эцсийн шатны толгой компани нь Голомт Файнэншил Групп ХХК (2015 оны 12 дугаар сарын 31: Голомт Файнэншил Групп ХХК) байна. Банк нь Монгол Улсад бүртгэгдсэн, мөн тус улсад албан ёсны хаягтай юм. Банк нь хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд анх Бодь Интернэйшл ХХК (Банкны өмнөх толгой компани)-ийн 100 хувийн охин компанийн хэлбэрээр Бодь Интернэйшл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Монгол Улсын хууль, эрх зүйн дагуу үүсгэн байгуулагдсан. 2014 онд өмнөх шууд хянадаг, эцсийн шатны толгой компани болох Бодь Интернэйшл ХХК нь оруулсан өөрийн хөрөнгө оруулалтаа дахин бүтэцчилж, Банкин дахь эзэмшлийн бүх хувьцааг Монгол улсад шинээр бүртгэгдсэн Голомт Файнэншил Групп ХХК-д шилжүүлсэн.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт Файнэншил Групп ХХК-ийн эзэмшигч Д.Баясгалан нь 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт Банкны шууд хянадаг, эцсийн шатны эзэмшигч юм.

2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны хувь эзэмшигчдийн талаарх мэдээллийг Тодруулга 29-аас үзнэ үү.

Банк нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас олгосон 2075377 тоот регистрийн дугаартай, 9016001014 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээтэй. Банк нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Монголбанкнаас (“МБ”) олгосон банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот тусгай зөвшөөрлийг авсан.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж;
- Зээлийн үйлчилгээ;
- Картын үйлчилгээ;
- Баталгаа ба аккредитив;
- Мөнгөн шилжүүлэг;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Үнэт метал худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Гадаад төлбөр, тооцоо;
- Үнэт цаас гаргах, арилжаалах;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах;
- Кастодиан банкны үйлчилгээ;
- Хууль эрх зүйн хүрээнд хязгаарлаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болон Монголбанк ба Засгийн Газрын байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

Банк нь 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 163 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос (“СЗХ”) авсан.

Банк нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад 68 салбар, тооцооны төвтэй (2015 оны 12 дугаар сарын 31: 71 салбар, тооцооны төвтэй), мөн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 20 касс (2015 оны 12 дугаар сарын 31: 26 касс)-тайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны ажилтны тоо 1,769 (2015 оны 12 дугаар сарын 31: 1,872) байсан.

Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг, компанийн байршил нь: Монгол Улс, Улаанбаатар хот-15160, Сүхбаатарын талбай 5, шуудангийн хайрцаг-22 байна.

Голомт Банк ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох Голомт Секюритиз ХХК (“Охин Компани”) нь Монгол Улсын хууль, эрх зүйн дагуу болон 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Банкны 1 тоот шийдвэрийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Охин Компани нь 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, 5481589 тоот регистрийн дугаар, 9011287134 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

Охин компани нь Үнэт Цаасны Зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх 3/97 тоот Тусгай Зөвшөөрлийг 2011 оны 11 дугаар сарын 02-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 317 тоот тогтоолын дагуу авсан.

Охин компанийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Брокерийн үйл ажиллагаа;
- Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйлчилгээ;
- Андеррайтингийн үйлчилгээ;

2 Группийн үйл ажиллагааны орчин

2.1 Ерөнхий

Байгалийн арвин их эрдэс баялагтай, далайд гарцгүй Монгол улсын эдийн засаг нь хүүгийн түвшин өндөр бөгөөд зах зээлийн тогтворгүй шинж тэмдгүүд бүхий хөгжиж буй зах зээл юм. Түүнчлэн олон улсын хөрөнгө оруулагчид нь Монгол улсыг өндөр өсөлт үзүүлэх боломжтой эдийн засаг гэж үздэг. Монголын эдийн засаг нь Оюу толгой (ОТ), Таван толгой зэрэг цөөн тооны томоохон уул уурхайн төслүүдээс ихээхэн хамаардаг. 2010 болон 2011 онуудад эдийн засгийн өндөр өсөлтийг үзүүлсэн боловч таваарын үнийн бууралт, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт, гадаадын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн өөрчлөлт зэргээс хамааран 2012 оноос эхлэн Монголын эдийн засгийн өсөлт удааширч эхэлсэн.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт, төгрөгийн ханшийн уналт, гадаад өрийн асуудал болон улс төрийн тогтворгүй байдлууд нь 2016 онд Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлж, 3-р улиралд эдийн засаг бууралттай гарахад хүргэсэн. Энэхүү бууралт нь голлон барилга болон худалдааны салбарт ажиглагдсан. Эдийн засгийг эрэлтийн талаас тайлбарлавал, өрхийн хэрэглээ болон хөрөнгө оруулалт буурсан. Нийт ажил эрхэлдэг хүний тоо өссөн боловч ажилгүйдлийн түвшин өссөн үзүүлэлттэй байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өрхийн орлого, зарлага аль аль нь өссөн дүнтэй байсан. 2016 онд инфляци огцом буурч, Төв Банкны мөнгөний бодлогод тусгасан 8%-ийн инфляцийн түвшнээс эрс бага байсан.

2012 оноос хойш төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсаар байв. Хангалттай гадаад валютын орох урсгалгүйн улмаас гадаад валютын албан нөөц буурч, 2016 оны 12-р сар хүртэл ам.долларын эсрэг төгрөгийн ханш ихээхэн суларсан. Гадаад өрийн асуудал болон эдийн засгийн өсөлтийн сааралттай холбоотойгоор засгийн газрын зүгээс ОУВС-ын санхүүжилт авах ажлыг эхлүүлж, томоохон төслүүд дээрээ тулгуурласан эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг боловсруулсан. Мөн засгийн газар нь өөр бусад санхүүжилтийн боломжуудын тухай ч хэлэлцэж байгаа юм.

2016 оны 8-р сард Мүүдийс агентлагаас Монгол улсын зээлжих зэрэглэлийг В3 болгон бууруулсан бөгөөд 11-р сард зэрэглэлийг дахин бууруулж Саа1 болгосон. Тус онд эдийн засгийн зэрэг өөрчлөлтүүд ч мөн гарсан. Экспорт тоо хэмжээний хувьд их, импорт бага байснаар төлбөрийн тэнцэл эерэг болж чадсан. Оюу толгойн нэг дүгээр шатны бүтээн байгуулалт хийгдэхэд Монгол дэлхийн хамгийн өндөр эдийн засгийн өсөлттэй улс болж байсан бол 2016 онд хоёр дугаар шатны бүтээн байгуулалт эхэлсэн. Мөн засгийн газар эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөр нь ирэх онд эдийн засгийг сэргээх 17 зорилго, 104 зорилттой бөгөөд 5-н томоохон төслөө хөдөлгөхөд чиглэгдсэн. Эдгээр томоохон төслүүд нь Таван толгойн уурхай, Таван толгойн цахилгаан станц, Таван толгойн төмөр зам, Гацуурт уурхай, Оюу толгойн хоёр дугаар шатны хөгжүүлэлт юм. 2016 онд олон улсын зах зээл дээр ч мөн адил эерэг өөрчлөлтүүд гарсан. БНХАУ эрэлт ихэссэнтэй холбоотойгоор 11-р сараас хойш Монголын голлох экспортын бүтээгдэхүүнүүд болох нүүрс, зэсийн үнэ нэмэгдсэн.

Монголын санхүүгийн зах зээл нь төвлөрөл өндөртэй ба цөөн тооны банкууд голлох байр суурийг эзэлдэг. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал нь банкуудад сөргөөр нөлөөлж, чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтийг өгсгөсөн. 8 хувийн ипотекийн зээлийн хувьд хэд хэдэн удаа санхүүжилт зогссоныг эс тооцвол амжилттай хэрэгжиж байгаа. Түүнчлэн Төв Банк нь тус хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэхээ мэдэгдсэн. Төв Банкны зүгээс мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, энэ нь банкуудын харилцах, хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэсэн. Улмаар актив талаас гадаад актив голлон нэмэгдсэн. 2016 онд Төв Банк валютын ханшийг тогтворжуулах зорилготойгоор бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн боловч 12 сард ханш тогтворжихын хэрээр бодлогын хүүг бууруулах боломж бүрдэж 1 нэгж хувиар бууруулсан.

Монгол улсын татвар, эрх зүйн орчин сайжруулах ажлууд хийгдсээр байгаа. Ялангуяа Монгол улсын татвар, гаалийн зохицуулалтуудтай холбоотой эрх зүйг сайжруулах ажлууд хийгдсээр байгаа. Үүнд татвар болон гаалийн тухай хуулийн өөрчлөлтүүд, түүний тайлбаруудыг хэлж болно (39-р тодруулгаас харах). Эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдал нь БНХАУ-ын эрэлт, таваарын үнэ зэргээс голлон амаарна. Мөн засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнтэй байдал, хууль, эрх зүйн сайжруулалтаас хамааралтай.

Банкны удирдлага нь СТОУС-д нийцтэйгээр зээлийн эрсдэлийн санг "учирсан алдагдлын" загвар ашиглаж тооцохоор шийдвэрлэсэн. Үнэ цэнийн бууралтыг өнгөрсөн үйл явдалд үндэслэн хийх ба ирээдүйд учирч болзошгүй үйл явдлаас үнэ цэнийн бууралт хийх нь хориотой. Тухайлбал ирээдүйд болох үйл явдалд эдийн засгийн орчны өөрчлөлтийг авч үзнэ. Хэдийгээр ирээдүйд болох үйл явдал нь өндөр магадлалтай байсан ч үнэ цэнийн бууралтыг хийж болохгүй. Иймд активын үнэ цэнийн бууралт нь одоогийн эрсдэлийн сангийн хэмжээнээс их хэмжээгээр зөрүүтэй байх боломжтой.

Голомт Банк Групп

2 Группийн үйл ажиллагааны орчин (үргэлжлэл)

2.1 Ерөнхий (үргэлжлэл)

Удирдлага нь Монголын эдийн засагт нөлөө үзүүлж болох ирээдүйн үйл явдлыг урьдчилан харах боломжгүй бөгөөд улмаар тэдгээр нь Банкны ирээдүйн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж болохыг таамаглах бололцоогүй билээ. Хэдий тийм боловч удирдлага нь Банкны бизнесийн тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардагдах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2.2 Валютын арилжаа

Голлох гадаад валют болох Ам.доллар болон Евро зэрэг нь Монгол Улсын ихэнх бизнесийн төлбөр тооцоонд ашиглагдаж, суурь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Доорх хүснэгт нь Монгол Улсын Төв Банкнаас зарласан Ам.доллар болон Еврогийн Төгрөгтэй харьцах ханшийг харуулав.

| Огноо | Ам.доллар | Евро |
|----------------------|-----------|----------|
| 2016 оны 12 сарын 31 | 2,489.53 | 2,605.79 |
| 2015 оны 12 сарын 31 | 1,995.98 | 2,182.70 |
| 2014 оны 12 сарын 31 | 1,885.60 | 2,293.36 |
| 2013 оны 12 сарын 31 | 1,654.10 | 2,275.63 |
| 2012 оны 12 сарын 31 | 1,392.10 | 1,835.83 |
| 2011 оны 12 сарын 31 | 1,396.37 | 1,806.76 |

3 Тайлан бэлтгэх үндэслэл

3.1 Ерөнхий зарчмууд

Эдгээр Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон Банкны тусдаа санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу, санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх, мөн борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг дахин үнэлэн бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн.

Групп болон Банк нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС-тай бүх материаллаг зүйлсийн хувьд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн суурийн дагуу бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг тодруулга 4-т толилуулав.

Монголбанкны тайлан бэлтгэх журмын дагуу эдгээр нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудийн тодруулгууд нь Групп болон Банкны хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчдийн өмч, орлого болон зардлын дүн болон бусад тодруулгуудыг багтаасан болно. Групп болон Банкны дүнгүүд өөр тохиолдолд, Группийн санхүүгийн байдал болон ажил гүйлгээ нь холбогдох тодруулгуудад тусгагдсан болно.

3.2 Гүйлгээний болон тайлагналын валют

Группийн үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют байна. Банкны болон түүний охин компанийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группийн гүйлгээний болон тайлагналын валют болох Монгол улсын Үндэсний Төгрөг ("төгрөг")-өөр илэрхийлэгдсэн ба өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүдийг мянганчлан илэрхийлсэн.

3.3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд

Санхүүгийн тайланг бэлтгэх нь санхүүгийн тайлан бэлтгэсэн өдрөөр тайлагнасан болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дүн, тайлагналын өдрөөрх болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн нэмэлт тодруулга, тайлант хугацааны орлого болон зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх тооцоолол болон таамаглалыг шаарддаг. Удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх тухайн нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт зэрэг бусад хүчин зүйлүүдэд үндэслэдэг чухал тооцоолол дүгнэлтүүд нь байнга дахин хянагдаж байдаг. Удирдлага нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ тооцоололоос гадна тодорхой дүгнэлт хийдэг. Нэгтгэсэн Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна. Үүнд:

(i) Зээл болон урьдчилгааны үнэ цэнэ бууралтын гарз

Групп зээлийн багцын үнэ цэнэ бууралтыг тогтмол эргэн шалгадаг. Үнэ цэнэ бууралтын гарзыг тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо Групп зээлийн багц доторх дан ганц зээлийн хувьд үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг тодорхойлохын өмнө, тухайн багцын ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгал хэмжихүйц хэмжээгээр буурсны шинж тэмдэг илэрснийг харуулсан нээлттэй мэдээлэл байгаа эсэх талаар шийдвэр гаргадаг. Энэ нотолгоонд бүлэг доторх зээлдэгчдийн төлбөр төлөх байдалд, мөн тухайн бүлэг доторх хөрөнгийн нөхөн төлөгдөх байдалтай уялдаа холбоотой дотоодын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх өөрчлөлтүүдийн талаарх нээлттэй олдох мэдээлэл орсон байж болно. Удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалыг товлохдоо ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай хөрөнгийн зүйлүүдийн хувьд хохирол учирсан түүхэн мэдээлэл, мөн багц доторхи хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаарх бодит нотолгоон дээр үндэслэн тооцоолол хийдэг.

Тооцоолсон байсан гарзыг бодитоор үүссэн гарзын хэмжээтэй ойртуулах үүднээс ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацааг тооцоолоход ашигласан аргачлал болон үндэслэлүүдийг тогтмол эргэн хянадаг.

Бодитоор үүсэх гарзын хэмжээг тооцоолсон гарзын хэмжээнээс 20 хувиар ихэсгэх буюу бууруулахад зээлийн үнэ цэнийн бууралтын гарз 18,143,242 мянган төгрөгөөр (2015: 19,018,891 мянган төгрөгөөр) ихсэх буюу буурна. Өндөр дүнтэй тусгай зээлүүдийн үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн зээл бүрийн аливаа эргэн төлөлт болон зээлийн барьцаа хөрөнгийг борлуулснаас орж ирэх мөнгөн урсгал зэргийг харгалзан үзэж ирээдүйн мөнгөн урсгалыг хямдруулсан дүнд үндэслэн тооцоолдог.

(ii) Барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ

Групп нь барилга байгууламжийг үнэлэхдээ дахин үнэлгээний арга ашигладаг ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлдэг. Банкны НБББББ болон холбогдох СТОУС-ын дагуу Группийн дотоодын үнэлгээний мэргэжилтнүүд барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ болон зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлтийг хянадаг. Дотоодын үнэлгээний мэргэжилтнүүдийн үнэлгээгээр Группийн барилга байгууламжийн бодит үнэ цэнэ 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,738,497 мянган төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлт нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Группийн эзэмшигчдийн өмч дэх дахин үнэлгээний нөөцийг нэмэгдүүлсэн.

Барилга байгууламж, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг үнэлсэн тус мэргэжилтний ашигласан суурь нь харьцуулагдах зах зээлийн мэдээлэлд үндэслэсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ юм. 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Группийн нийт барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо идэвхтэй зах зээл дээрх зах зээлийн үнийг ашигласан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 16 болон 20-с үзнэ үү.

Хэрэв барилга байгууламжийн дундаж үнэлгээг одоогийн дансны үнээс 10 хувиар ихэсгэвэл/багасгавал 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт барилга байгууламж болон түүний дахин үнэлгээний нөөцийн дансны үнэ ойролцоо дүнгээр 14,425,467 мянган төгрөгөөр өснө/буурна (2015 оны 12 дугаар сарын 31: 14,541,873 мянган төгрөгөөр). Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнийн өөрчлөлтийн нөлөө нь материаллаг бус байх магадлалтай байна.

(iii) Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэр

Банк нь Монгол Улсын Засгийн Газар (Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголбанк г.м), төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацаат санхүүжилтийг хэвийн үед зээлүүлдэг зээлийн хүүтэй ижил хүүгээр авдаг бөгөөд тус зээлийн хүү нь Банкны бусад зээлдүүлэгчдээс авдаг зээлийн хүүгээс доогуур байж болзошгүй. Ийм санхүүжилтийн үр дүнд Банк эдгээр эх үүсвэрүүдийг зээлдүүлэгчийн тодорхойлсон зорилтот харилцагч нарт ашигтай нөхцөлтэйгөөр зээлүүлэх боломжтой юм. Удирдлага эдгээр хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олз, гарз үүссэн эсэхийг авч үзсэн. Уг ажил гүйлгээнүүд нь холбоогүй этгээдүүдтэй хийгддэг тул удирдлагын үнэлэлтээр эдгээр эх үүсвэрүүд болон холбогдох зээл олголтууд нь зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэхгүй гэж үзсэн. Уг үнэлэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүд нь тусгай зах зээл (тусгай сегмент г.м) болдог гэж үзэж байгаа.

Мөн түүнчлэн дээрх удирдлагын үнэлэмжид Засгийн газрын санаачлагаар Монголбанкны Үнэ Тогтворжуулах Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй 4 хувийн хүүтэй эх үүсвэртэй, харилцагчид 8 хувийн хүүтэй олгогдож буй Ипотекийн орон сууцны зээлийн хөтөлбөр хамрагдаж байна.

Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэрүүд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 595,840,669 мянган төгрөг (2015 оны 12 дугаар сарын 31: 478,754,724 мянган төгрөг)-ийн дүнтэй байсан. Энэ талаарх мэдээллийг тодруулга 25-т толилуулсан.

3.3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд (үргэлжлэл)

(iv) Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (ипотекийн зээлийн багцыг үнэт цаасжуулах ажил гүйлгээ)

2016 онд Банк нь 2 удаагийн МИК-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасны хэлцэлд оролцсон. Банк нь 8%-ийн хүүтэй зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпорацийн 100 хувийн эзэмшлийн компани болох МИК ТЗК8, МИК ТЗК9 тусгай зориулалтын компанид зарж, 4.5%-ийн хүүтэй, давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд мөн 10.5%-ийн хүүтэй, энгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд хүлээн авсан. МИК, тусгай зориулалтын компанийн худалдан авсан зээлийн багц нь буцаах нөхцөлгүй. Давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр хийгдсэн тохиолдолд энгийн үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй. Банк нь зарагдсан зээл бүрийн хувьд Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх ба үйлчилгээний шимтгэлд цуглуулсан төлбөрөөс 2.5 хувийн шимтгэл авна. МИК-д үлдсэн цэвэр хөрөнгө нь (хэрэв байгаа бол) МИК-ийн хувьцаа эзэмшигчдэд очно. Түүнчлэн, МИК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид МИК-д буцаах нөхцөлгүйгээр хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр). Энэхүү гэрээний дагуу Банкны эзэмшиж буй давуу эрхтэй үнэт цаас нь Монголбанкнаас анх 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийг санхүүжүүлэх зорилгоор авсан 4 хувийн хүүтэй эх үүсвэрийг буцаан төлөхөд ашиглагдана.

Эдгээр зээлүүд нь НББОУС 39 -ийн 36-д заасан данснаас хасах шаардлагыг хангасан эсэхийг Удирдлага үнэлж үзсэн. Мөнгөн хөрөнгийн эрхийн хугацаа дуусаагүй байгаа боловч эдгээр 8 хувийн Орон сууцны зээлийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ шилжүүлснээр бүх эрсдэл өгөөжийг давхар шилжүүлсэн гэж Удирдлага үзсэн. Тус шийдвэрийг гаргахдаа удирдлага банк бүрийн бүлгийн буюу ерөнхий эрсдлийн багц нь өөр өөр зээлдэгч, үүрэг хүлээгч, ипотекийн хөрөнгийн байршил зэргээс хамаараад зарсан зээлийн эрсдлийн багцаас эрс ялгаатай гэж үзсэн. Мөн эдгээр хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөхөд ашиг алдагдал үүсэх эсэхийг тооцсон.

Эдгээр хэлцлийг зах зээл дээр оролцогчид сайн дураараа хийсэн ба уг хэрэглүүрүүд нь зах зээлийн хүүтэй тул ашиг алдагдлыг анх хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж Удирдлага үзсэн. Түүнчлэн шийдвэр гаргахдаа Удирдлага нь эдгээр хэрэглүүр нь зах зээлийн тусдаа сегмент (тусдаа зах зээл) болохыг бодолцож үзсэн.

(v) Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-д оруулсан хөрөнгө оруулалт

Тодруулга 14-д заасны дагуу 2014 оны 12 дугаар сарын сүүлээр Банк нь Монгол Улсад байгуулагдсан анхны хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийсэн. Ингэснээр 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн 10 хувийг Банк эзэмшиж, үлдсэн нэгжийн 90 хувь нь энэхүү санхүүгийн тайлангийн батлагдсан өдрийн байдлаар бусад худалдагдаагүй байсан. Удирдлагын зүгээс Банк нь тус хөрөнгө оруулалтын санг удирдах эрхгүй ба үйл ажиллагааны чиглэлд нөлөөлж чадахгүй гэж үзсэн тул уг хөрөнгө оруулалтыг НББОУС 39-д заасны дагуу борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт гэж ангилсан. Энэхүү дүгнэлтэд хүрэхийн тулд удирдлага нь доорх зүйлсийг авч үзсэн:

- 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн хөрөнгө оруулалтын сан нь Банкинд хамааралгүй удирдлагын багтай бөгөөд Банкны эзэд болон удирдлагын зүгээс уг ХОС-н удирдлагыг өөрчлөх ямар нэгэн эрхгүй;
- Хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын зүгээс үлдэгдэл нэгжийн 90 хувьд хөрөнгө оруулагчийг идэвхтэй хайж байгаа бөгөөд хэрэв тухайн нэгжид хөрөнгө оруулагч олдохгүй тохиолдолд ХОС үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрэх магадлалтай;
- Түүнчлэн холбогдох хуулийн болон гэрээний хүрээнд Голомт Банк болон бусад хөрөнгө оруулагчид ХОС-н удирдах компанийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалт болон хараат бус байдалд нөлөөлөх нь хориглогдсон;
- Голомт Банк нь хамгийн ихдээ өөрийн оруулсан хөрөнгө оруулалтыг алдаж болох ба бусад хөрөнгө оруулагчдын алдагдлыг үүрэх ямар нэгэн үүрэг байхгүй. Ашиг өгөөжийн хувьд Банк нь зөвхөн өөрийн оруулсан хөрөнгө оруулалтад хамаарах хэсгийн хүртэх ба бусад хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой аливаа урамшууллаас хүртэх эрхгүй;
- Банк нь тухайн ХОС-н хөрөнгө оруулалтын шийдвэрт оролцохгүй бөгөөд удирдлагын компани бие даан бусад төрлийн хөрөнгө оруулалтыг хийх шийдвэр гаргана.

(vi) Тасралтгүй байх зарчим

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын бизнесийн орчны нөлөөлөл Группийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд нөлөөлөх Группийн удирдлагын өнөөгийн үнэлгээг тусгасан. Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн хандлага нь Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон улс төр зохицуулалтын хөгжлөөс шууд хамаарна. Энэ нь Группийн хяналтаас гадуур юм. Эдгээр хүчин зүйлс нь ирээдүйд Группийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлөхийг Группийн удирдлагууд таамаглаж чадахгүй юм.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмыг баримталсан. Группийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон хөрвөх чадварын эрсдлийн менежментийг Тодруулга 37-өөс үзнэ үү. Хөрвөх чадварын эрсдлээ цаг алдалгүй удирдахын тулд Групп нь Группийн хөрвөх чадварын түвшинд нөлөө үзүүлж болох гадаад хүчин зүйлсийг тогтмол хянаж, мөнгөн урсгалаа төлөвлөдөг. Хөрвөх чадварын дунд болон урт хугацааны эрсдлийг удирдахдаа хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны зөрүүтэй байдлыг шинжилдэг. Эрсдэлд өртөх магадлалыг бууруулахын тулд Групп хөрвөх чадварын зөрүүний хязгаар тогтоодог бөгөөд энэхүү тогтоосон хязгаарыг гадаад болон дотоод орчны өөрчлөлттэй уялдуулан тогтмол хугацаагаар шалгадаг.

Хөрвөх чадварын шаардлагатай түвшинг хадгалахын тулд Групп болон Банк нь Монголбанкнаас болон банк хоорондын зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжтой. Хөрвөх чадварын эх үүсвэрийг төрөлжүүлэх нь Группийг ямар нэг эх үүсвэрээс хараат байх эрсдлийг хамгийн бага түвшин хүртэл бууруулж өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжийг олгодог. Группийн хуримтлуулсан өнөөгийн хөрвөх чадварын байдал болон нэмэлт санхүүжилт бий болгох боломжит эх үүсвэр зэрэг нь Группийг урт хугацааны турш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг олгодог. Өнгөрсөн үеийн түүхээс үндэслэн харахад харилцагчийн харилцах болон хадгаламж нь Банкны тогтвортой, урт хугацааны эх үүсвэрийг бүрдүүлж буй томоохон хэсэг юм. Тодруулга 37-оос дэлгэрэнгүйг харна уу.

Мөн Банк нь ойрын ирээдүйд тогтвортой үйл ажиллагаагаа явуулна гэж дүгнэхэд Удирдлагын зүгээс Банк нь хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй (Тодруулга 38), толгой компаниас авсан нэг сарын дотор хөрвөх чадвартай томоохон хэмжээний санхүүгийн хөрөнгө болох хоёрдогч өглөг, түүний дуусах хугацааг сунгах боломж зэрэг боломжит санхүүжилт болон өөр бусад хүчин зүйлсийг тооцож үзсэн. Тодруулга 37-оос дэлгэрэнгүйг харна уу.

(vii) Ханшийн тэгшитгэлийн зөрүү болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хойшлогдсон татвар

Одоо мөрдөгдөж буй татварын хууль тогтоомж болон холбогдох нэмэлт татварын хууль тогтоомжинд үүсмэл санхүүгийн хэрэглэлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз гарзад хойшлогдсон татвар хүлээн зөвшөөрөх талаар тусгаагүй байдаг. Холбогдох татварын хууль нь зөвхөн ханшийн тэгшитгэлийн олз, гарзын татварыг хэрхэн тооцох талаар тусгасан бөгөөд байгууллагын орлогын албан татварын хуульд зөвхөн хэрэгжсэн ханшийн тэгшитгэлийн олзод татвар ногдуулна, хэрэгжсэн гарзыг татвар ногдуулах орлогоос хасна, хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжих хугацааг хойшлуулж бүртгэнэ хэмээн заасан. Тиймээс орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөртөл татвар төлөхгүй орлого болон татвар ноогдох орлогоос хасахгүй зардал гэж үздэг ба дээрх хэрэгжээгүй олз, гарз нь татварын түр зөрүү үүсгэдэг. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн зөвшөөрсөн цэвэр хойшлогдсон татварын өглөг нь 20,290,007 мянган төгрөг (2015 оны 12 дугаар сарын 31: 10,051,754 мянган төгрөг) байна. Дэлгэрэнгүйг тодруулга 34-ээс харна уу.

Групп нь санхүүгийн баталгаа болон зээл олгох үүрэг хүлээх үйлчилгээ үзүүлдэг. Санхүүгийн баталгаа нь гуравдагч этгээдэд хүлээсэн үүргээ харилцагч биелүүлж чадаагүй тохиолдолд Банк харилцагчийн өмнөөс төлбөр гүйцэтгэхээр буцалтгүй нөхцлөөр олгосон баталгаа бөгөөд зээлтэй адил зээлийн эрсдэл агуулдаг. Санхүүгийн баталгаа болон зээл олгох үүрэг нь анх бодит үнэ цэнээрээ хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд энэ үнэ цэнэ нь хэвийн үед хүлээн авсан хураамжийн дүнгээр нотлогддог. Уг дүнг хүлээсэн үүргийн хүчинтэй байх хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулан бүртгэдэг. Энэ арга нь Банк зээл олгох үүрэг хүлээж уг үүргийнхээ дагуу тодорхой зээлийн хэлцэлд оролцох нь магадлалтай бөгөөд уг зээлээ олгосны дараа богино хугацаанд бусдад шилжүүлэх төлөвлөгөөгүй тохиолдолд үйлчлэхгүй. Энэ тохиолдолд зээлийн үүргийн хураамжийг хойшлуулж олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөх дүнд оруулан тооцно. Тайлант үе бүрийн эцэст үүргүүдийг (i) анх хүлээн зөвшөөрсөн тухайн өдрөөрх хорогдуулаагүй дүнгийн үлдэгдэл, (ii) үүргийг тухайн өдөр барагдуулахад шаардагдах зардлын хамгийн баталгаатайгаар тооцоолсон дүнгийн аль ихээр бүртгэнэ. Хураамжуудыг үүргийн үлдэгдэл дүнтэй холбоотойгоор тогтмол давтамжтай тооцдог тохиолдолд тэдгээрийг үүргийн үйлчлэх хугацааны туршид пропорциональ хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрдөг.

Зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн сан нь харилцагчийн санхүүгийн байдлын муудалтаас үүдэлтэй харилцагчид олгосон баталгаа, хүлээсэн үүрэгтэй холбоотой болзошгүй алдагдалд зориулсан эрсдэлийн санг илэрхийлнэ. Тайлант жил бүр Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан гарах өдрөөрх боломжит бүх мэдээлэлд үндэслэн шаардлагатай эрсдэлийн санг үнэлдэг ба зөвхөн доорх хоёр нөхцөл бүрдсэн үед бүртгэдэг:

- Тайлант өдрийн байдлаар Банк гэрээний дагуу санхүүжилт олгох магадлал маш өндөр байх (зээлийн шугамын ашиглал, баталгааны гэрээнд заасны дагуу төлбөр төлөх гэх мэт).
- Тайлант өдрийн байдлаар үнэ цэнэ буурсныг илэрхийлэх бодит нотолгоотой байх, жишээ нь Группийн зээлдэгчид/хүлээн авагчид гэрээний дагуу олгох урьдчилгааны дүн нь бүрэн нөхөгдөхгүйг илэрхийлсэн хүчин зүйлс орно.

4.27 Нөөц

Групп нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн хувьд эсвэл бодит үндэслэлтэй үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой үед нөөц/санг хуримтлуулан байгуулна.

Групп 2016 оноос эхлэн үйл ажиллагааны эрсдэлийн нөөц санг байгуулсан. Уг нөөц нь бусад өмчид батгах бөгөөд Банкны удирдлагын шийдвэрийн дагуу хуримтлагдсан ашгаас шилжүүлэгдсэн.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.28 Засгийн газрын хөнгөлөлтүүд

Монголбанк (Засгийн газрын зуучлагчийн үүргээр оролцож буй)-наас зах зээлээс доогуур хүүтэй авсан зээлийн үр ашгийг засгийн газрын хөнгөлөлтөд тооцно. Энэхүү төрлийн зээлийг зах зээлийн хүүг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжих ба зээлийн бусад эх үүсвэрт хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн хүүгээс доогуур хүүний үр ашгийг (өөрөөр хэлбэл, зээлийг анх хүлээн зөвшөөрөхөд гарах ашиг) НББОУС 39-ийн дагуу тодорхойлсон зээлийн анхны дансны үнэ болон хүлээн авсан төлбөрийн зөрүүгээр хэмждэг ба засгийн газрын хөнгөлөлтийн орлогоор хүлээн зөвшөөрдөг. Хөнгөлөлтийн холбогдох орлогыг зээлийн хугацааны турш үр ашигт хүүгийн аргаар ашиг алдагдалд системтэйгээр хүлээн зөвшөөрдөг. Хөнгөлөлтийн орлогыг хүүний зардлаар цэвэршүүлэн бүртгэдэг.

Удирдлагын зүгээс засгийн газрын хөнгөлөлтүүдийн өр төлбөрийн дүн нь материаллаг бус тул тусдаа мөр байх шаардлагагүй гэж үзээд “Зээлээр авсан бусад эх үүсвэр” –н мөрөнд багтаасан.

4.29 Итгэмжлэгдсэн хөрөнгө

Гуравдагч этгээдийн дансанд бүртгэлтэй байгаа Группийн нэр дээрх хөрөнгийг энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд оруулаагүй. Үүнээс орох шимтгэлийн орлогыг “Хураамж, шимтгэлийн орлого” хэсэгт багтаасан.

4.30 Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст бүхэлд нь эсвэл ерөнхийд нь батлагдсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Хойшлогдсон татварыг Балансын өглөгийн аргыг ашиглан дараа тайлант хугацаанд шилжүүлэн тооцох татварын алдагдал дээр мөн санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүнгийн хооронд үүсэх түр зөрүүн дээр үндэслэж тооцдог.

Хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлээс өөр гүйлгээний явцад анх хүлээн зөвшөөрсөн бөгөөд тухайн үедээ бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашигт нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх түр зөрүүнүүдэд хүлээн зөвшөөрдөггүй. Хойшлогдсон татварыг хөрөнгө ашиглагдах эсвэл өглөг төлөгдөх тайлант хугацаанд ашиглагдах, санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар батлагдсан буюу үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжоор тогтоосон татварын хувь хэмжээгээр эсвэл дараа тайлант хугацаанд шилжүүлэн ашиглагдах татварын алдагдлаар тооцдог. Банк хойшлогдсон татварын хөрөнгө болон өглөгийг хооронд нь хааж бүртгэдэг.

Хойшлогдсон татварын өглөг нь татвар ногдуулах бүхий л түр зөрүүнд, хойшлогдсон татварын хөрөнгийг татвараас хасагдах бүхий л түр зөрүүнд, мөн ашиглагдаагүй татварын алдагдал, татварын хөнгөлөлтөнд тэдгээрийг ирээдүйн татвар ногдуулах ашигт татвараас хасагдах түр зөрүү, ашиглагдаагүй татварын алдагдал болон хөнгөлөлтийг хасагдуулан ашиглах магадлалтай.

Гадаад валютын арилжааны үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүй олз гарз гэж үздэг ба түр зуурын зөрүү гэж бүртгэдэг (Тодруулга 3 болон 31). Бусад хөрөнгө болон бусад өр төлбөрийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү нь гадаад валютын арилжааны олз гарз гэж үздэг ба энэ нь түр зуурын зөрүү үүсгэдэггүй.

Группийн татварын тодорхой бус байр суурийг удирдлага тайлант үеийн эцэс бүрт дахин үнэлдэг. Группийн орлогын татварын байр суурийг татварын байгууллага хүлээн зөвшөөрөхгүй байж болохоос үүдэн нэмэлт татвар ногдуулах нь ногдуулахгүй байхаас илүү магадлалтай гэж удирдлага үзсэн тохиолдолд өглөг хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан хууль тогтоомжийн тайлбар, мөн ижил асуудлыг шүүх байгууллагын шийдвэрлэсэн байдал дээр үндэслэн үнэлгээ хийгддэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг удирдлага хамгийн боломжит аргаар тодорхойлсноор хүлээн зөвшөөрнө.

4.31 Ажиллагсдын тэтгэмж ба нийгмийн халамж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин, хөлс, бусад цалин хөлстэй холбоотой бусад зардлууд нь Групп болон Банкны ажилтан нь холбогдох ажил үйлчилгээг үзүүлсэн тухайн жилдээ зардлаар хүлээн зөвшөөрөгддөг. Цалинтай ээлжийн амралт зэрэг нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах ажлын

чөлөөг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, нөхөн олговортой богино хугацаат хуримтлагдахгүй ажлын чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) тухайн үед нь хүлээн зөвшөөрдөг.

(ii) Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн болоод нийгэм, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого, зарлагад зардлаар бүртгэдэг. Групп өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны Групп-д ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэнэ.

4.32 Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Групп нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийн худалдах магадлалтай тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно.

Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүд найдваргүй болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын гарзыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолж хүүгийн орлогоор бүртгэдэг.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэль суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

4.33 Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгө гэдэг нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө (барилга зэрэг үл хөдлөх, машин тоног төхөөрөмж, бараа материал зэрэг хөдлөх, үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө)-ийг хэлнэ. Хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайн хөрөнгийн шинж чанар, Группийн сонирхол зэргээс шалтгаалж холбогдох хөрөнгийн бүлэгт хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дахин хэмжиж бүртгэнэ.

Санхүүгийн бус хөрөнгийн хувьд, хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгийг (үл хөдлөх хөрөнгийг) өөрийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглах бол уг хөрөнгийг "Байшин барилга ба үндсэн хөрөнгө" гэж дахин ангилан, Байшин барилга ба үндсэн хөрөнгөтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.18). Хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгийг түрээслүүлэх болон үнэ цэнийн өсөлтийн зорилгоор, эсвэл уг 2 тохиолдлын хоёулангийн зорилгоор өөрөө ашиглахгүйгээр хадгалж үлдсэн бол Групп нь уг хөрөнгийг "Өмчлөх бусад хөрөнгө"- өөс "Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө" хэсэг рүү дахин ангилан холбогдох нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.19). Хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгөөр авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах тохиолдолд Групп нь бараа материалтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журмыг баримтлан зөвхөн СТОУС-5 –ын шаардлага биелэн худалдах зорилготой хөрөнгө гэж ангилснаас бусад тохиолдолд уг хөрөнгийг "Өмчлөх бусад хөрөнгө" гэж Санхүүгийн Байдлын Тайланд тусгана. Худалдахаар төлөвлөсөн санхүүгийн бус хураан авсан барьцаа хөрөнгийн талаар тодруулга 22-өөс үзнэ үү.

Хэрэв хураан авсан санхүүгийн хөрөнгө (Үнэт цаас гэх мэт)-ийг худалдснаар анхны үнэ нөхөх бол Группийн зүгээс энэхүү хөрөнгийг "Өмчлөх бусад хөрөнгө" гэж үзэн СТОУС-ын хэмжилтийн дагуу борлуулахад бэлэн үнэт цаас гэж ангилан бодит үнэ цэнээр хэмждэг. Хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг тайлант хугацаа бүрт тооцдог бөгөөд бодит үнэ цэнийн тохируулгыг өмчийн хэсэг дэх Борлуулахад бэлэн үнэт цаасны нөөцөд хүлээн зөвшөөрдөг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар тодруулга 4.11 –т тусгасан. Хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийн талаар тодруулга 21-ийг үзнэ үү.

4.34 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэнэ. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бизнесийн энгийн нөхцөлд барааг худалдахаар таамаглаж буй үнээс барааг гүйцээх болон худалдахтай холбоотойгоор гарах таамагласан зардлыг хассан дүн.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.35 Нөхцөл өөрчлөгдсөн зээлүүд

Групп барьцаа хөрөнгийг хураан авахаасаа илүү аль болох төлбөр хийх хугацааг сунгах, зээлийн нөхцлийг шинээр тохиролцох зэрэг замаар зээлийн нөхцлийг өөрчлөх боломжийг хайдаг. Нөхцлүүдийг дахин хэлэлцэн тохиролцсоны дараа тухайн зээлийг хугацаа хэтэрсэнд ангилдаггүй. Удирдлага нөхцөл өөрчлөгдсөн зээлүүдийг үргэлж эргэн шалгаж, бүх шалгуурууд биелэгдсэн эсэх, ирээдүйд орж ирэх төлбөрүүд төлөгдөх магадлалтай эсхийг авч үздэг. Эдгээр зээлүүдийг мөн цаашид ч тэдгээрийн анхны үр ашигт хүүг ашиглан дан ганцаар нь эсвэл бүлгийн үнэлгээгээр нь үнэ цэнийн бууралтын хувьд шинжилдэг.

4.36 Хувьцаанд суурилсан төлбөрүүд

Хувьцаанд суурилсан төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хүрээнд хүлээн авсан буюу худалдаж авсан үйлчилгээг Банк тухайн үйлчилгээг хүлээн авсан үед хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хувьцаанд суурилсан бөгөөд хувьцаагаар төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хүрээнд үйлчилгээ хүлээн авсан бол эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэдэг, харин хувьцаан дээр суурилсан бөгөөд мөнгөөр төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд өглөгийг нэмэгдүүлэн бүртгэдэг.

Хувьцаанд суурилсан бөгөөд хувьцаагаар төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд Банк хүлээн авсан үйлчилгээ болон эзэмшигчдийн өмчийн холбогдох өсөлтийг олгосон хувьцааны бодит үнэ цэнэ дээр үндэслэн шууд бус аргаар тооцно. Хувьцаанд суурилсан бөгөөд мөнгөөр төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд Банк хүлээн авсан үйлчилгээ болон үүссэн өр төлбөрийг уг өр төлбөрийн бодит үнээр хэмжинэ. Өр төлбөр барагдаж дуустал Банк тайлант үе бүрийн эцэст болон өр төлбөр барагдаж дуусах өдөр тухайн өр төлбөрийн бодит үнэ цэнийг дахин үнэлэх ба дахин үнэлгээнээс үүсэх бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн үеийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг.

4.37 Санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа хийгдэх өөрчлөлтүүд

Банкны удирдлага болон хувьцаа эзэмшигчид санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа өөрчлөх эрх мэдэлтэй болно.

5 Шинэ буюу өөрчлөгдсөн стандарт, тайлбаруудын хэрэгжилт

Группийн хувьд дараах шинэ стандарт болон тайлбаруудыг хэрэгжилт нь 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс хүчинтэй:

СТОУС 14, Зохицуулах байгууллагатай холбоотой хойшуулсан данс (2014 оны 1 дүгээр сард батлагдсан ба 2016 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). СТОУС 14-өөр СТОУС-ыг анх удаа хэрэглэж байгаа этгээд өмнө нь мөрдөж байсан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үнэ ханшийн зохицуулалттай холбоотой дүнг цаашид үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэхийг зөвшөөрсөн. СТОУС-ыг өмнө нь нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлантай анх удаа СТОУС-ын нэвтрүүлж байгаа этгээдийн санхүүгийн тайланг харьцуулагдахуйц байлгах үүднээс үнэ ханшийн зохицуулалттай холбоотой дүнг бусад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тусад нь тайлагнахыг стандартад зааж өгсөн. Санхүүгийн тайландаа СТОУС-ыг өмнө нь нэвтрүүлсэн аж ахуйн нэгжид тус стандарт хамааралгүй болно.

СТОУС 11-д орсон нэмэлт өөрчлөлт – Хамтарсан үйл ажиллагаан дах ашиг сонирхлыг эзэмших ажил гүйлгээг бүртгэх (2014 оны 5 сарын 6-нд батлагдсан ба 2016 оны 1 сарын 1 нээр эхлэж буй болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтөөр бизнесийн үйл ажиллагаа үүсгэж байгаа хамтарсан хэлцэл дэх ашиг сонирхлын эзэмшлийг хэрхэн бүртгэх талаар зааж өгсөн.

НББОУС 16 болон НББОУС 38-д орсон нэмэлт өөрчлөлт - Элэгдэл болон хорогдлыг тооцох аргыг илүү тодорхой болгох нь (2014 оны 5 сарын 12-нд батлагдсан ба 2016 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтөөр НББОУС-ын зөвлөл, хөрөнгийг ашиглаж буй үйл ажиллагаанаас бий болсон орлогод тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн ашиглалтаас гадна өөр бусад хүчин зүйлс нөлөөлсөн байдаг тул орлогод суурилсан аргаар үндсэн хөрөнгийг элэгдүүлэх нь тохиромжгүй гэдгийг тодорхой болгож өгсөн.

НББОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Хөдөө аж ахуй: Биологийн ургамлууд (2014 оны 6 сарын 30-нд батлагдсан ба 2016 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Тус өөрчлөлтөөр усан үзмийн мод, резины мод болон тосны мод гэх зэрэг биологийн ургамлууд нь үйлдвэрлэлийн шинж чанартай тул үндсэн хөрөнгөөр бүртгэнэ гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Тиймээс дээрх өөрчлөлтийг НББОУС 16-д оруулж, НББОУС 41-ээс хассан. Гэхдээ биологийн ургамлыг ургуулах хугацаанд НББОУС 41-ийг хэвээр баримтална.

НББОУС 27-д орсон нэмэлт өөрчлөлт - Бие даасан санхүүгийн тайлан дах өртгийн арга (2014 оны 8 дугаар сарын 12-нд батлагдсан ба 2016 оны 1 сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж нь бие даасан санхүүгийн тайландаа охин компани, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэх боломжтой болсон.

СТОУС 2014-үүдэд жил бүр хийгддэг сайжруулалтууд - (2014 оны 9 сарын 25-нд батлагдсан ба 2016 оны 1 сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Дээрх өөрчлөлтөд нийтдээ 4 стандарт хамрагдсан. СТОУС 5-д, ашиглах эрхийг шилжүүлэх хэлбэр

өөрчлөгдсөн (жишээ нь борлуулах ангиллаас эзэд хуваарилах ангилалд шилжүүлэх эсвэл эсрэгээрээ) нь уг хөрөнгийг зарж борлуулах эсвэл эзэд хуваарилах төлөвлөгөөг өөрчилсөн гэж үзэхгүй бөгөөд тийм байдлаар бүртгэхгүй гэж нэмж өгсөн. СТОУС 7-ын тодруулгын шаардлагын дагуу, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гэрээний нөхцлүүдэд шилжүүлэгчийн зүгээс цаашид уг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой оролцоо байгаа эсхийг удирдлага тодорхойлоход илүү дөхөмтэй болгосон. НББОУС 34-өөр шаардаагүй тохиолдолд, завсрын тайлангуудад СТОУС 7-ийн дагуу санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэршүүлж толилуулахгүй байх боломжтой гэж заасан. НББОУС 19-д орсон нэмэлт өөрчлөлтөөр ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн өр төлбөрийг хорогдуулах хүүгийн түвшин тодорхойлохдоо өндөр зэрэглэлтэй байгууллагын гаргасан бонд, эсвэл уг бонд байхгүй бол засгийн газрын бондын хүүг авахдаа уг өрийн хэрэгслийг гаргасан улсын валют биш тухайн өрийн хэрэгсэл гарсан валютаарх өрийн хэрэгслийн хүүг суурь болгоно гэж заасан. НББОУС 34 –ийн дагуу “завсрын санхүүгийн тайлан мэдээнд толилуулсан мэдээ” гэж бичихдээ санхүүгийн тайлангаас тухайн мэдээлэл байгаа хэсгийг зааж өгнө гэж нэмж оруулсан. Банк дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 1-д орсон санхүүгийн тайлангийн толилуулгатай холбоотой нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 дугаар сард батлагдсан ба 2016 оны 1 дүгээр сарын 1 нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Өөрчлөлтөөр материаллаг байдал гэсэн ойлголтыг дэлгэрүүлж дараах байдлаар тайлбарласан: СТОУС-ын дагуу тодруулах шаардлагатай тусгай зүйлсийн жагсаалтад орсон эсвэл хамгийн багадаа тухайн зүйлийг тодруулна гэж заасан байсан ч хэрэв тухайн тодруулгаар харуулсан мэдээлэл нь материаллаг бус бол СТОУС-ын дагуу заавал толилуулах шаардлагатай зүйлсийг ч тодруулахгүй байж болно гэж заасан. Мөн, стандартаар санхүүгийн тайлан дахь дэд бүлгийн нийт дүнгийн талаар шинэ заавар өгсөн. Үүнд: (а) дэд бүлгийн нийт дүнг бүрдүүлж буй зүйлс нь СТОУС-ын дагуу хэмжигдэж хүлээн зөвшөөрөгдсөн байх; (б) дэд бүлгийн тоог бүрдүүлж буй зүйлсийн нэрсийг тусгаж, харахад ойлгомжтой цэвэрхэн байдлаар толилуулна; (в) тайлант үеүдэд толилуулах байдлыг тууштай хадгалах; (г) СТОУС-ын дагуу дэд бүлгийг бүрдүүлж буй зүйлсэд дэд бүлгийн нийт дүн болон үндсэн бүлгийн нийт дүнгээс илүү ач холбогдол өгөхгүйгээр толилуулах.

СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 28-д орсон нэгтгэл хийхээс чөлөөлөгдөх нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 дугаар сард батлагдсан ба 2016 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг охин компани тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн, хэрэв охин компанийн эцсийн эсвэл дундын толгой компани олон нийтийн хүртээл болгох нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг бол нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахаас чөлөөлөгдөнө гэснийг охин компанийн эцсийн болон дундын толгой компанийн санхүүгийн тайландаа охин компанийг нэгтгэсэн эсвэл СТОУС 10-ын дагуу тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр охин компанийг бүртгэсэн эсэхээс үл хамааран нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхээс чөлөөлөгдөнө гэж нарийн тодорхойлж өгсөн. Банк дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд

2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

СТОУС 9, “Санхүүгийн хэрэглүүр: Ангилал ба хэмжилт”. (2014 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан ба 2018 оны 1 сарын 1-нээс эхэлсэн болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү стандартын гол агуулгаас дурьдвал:

- Санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр нь хэмжих, бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих болон тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүү нь бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж 3 ангилна.
- Өрийн хэрэгслийг ангилах нь аж ахуйн нэгжийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн модел болон гэрээнд заасан мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөр байх эсэхээс хамаарна. Хэрэв өрийн хэрэгсэл нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг авах зорилготой байвал хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хэрэв аж ахуйн нэгж нь өрийн хэрэгслийг үндсэн зээлийн төлбөр болон хүүг авах мөн шаардлагатай тохиолдолд зарах зорилгоор эзэмшиж байвал бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих санхүүгийн хөрөнгө гэж ангилна. Мөнгөн гүйлгээгүй санхүүгийн хөрөнгийг тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүү нь бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж ангилна (жишээ нь дериватив). Нуугдмал деривативыг санхүүгийн хөрөнгөөс салгаж үзэхгүй болсон ба зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн нөхцлийг хангаж буй эсэхийг үнэлнэ.
- Бүх өмчийн хэрэгслийг дараагийн тайлант үеүдэд үргэлж бодит үнэ цэнээр хэмжинэ. Хэрэв санхүүгийн хөрөнгийг арилжаалах зорилгоор эзэмшээгүй бол бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх ангилалын сонголтыг хийж болох ба энэ сонголтыг буцаах боломжгүй. Хэрэв өмчийн хэрэгслийг арилжаалах зорилготой бол тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг нь бүртгэнэ.
- НББОУС 39-ийн ангилал болон хэмжилтийн ихэнх шаардлагууд нь СТОУС 9-д шилжихдээ өөрчлөгдөөгүй. Гол өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдэлийн тайланд өөрчлөлтийн нөлөөний талаар тусгах шаардлагатай гэж заасан.
- СТОУС 9-д үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шинэ загвар болох ирээдүйд учирч болох зээлийн гарзын загварыг нэвтрүүлсэн. Эхний хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарт гарах өөрчлөлтөд үндэслэсэн “3 үе шат”-ны арга байна гэж заасан. Практикийн хувьд шинэ аргаар үнэ цэнэ нь буураагүй санхүүгийн хөрөнгийг (дансны авлагын хувьд авлага хаагдах хүртэл буюу хугацаанд үндэслэхгүйгээр учирч болох эрсдэлийн гарзын сан байгуулна) анх хүлээн зөвшөөрөхдөө ирэх 12 сард учирч болох зээлийн гарзыг тэр дарууд нь хүлээн зөвшөөрнө гэж заасан. Зээлийн эрсдэлд томоохон сөрөг өөрчлөлт гарсан тохиолдолд 12 сарын биш хугацаагүй учирч болох зээлийн гарзын сан байгуулна. Энэхүү загварт түрээс болон дансны авлагыг арай энгийн байдлаар авч үзсэн.

6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд (үргэлжлэл)

- Хэйджийн бүртгэлийг аж ахуйн нэгжийн эрсдэлийн удирдлагатай уялдахуйц байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан. СТОУС 9-д макро хейджийг хэрхэн бүртгэх талаар тусгаагүй тул СТОУС 9-ийн хэйджийн бүртгэл эсвэл НББОУС 39-ийн хэйджийн бүртгэлийг үргэжлүүлэн ашиглах талаар нягтлан бодох бүртгэлдээ тусгах сонголтыг аж ахуйн нэгжид үлдээсэн.

Групп шинээр гарсан стандартуудын санхүүгийн тайланд нөлөөлөх байдлыг үнэлж байгаа хэдий ч СТОУС 9-ийн хэрэгжилт нь ихэнх санхүүгийн байгууллагуудад нөлөөлнө.

СТОУС 15, Харилцагчтай байгуулсан гэрээний орлого (2014 оны 5 дугаар сарын 28-нд батлагдсан ба 2017 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Шинэ стандартаар бараа, ажил үйлчилгээг харилцагчид шилжүүлсэн үед ажил гүйлгээний үнээр орлогыг заавал хүлээн зөвшөөрнө гэсэн үндсэн зарчмыг танилцуулсан. Салгаж болохуйц багцын бараа, ажил үйлчилгээний орлогыг салгаж бүртгэнэ, гэхдээ гэрээний хөнгөлөлт, урамшуулалыг холбогдох зүйлд нь заавал хуваарилж бүртгэнэ гэж заасан. Харилцагчтай байгуулсан гэрээний эрсдэлийг бууруулахтай холбоотой гарсан зардлыг капиталжуулж гэрээний орлого олох хугацаанд хорогдуулна. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

СТОУС 16 “Түрээс” (2016 оны 1 дүгээр сарын 13-нд батлагдсан ба 2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Шинэ стандартаар түрээсийн хүлээн зөвшөөрөлт, дараа үеийн хэмжилт, тайлагнал болон тодруулгыг хэрхэн бэлтгэх талаар зарчмуудыг зааж өгсөн. Бүх түрээсийн хувьд түрээслэгч түрээсийн хөрөнгийг ашиглах эхлэх үеэс эхлэн хөрөнгийг ашиглах эрхийг эзэмших ба хэрэв түрээсийн төлбөрийг олон удаагийн төлбөрөөр хийх бол түрээслэгч түрээслүүлэгчээс санхүүжилт авсан гэж үзнэ. Тиймээс НББОУС 17-д заасны дагуу түрээсийг үйл ажиллагааны болон санхүүгийн түрээс гэж ангилна гэж заасан байсныг хасаж түрээсийн бүртгэлийн нэг л загварыг НББОУС 16-аар танилцуулсан. Түрээслэгч а) 12 сараас дээш хугацаатай бүх төрлийн түрээстэй холбоотой хөрөнгө өр төлбөр бүртгэх, б) орлогын тайланд түрээсийн хөрөнгийн элэгдлийг түрээсийн төлбөрийн хүүгийн зардлаас тусад нь тайлагнана. НББОУС 17-д заасан түрээслүүлэгчтэй холбоотой бүртгэлийн заалтын ихэнх хэсгийг НББОУС 16-д оруулсан. Тиймээс түрээслүүлэгч түрээсийг шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн аль нэгээр нь бүртгэнэ. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлтүүд – Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах (2014 оны 9 дүгээр сарын 11-нд батлагдсан ба НББОУС-ын зөвлөлөөс заасан хугацаанаас хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээг хэрхэн бүртгэх талаар СТОУС 10 болон НББОУС 28-д ялгаатай байдлаар тусгасан байдлыг арилгахад чиглэгдсэн. Өөрчлөлтийн үр дүнд, хөрөнгө борлуулах эсвэл хандивлах ажил гүйлгээ нь бизнесийн шинж чанартай бол олз, гарзыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрнө гэж заасан. Бизнесийн үйл ажиллагаанд ашиглагддаггүй хөрөнгийг хараат компани эзэмшиж байсан ч хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээний олз, гарзыг хэсгчлэн хүлээн зөвшөөрнө. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

Бодит бус олзод хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх – НББОУС 12-т орсон нэмэлт өөрчлөлт (2016 оны 1 сарын 19-нд батлагдсан ба 2017 оны 1 сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Нэмэлт өөрчлөлтөөр өрийн хэрэглээс үүссэн бодит бус гарзад хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой болгосон. Байгууллага нь өрийн хэрэглүүрийг зах зээлийн хүүгээр хорогдуулсан мөнгөн гүйлгээнээс үүссэн бодит бус гарзад хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж нь өрийн хэрэглүүрийн эзэмшигч ирээдүйд олз хүртэж уг олзод татвар төлөхгүй байснаар бий болох юм. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

Тодруулгын шаардлагад орсон өөрчлөлтүүд – НББОУС 7-д орсон өөрчлөлт (2016 оны 1 дүгээр сарын 29-нд батлагдсан ба 2017 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). НББОУС 7-д санхүүжилтийн үйл ажиллагааны өр төлбөрийн хөдөлгөөнийг тодруулгад тусгахыг нэмэлт өөрчлөлтөөр оруулсан. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

Харилцагчтай байгуулсан гэрээний орлого-СТОУС 15-д орсон өөрчлөлтүүд (2016 оны 4 дүгээр сарын 12-нд батлагдсан ба 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Энэхүү өөрчлөлт нь стандартын үндсэн зарчмуудыг өөрчлөөгүй боловч эдгээр зарчмуудыг хэрхэн дагаж мөрдөх талаар тодорхойлж өгсөн. Өөрчлөлт нь гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлох (бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад шилжүүлэх амлалт), гэрээнд оролцогч компанийг нийлүүлэгч (бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч) эсвэл агент (бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх ажиллагаагаа зохицуулах үүрэгтэй) гэдгийг хэрхэн тодорхойлох, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанаас орж ирэх орлогыг тухайн хугацаанд эсвэл хугацааны туршид хүлээн зөвшөөрөх талаар тодорхойлж өгсөн. Мөн түүнчлэн, энэхүү өөрчлөлтүүдээр шинэ стандартыг мөрдөх үеийн компанид учрах хүндрэл болон зардлыг бууруулахаар 2 төрлийн нэмэлт хөнгөлөлтийг тусгасан. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

Хувьцаанд суурилсан төлбөр- СТОУС 2-т орсон өөрчлөлтүүд (2016 оны 6 дугаар сарын 20-нд батлагдсан ба 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Өөрчлөлт нь зах зээлийн бус гүйцэтгэлийг харгалзаж үзэх хугацааны нөхцөл нь мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээнд хувьцаагаар төлөгдөхтэй ижил маягаар нөлөөлнө. Мөн энэхүү өөрчлөлтөөр компанийн хувьцаанд суурилсан төлбөртэй холбоотойгоор үүсэх харилцагчийн татварын үүргийг зохицуулахын тулд харилцагчид төлөх хувьцаанд суурилсан

төлбөрийн хэрэгжих өдөр суутгах татварыг өмчийн хэрэглүүрээс тодорхой хувиар суутгаж цэвэр дүнгээр бүртгэх гүйлгээний ангиллыг тодорхойлж өгсөн. Холбогдон гарах хэлэлцээр нь бүхэлдээ хувьцаагаар төлөгдөх ангилал ангилагдана.

Мөн энэхүү өөрчлөлтөөр мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийг хувьцаагаар төлөгдөх төлбөр болж өөрчлөхтэй холбоотой бүртгэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: (а) хувьцаанд суурилсан төлбөр нь өөрчлөлтийн дүнд олгогдох хувьцааны хэрэглүүрийн өөрчлөгдсөн өдрийн бодит үнэ цэнээр хэмжигдэнэ (б) энэхүү өөрчлөлтийн дагуу холбогдох өр төлбөрийг данснаас хасна, (в) хувьцаагаар төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр нь өөрчлөлт орох өдөр хүртэлх үзүүлсэн үйлчилгээтэй тэнцэх хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөнө (г) өөрчлөлт орох өдрөөрх өр төлбөрийн дансны үнэ болон мөн өдрөөрх өмчийн хэсэгт хүлээн зөвшөөрөгдсөн үнийн дүнгийн зөрүүг ашиг, алдагдлаар бүртгэнэ. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

Даатгалын гэрээ-СТОУС 4-т орсон өөрчлөлтүүд (2016 оны 12 дугаар сарын 12-нд батлагдсан ба 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Өөрчлөлт нь 2 аргыг танилцуулж байгаа ба үүнд: (i) үечилсэн арга болон (ii) хойшлуулах арга орно. Өөрчлөлт нь Даатгалын шинэ стандарт батлагдахаас өмнө, Санхүүгийн хэрэгслийн шинэ стандарт болох СТОУС 9-ийн хэрэгжилтийн явцад гарч болох зөрүүг орлого үр дүнгийн тайланд бус, дэлгэрэнгүй орлогын хэсэгт тусгаж болох сонголтыг олгож байгаа. Мөн тус стандартын өөрчлөлтөөр, үйл ажиллагаа нь даатгалын гэрээтэй нягт холбоотой компаниудын хувьд СТОУС 9-ийг 2021 он хүртэл ашиглахгүй байж болох түр чөлөөлөлт өгсөн.

Дээр дурдсанаас бусад тохиолдолд шинэ стандарт болон тайлбарууд нь Группын санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| Бэлэн мөнгө | 101,879,822 | 91,866,379 | 101,095,187 | 91,801,377 |
| Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад) | 215,706,005 | 66,322,910 | 215,706,005 | 66,322,910 |
| Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө | 317,585,827 | 158,189,289 | 316,801,192 | 158,124,287 |

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгө нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус хөрөнгийн дүнд хугацаа хэтэрч, эсвэл үнэ цэнэ буурсан дүн байхгүй. Монголбанк нь Мүүдийс-ийн Саа1 үнэлгээтэй.

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгийн валют, хүү болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 37-с үзнэ үү.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан хөрөнгө (Тодруулга 7) | 317,585,827 | 158,189,289 | 316,801,192 | 158,124,287 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө (Тодруулга 11) | 294,216,826 | 149,605,676 | 294,216,826 | 149,605,676 |
| Монголбанкны үнэт цаас (Тодруулга 13, 15) | 41,979,911 | 424,454,647 | 41,979,911 | 424,454,647 |
| Засгийн Газрын бонд (Тодруулга 9) | 141,625,606 | - | 141,625,606 | - |
| Урвуу РЕПО хэлцэл (Тодруулга 10) | 9,995,766 | - | 9,995,766 | - |
| Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 805,403,936 | 732,249,612 | 804,619,301 | 732,184,610 |

Голомт Банк Групп

8 Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|----------------------|----------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц | 315,633,095 | 260,739,412 |
| Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц | 315,633,095 | 260,739,412 |

Банк нь Төв Банк буюу Монголбанкн дахь харилцах дансандаа Монголбанкнаас тавьдаг шаардлагын дагуу зайлшгүй байлгах нөөц байршуулдаг. Төв Банкн д байршуулдаг хөрөнгийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.0% (2015: 12.0 %) -аас багагүй байдаг. Группийн болон Банкны заавал байлгах нөөцийн дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

9 Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө

Хөрөнгийн биржид арилжаалагддаг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгүүд нь Хонг Конг, Торонто болон Нью Йоркийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй өмчөөрх хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

Банк 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Засгийн газрын бонд болон Монголбанкны үнэт цаасыг дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалахаар зорилгоо өөрчилсөн. Иймээс Банк шинээр худалдан авсан Засгийн газрын үнэт цаасыг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаас ангилалд ангилж бүртгэсэн. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 64,901,615 мянган төгрөгийн Засгийн газрын бондыг дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас ангилалд ангилсан байсан ба эдгээр бонд нь 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд болон бондын дуусгавар хугацаа нь хүртэл хэвээр энэ ангилалд хэвээр үлдэнэ.

2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн доор харуулав:

| | Групп | | Банк | |
|--|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| Мянган төгрөгөөр | | | | |
| Засгийн газрын бонд | 246,843,505 | - | 246,643,506 | - |
| Засгийн газрын богино хугацаат бонд | 141,625,606 | - | 141,625,606 | - |
| Бусад бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаас | 7,172,002 | 5,442,398 | 7,153,482 | 5,410,038 |
| Нийт бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаас | 395,641,113 | 5,442,398 | 395,422,594 | 5,410,038 |

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх засгийн газрын үнэт цаас

Засгийн газрын бонд нь Сангийн яамнаас хямдруулалттай гаргасан, анхны дуусах хугацаа нь 3-аас 53 сар хүртэлх (2015: 6-аас 121 сар хүртэлх) хугацаатай бондыг илэрхийлнэ. Богино хугацаат засгийн газрын бондын анхны дуусах хугацаа нь 3 сараас бага тул түүнийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж үзнэ.

2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх засгийн газрын үнэт цаасны өөрчлөлтийг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| 1 сарын 1-нээрх бодит үнэ цэнэ | - | - | - | - |
| Худалдаж авсан | 482,261,309 | - | 482,061,310 | - |
| Худалдсан | (79,313,095) | - | (79,313,095) | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө | 836,715 | - | 836,715 | - |
| Хорогдуулаагүй урамшуулал/хямдруулалт | (15,964,109) | - | (15,964,109) | - |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 648,291 | - | 648,291 | - |
| 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ | 388,469,111 | - | 388,269,112 | - |

2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх бусад бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтийг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| 1 сарын 1-нээрх бодит үнэ цэнэ | 5,442,398 | 227,942 | 5,410,038 | 227,942 |
| Худалдаж авсан | 240,828 | 8,629,537 | 170,445 | 8,597,177 |
| Худалдсан | (3,094,694) | (693,695) | (3,016,778) | (693,695) |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө | 1,654,682 | 282,309 | 1,654,682 | 282,309 |
| Бодит үнэ цэнийн тохируулга | 2,928,788 | (3,003,695) | 2,935,095 | (3,003,695) |
| 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ | 7,172,002 | 5,442,398 | 7,153,482 | 5,410,038 |

Эдгээр үнэт цаасыг нийтэд нээлттэй зах зээлийн мэдээлэл (харьяалагдах хөрөнгийн биржээс) дээр үндэслэн бодит үнэ цэнээр бүртгэдэг тул Групп эдгээр үнэт цаасны үнэ цэнэ бууралтын шинж тэмдгийг хянадаггүй.

Банк 2016 онд Нью Йоркийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Туркуаз Хилл Ресурс ХК-ны 905 мянган ам.долларын хувьцааг болон Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Монголиан Майнинг Корпораци ХК-ны 4,653 мянган Хонг Конг долларын хувьцааг худалдсан. Банк нь тайлант жилд эдгээр хувьцааны зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүссэн олз болох 2,934,893 мянган төгрөгийг (2015: 2,878,574 мянган төгрөгийн алдагдал) хүлээн зөвшөөрсөн.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасны Стандарт ба Пүүрсийн зэрэглэлийн дагуух зээлийн чанарыг үнэлгээг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доор харуулав. 2016 оны сүүлийн хагасд Мүүдийс агентлаг Монгол улсын болон арилжааны банкуудыг зээлжих зэрэглэлийг бууруулсан тул доорхи В зэрэглэлтэй талуудыг (Монгол улсын засгийн газар болон арилжааны банкууд) Мүүдийс үнэлгээгээр үнэлвэл С байна (Тодруулга 2).

| Мянган төгрөгөөр | Засгийн газрын бонд /урт хугацаат/ | Засгийн газрын бонд /богино хугацаат/ | Бусад БУЦААХЗ үнэт цаас | Нийт |
|--|--|---|----------------------------|--------------------|
| <i>Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй</i> | | | | |
| - В- | 246,643,506 | 141,625,606 | - | 388,269,112 |
| - Зэрэглэл хийгдээгүй | - | - | 7,153,482 | 7,153,482 |
| Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй | 246,643,506 | 141,625,606 | 7,153,482 | 395,422,594 |

Голомт Банк Групп

10 Урвуу репо хэлцэл

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх урвуу репо хэлцэл нь 15.5 хувийн хүүтэй, 7 хоногийн хугацаатай дотоодын Банктай хийсэн хэлцэл байна. Уг урвуу репо хэлцэл нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан ба эргэн төлөлт хийгдээгүй тохиолдолд Банк гэрээгээр олгосон эрхийн дагуу тухайн үнэт цаасыг худалдан борлуулах, давхар барьцаалах эрхтэй.

11 Бусад банкуудад байршуулсан хөрөнгө

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|-------------------------|-------------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Бусад банкууд дахь харилцах данс | | |
| Дотоод | 11,734,532 | 14,294,479 |
| Гадаад | 742,682,084 | 334,909,197 |
| Богино хугацаат хөрөнгө | | |
| Дотоод | 37,706,210 | - |
| Бусад банкуудад анх 3 сараас их хугацаатайгаар байршуулсан хөрөнгө | 31,729 | 30,329 |
| Нийт бусад банкуудад байршуулсан хөрөнгө | 792,154,555 | 349,234,005 |

Бусад гадаадын банкууд дахь харилцах дансдад гадаадын банкнаас авсан зээлийн барьцаа болох 200 сая ам.доллар багтсан (тодруулга 25, 39) ба үүнээс бусад банкуудад байршуулсан хөрөнгө нь барьцаалагдаагүй. Зээлийн эрсдлийн үнэлгээнд Стандарт ба Пүүрсийн үнэлгээг ашигласан.

Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн зээлийн эрсдлийн чанарыг дор үзүүлэв:

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|-------------------------|-------------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй | | |
| AA | - | 72,182,743 |
| AA- | 4,816,688 | 1,559,383 |
| A+ | 46,176,779 | 13,117,265 |
| A | 62,596,820 | 19,186,352 |
| A- | 5,407,549 | 246,998 |
| BBB+ | 259,099,674 | 214,492,075 |
| BBB | 569,758 | 438,100 |
| BBB- | - | 138,566 |
| BB | 107,810,809 | 2,416,949 |
| BB- | 248,953,000 | - |
| B | - | 14,261,918 |
| B- | 12,397,284 | - |
| Зэрэглэл хийгдээгүй | 44,326,194 | 11,193,656 |
| Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй | 792,154,555 | 349,234,005 |

Бусад банкуудад байршуулсан зэрэглэл хийгдээгүй хөрөнгө нь дунд хэмжээтэй Монгол болон гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө юм. Удирдлагын зүгээс зэрэглэл хийгдээгүй банкуудад байршуулсан хөрөнгийг тухайн банкны нэр хүнд болон бусад олон нийтэд нээлттэй мэдээллийг (олон нийтэд нээлттэй санхүүгийн тайлан гэх мэт) ашиглан үнэлсэн.

Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн валют, хүү болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 37-с үзнэ үү.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|---|----------------------|----------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Бизнесийн зээл | 976,217,821 | 1,205,437,537 |
| Жижиг дунд бизнесийн зээл | 542,679,369 | 461,558,818 |
| Хувь хүнд олгосон хэрэглээний зээл | 256,880,787 | 194,024,822 |
| Хувь хүнд олгосон орон сууцны зээл | 349,797,988 | 247,684,064 |
| Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа | 2,125,575,965 | 2,108,705,241 |
| Хасах нь: Зээлийн үнэ цэнэ бууралтын сан | (90,716,210) | (95,094,454) |
| Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа | 2,034,859,755 | 2,013,610,787 |

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 30 том зээлдэгчдэд олгосон зээлийн дүн 790,641,419 мянган төгрөг (2015 оны 12 дугаар сарын 31: 886,299,597 мянган төгрөг) байсан бөгөөд нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 37.2% хувийг (2015 оны 12 дугаар сарын 31: 41.9% хувийг) эзэлж байсан. Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

Зээлийн үнэ цэнийн бууралтын санд 2016 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Бизнесийн зээл | Хэрэглээний зээл | Жижиг дунд бизнесийн зээл | Орон сууцны зээл | НИЙТ |
|--|-------------------|------------------|---------------------------|------------------|-------------------|
| Зээлийн үнэ цэнэ бууралтын сан 2016 оны 01 сарын 01 | 59,811,263 | 5,412,308 | 26,194,204 | 3,676,679 | 95,094,454 |
| Тайлант жилд байгуулсан сан | 30,963,283 | 1,619,990 | 17,618,651 | 1,701,874 | 51,903,798 |
| Ханшийн зөрүү | 8,425,741 | (1,491,720) | (1,616,965) | (1,121,471) | 4,195,585 |
| Тайлант жилд данснаас хассан дүн | (48,707,689) | (413,301) | (11,356,637) | - | (60,477,627) |
| 2016 оны 12 сарын 31 – нээрх зээлийн үнэ цэнэ бууралтын сан | 50,492,598 | 5,127,277 | 30,839,253 | 4,257,082 | 90,716,210 |

Зээлийн үнэ цэнийн бууралтын санд 2015 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Бизнесийн зээл | Хэрэглээний зээл | Жижиг дунд бизнесийн зээл | Орон сууцны зээл | НИЙТ |
|--|-------------------|------------------|---------------------------|------------------|-------------------|
| Зээлийн үнэ цэнэ бууралтын сан 2015 оны 01 сарын 01 | 49,180,880 | 2,871,780 | 23,690,355 | 1,238,645 | 76,981,660 |
| Тайлант жилд байгуулсан сан | 29,054,370 | 3,375,532 | 14,836,115 | 2,437,398 | 49,703,415 |
| Ханшийн зөрүү | 679,099 | 4,893 | 26,347 | 636 | 710,975 |
| Тайлант жилд данснаас хассан дүн | (19,103,086) | (839,897) | (12,358,613) | - | (32,301,596) |
| 2015 оны 12 сарын 31 – нээрх зээлийн үнэ цэнэ бууралтын сан | 59,811,263 | 5,412,308 | 26,194,204 | 3,676,679 | 95,094,454 |

Монголбанкны холбогдох журамд заасны дагуу СТОУС-ын дагуу байгуулсан зээлийн үнэ цэнэ бууралтын сан болон Монголбанкны журмын дагуу байгуулсан зээлийн үнэ цэнэ бууралтын сангийн зөрүүг өмчийн өөрчлөлтийн тайланд бусад нөөц гэж бүртгэнэ. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 12,581,183 мянган төгрөгийг бусад нөөцөөр бүртгэсэн. Уг нөөц нь 2016 оны 01 дугаар сарын 01-нээс хүчинтэй Монголбанкны журам болон СТОУС-ын дагуух Банкны өөрийн хөрөнгөөс шилжүүлэгдсэн нөөц юм.

Голомт Банк Групп

12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдын зээлийн багц дахь бизнесийн салбарын эрсдлийн төвлөрлийг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | 2016 | | 2015 | |
|--|----------------------|-------------|----------------------|-------------|
| | Дүн | % | Дүн | % |
| Орон сууц, орон сууцны засвар | 349,797,988 | 16.46% | 247,684,064 | 11.75% |
| Боловсруулах үйлдвэр | 386,262,185 | 18.17% | 405,779,805 | 19.24% |
| Уул уурхай, хайгуул | 242,130,121 | 11.39% | 317,435,450 | 15.05% |
| Барилга | 227,687,785 | 10.71% | 252,836,499 | 11.99% |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 231,047,086 | 10.87% | 226,603,476 | 10.75% |
| Цалин, хэрэглээ | 250,908,681 | 11.80% | 188,046,423 | 8.92% |
| Эрчим хүч, шатахуун | 52,953,879 | 2.49% | 94,299,062 | 4.47% |
| Үл хөдлөх хөрөнгө | 82,144,387 | 3.86% | 84,369,105 | 4.00% |
| Санхүү | 43,172,238 | 2.03% | 61,402,508 | 2.91% |
| Хөдөө аж ахуй | 36,271,143 | 1.71% | 63,806,431 | 3.03% |
| Тээвэр ба харилцаа холбоо | 36,270,290 | 1.71% | 33,417,701 | 1.58% |
| Аялал жуулчлал | 19,748,261 | 0.93% | 27,276,789 | 1.29% |
| Дэд бүтэц | 8,220,063 | 0.39% | 18,485,159 | 0.88% |
| Засвар үйлчилгээ | 92,410,634 | 4.35% | 23,080,842 | 1.09% |
| Эрүүл мэнд | 22,975,984 | 1.08% | 19,417,976 | 0.92% |
| Зочид буудал, ресторан | 27,276,519 | 1.28% | 15,204,794 | 0.72% |
| Нийгмийн халамж | 2,682,903 | 0.13% | 19,960,309 | 0.95% |
| Гэр ахуйн цахилгаан бараа | 1,962,418 | 0.09% | 2,155,270 | 0.10% |
| Авто машин | 4,009,689 | 0.19% | 3,823,128 | 0.18% |
| Боловсрол | 2,461,998 | 0.12% | 2,617,177 | 0.12% |
| Олон нийтийн үйлчилгээ | 4,569,404 | 0.21% | 331,831 | 0.02% |
| Хувиараа эрхлэх аж ахуй | 543,857 | 0.03% | 606,498 | 0.03% |
| Олон улсын байгууллага | 68,452 | 0.00% | 64,944 | 0.00% |
Охин компаниас байршуулсан 1,231,005 мянган төгрөг (2015: 34,977 мянган төгрөг) нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд устгагдсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаах эрхгүй Банкны баталгаа болгон 7,391,954 мянган төгрөг (2015 оны 12 дугаар сарын 31: 10,041,027 мянган төгрөг) харилцагчдаас байршуулсан байсан. Дэлгэрэнгүйг тодруулга 39-аас харна уу.

Голомт Банк Групп

25 Зээлийн бусад эх үүсвэр

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|---|-------------------------|-------------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| <i>(а) Төслийн зээлийн эх үүсвэрүүд</i> | | |
| Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/ | 593,876,110 | 475,890,342 |
| Төслийн зээлийн эх үүсвэр /Доллар/ | 921,098 | 1,706,171 |
| Төслийн зээлийн эх үүсвэр /Евро/ | 1,043,461 | 1,158,211 |
| Нийт төслийн зээлийн эх үүсвэр | 595,840,669 | 478,754,724 |
| <i>(б) Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр</i> | | |
| Гадаадын Банкнаас авсан эх үүсвэр /Доллар/ | 497,834,077 | 199,659,254 |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Доллар/ | 89,470,981 | 88,668,903 |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Евро/ | 4,208,098 | 299,685 |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Юань/ | 5,671,627 | 2,458,416 |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /фунт стирлинг/ | 143,302 | - |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Иен/ | 2,701,243 | - |
| Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр | 600,029,328 | 291,086,258 |
| <i>(в) Монголбанкнаас авсан эх үүсвэр</i> | | |
| Монголбанкнаас авсан эх үүсвэр /Төгрөг/ | - | 245,093,973 |
| Нийт Монголбанкнаас авсан эх үүсвэр | - | 245,093,973 |
| Нийт (а+б+в) | 1,195,869,997 | 1,014,934,955 |

(а) Төслийн зээлийн эх үүсвэрүүд

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|----------------------|----------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр | | |
| Орон сууцны зээлийн эх үүсвэр | 232,770,498 | 102,504,132 |
| Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрийг дэмжих, зоорь агуулахыг нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр | 5,338,587 | 18,502,700 |
| КФВ Банкны төслийн эх үүсвэр | 4,580,317 | 5,557,120 |
| Бусад төслийн эх үүсвэр | 3,111,900 | 2,747,900 |
| Орон сууцны үнэ тогтворжуулах төслийн эх үүсвэр | - | 3,567,865 |
| Барилгын салбарыг дэмжих | - | 1,503,288 |
| Монгол Улсын Хөгжлийн Банкны төслүүд | | |
| Ноолууран бүтээгдэхүүний технологийг шинэчлэх төсөл | 98,354,244 | 102,264,240 |
| Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл | 48,022,000 | 48,022,000 |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төслийн эх үүсвэр | 41,133,334 | 41,204,480 |
| Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл | 25,926,550 | 26,360,050 |
| Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр | 23,372,257 | 33,478,823 |
| Ази-Европын уулзалтанд зориулсан эх үүсвэр | 21,422,706 | - |
| ҮХААЯам-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр | 21,274,202 | 23,697,726 |
| Бусад төслийн эх үүсвэрүүд | 7,839,890 | - |
| Хөдөө аж ахуй 2016 програм | 4,576,397 | - |
| Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр | 4,506,575 | - |
| Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл | 3,610,600 | 3,610,600 |
| Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл | | |
| Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | 12,001,016 | 21,458,237 |
| Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн эх үүсвэр | 456,956 | 926,167 |
| Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /төгрөг, доллар/ | 126,106 | 628,742 |
| Бусад Засгийн газрын төслүүд | | |
| Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн эх үүсвэр | 18,687,810 | 21,182,449 |
| Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | 14,521,244 | 15,213,147 |
| Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сангийн эх үүсвэр | 1,136,070 | 4,333,089 |
| Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр | 1,090,321 | 793,915 |
| Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр | 1,000,000 | - |
| Орон сууцны санхүүжилтийн төслийн эх үүсвэр | 485,084 | 693,885 |
| Бусад төслийн эх үүсвэр | 460,270 | 451,027 |
| 40,000 айлын орон сууц хөтөлбөрийн эх үүсвэр | 35,735 | 52,114 |
| Нөөцийн мах бүрдүүлэх төслийн эх үүсвэр | - | 1,028 |
| Нийт төслийн эх үүсвэр | 595,840,669 | 478,754,724 |

Монгол Улсын Засгийн газар, Төв Банк болон гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийн гол нөхцөлүүдийг дор дурьдав:

(а) Төслийн зээлийн эх үүсвэрүүд

Тодруулга 3-д үзүүлсний дагуу эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн Газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлттэй нөхцөлтэй зээлийг зорилгод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банк нь өөр зээлдэгчээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр зээлсэн бусад эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 0.9-өөс 6 хүртэлх хувийн хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 3.8-аас 9 хүртэлх хүүтэй байдаг. Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзгыг хүлээн зөвшөөрөх эсэхийг бодож үзсэн ба тусгай зах зээлийн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болон харилцагчид олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарз бүртгэгдэхгүй гэж үзсэн. Удирдлагын үнэлэмжийн талаар тодруулга 3-аас үзнэ үү. Томоохон төсөл хөтөлбөрүүдэд Монгол улсын засгийн газраас Монгол улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарт (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын хөгжлийн Банкны санхүүжилтууд багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурьдвал:

Гол нэрийн бараа бүтээгдэхүүн болон хүнсний нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан санамж бичигт Монгол улсын засгийн газар болон Монголбанк 2012 оны 10 дугаар сарын 22-нд гарын үсэг зурсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Банк нь 2012 оны 12 дугаар сарын 10-нд Түлшний үнийг тогтворжуулах, 2012 оны 12 дугаар сарын 24-нд хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, 2013 оны 05 дугаар сарын 07-нд Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах тухай гэрээг Монголбанкттай тус тус байгуулав. Түлшний үнийг тогтворжуулах болон хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зээлийн хүү жилийн 0.89 хувь бөгөөд Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад зээлийн эх үүсвэрийг жилийн 3.8 хувиар дамжуулан олгох юм. Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах зээлийн хүү нь жилийн 2.5-4 хувь бөгөөд Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад жилийн 5.5-7 хувийн хүүтэйгээр дамжуулан зээлдүүлнэ. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Банк эх үүсвэрээ заасан хугацаанд Монголбанкинд төлж чадахгүй бол Монголбанк өөрт байршиж буй Банкны данснаас шууд суутгах эрхтэй. 2016 онд Стратегийн импортын санхүүжилтийн схем (СИСС), Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (ХБҮТ) хөтөлбөрүүд гэрээний дагуу хэрэгжиж дууссан. Банк нь эдгээр хөтөлбөрийн хүрээнд үлдсэн бүх төлбөрийг төлж барагдуулсан байна.

Орон сууцны зээлийг санхүүжүүлэх засгийн газрын хөтөлбөрийн дагуу Банк 2016, 2015 болон 2014 онд хүрээнд 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад Банкин дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүд хамрагдах боломжтой. Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан зээлдэгч нарт 8 хувийн хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүний түвшнийг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тодорхойлох эрхгүй гэсэн үг. Хөтөлбөрийн дагуу олгогдох зээлийн саналыг болон 8 хувиас доош олгосон дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба эрсдлийг мөн үүрэх юм.

Банк Монгол Улсын Хөгжлийн Банкнаас (МУХБ) хэрэгжүүлж буй засгийн газраас санхүүжүүлж байгаа хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөтөлбөрт оролцож байгаа. 2013 оны 08 дугаар сарын 15-нд хүлэмжийн аж ахуйн, сүү сүүн бүтээгдэхүүний, оёдлын, ноолууран бүтээгдэхүүн болон ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк нь МУХБ-тай хамт гэрээнд гарын үсэг зурсан. Энэ гэрээний дагуу Банк жилийн 5.13-аас 5.7 хүртэл хувийн хүүтэй эх үүсвэр авч Монгол улсын Хөгжлийн Банкны гэрээнд заасан жилийн 8% хувийн хүүтэй зээлийг харилцагчдад олгосон. Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг

2014 оны 7 дугаар сараас хойш Банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй "Арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" зорилготой засгийн газрын өөр нэг төсөлд оролцож байна. Энэхүү хөтөлбөрийн нөхцлийн дагуу Банк нь уг эх үүсвэрийг МУХБ-наас жилийн 5 хувиар авж, харилцагчдад жилийн 7 хувиар олгодог. Бүх зээлдэгчдийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас батал ба Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

Түүнчлэн Банк Монгол улсын Хөгжлийн Банк болон арилжааны Банкуудаар дамжуулан "Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой 888 хөтөлбөр"-ийг санхүүжүүлэх Засгийн газрын төсөлд оролцож байгаа. Энэ гэрээний дагуу Банк нь 5 жилийн хугацаатай жилийн 3-аас 5 хүртэлх хувийн хүүтэй эх үүсвэр авч жилийн 7-оос 9 хувийн таатай хүүтэйгээр зээл олгож байна. Банк тогтоосон босго хүрээнд зээлийн хүүг тодорхойлох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн эрсдлийг хариуцна.

Банк 2015 онд Засгийн газрын Монгол Улсын Хөгжлийн Банкаар дамжуулан хэрэгжүүлж буй ноолуурын салбарыг санхүүжүүлэх хөтөлбөрт хамтран ажилласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк 3 хүртэлх жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эх үүсвэрийг авч, зорилгод харилцагчдад 9 хувийн хүүтэйгээр зээл олгох эрхтэй.

Банк 2016 онд Монгол Улсын Хөгжлийн Банкны санхүүжилтээр 11-р Ази-Европын уулзалтын төлөөлөгчдийг байршуулах зочид буудлыг санхүүжүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк гэрээний дагуу жилийн 4.5 хувийн хүүтэй эх үүсвэр авч 13 хувийн хүүтэй хөнгөлттэй нөхцөлтэй зээлийг шаардлага хангасан зочид буудлуудад олгосон. Банк нь энэхүү зээлийн эрсдэлийг үүрдэг.

Мөн засгийн газрын хэрэгжүүлж буй Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк Монгол улсын Хөгжлийн Банктай жижиг дунд бизнесийн төслүүдийг дэмжих гэрээнд гарын үсэг зурсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6 хувийн хүүтэй, 2019 оны 03 дугаар сарын 05 хүртэлх хугацаатай эх үүсвэрийг авсан. Банк зорилгод харилцагчдад зээл олгохдоо жилийн 9 хувь хүртэлх хүүг тогтоох эрхтэй.

АХБ-аас авсан эх үүсвэрт биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг байсан ба 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар эдгээр биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөөгүй байсан.

| категори | Зээл олгогч | Төслийн нэр | Валют | Олгосон огноо | Дуусах огноо | 2016.12.31 – нээрх зээлийн дүн /тухайн валютаар/ | 2016.12.31 – нээрх зээлийн дүн /төгрөгөөр/ |
|---|----------------------------|---|--------|---------------|--------------|--|--|
| Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр | Монголбанк | Орон сууцны зээлийн эх үүсвэр | Төгрөг | 06/14/2013 | 12/15/2016 | 232,680,115 | 232,680,115 |
| | Монголбанк | Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрийг дэмжих эх үүсвэр | Төгрөг | 12/19/2013 | 12/19/2017 | 5,334,458 | 5,334,458 |
| | Монголбанк | КФВ Банкны төслийн эх үүсвэр | Төгрөг | 05/16/2013 | 06/25/2021 | 3,530,325 | 3,530,325 |
| | Монголбанк | Бусад төслийн эх үүсвэр (АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх) | Төгрөг | 05/07/2001 | 05/07/2018 | 3,111,900 | 3,111,900 |
| | Монголбанк | КФВ Банкны төслийн эх үүсвэр | Евро | 12/11/2012 | 12/25/2020 | 400 | 1,043,186 |
| Монгол Улсын Хөгжлийн Банкны төслүүд | Монгол Улсын Хөгжлийн Банк | Ноолууран бүтээгдэхүүний технологийг шинэчлэх төсөл | Төгрөг | 08/12/2013 | 12/01/2017 | 98,354,244 | 98,354,244 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл | Төгрөг | 08/12/2013 | 12/01/2017 | 48,022,000 | 48,022,000 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төслийн эх үүсвэр(Монгол Улсын Хөгжлийн Банк) | Төгрөг | 08/12/2013 | 12/01/2017 | 38,447,864 | 38,447,864 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл | Төгрөг | 08/12/2013 | 12/01/2017 | 25,926,550 | 25,926,550 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Ази-Европын уулзалтанд зориулсан эх үүсвэр | Төгрөг | 03/11/2016 | 12/21/2018 | 21,412,000 | 21,412,000 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | ҮХААЯам-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр | Төгрөг | 08/22/2014 | 07/27/2021 | 21,259,438 | 21,259,438 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр (2 тэрбум – с бага) | Төгрөг | 08/28/2014 | 01/29/2020 | 19,134,287 | 19,134,287 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Экспортыг дэмжих, импортыг орлох төслийн эх үүсвэр (300 тэрбум хүртэлх) | Төгрөг | 09/28/2015 | 11/27/2020 | 5,834,333 | 5,834,333 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Хөдөө аж ахуй 2016 програм | Төгрөг | 04/14/2016 | 06/29/2018 | 4,571,825 | 4,571,825 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр | Төгрөг | 03/25/2016 | 02/28/2020 | 4,500,000 | 4,500,000 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр (2 тэрбум – с бага) | Төгрөг | 09/01/2014 | 12/30/2019 | 4,225,931 | 4,225,931 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл | Төгрөг | 08/12/2013 | 12/01/2017 | 3,610,600 | 3,610,600 |
| | Монгол Улсын Хөгжлийн Банк | Ноолууран бүтээгдэхүүний дэмжих төсөл | Төгрөг | 06/15/2015 | 12/15/2017 | 2,000,000 | 2,000,000 |

(а) Төслийн зээлийн эх үүсвэрүүд (үргэлжлэл)

| категори | Зээл олгогч | Төслийн нэр | Валют | Олгосон огноо | Дуусах огноо | 2016.12.31 – нээрх зээлийн дүн /тухайн валютаар/ | 2016.12.31 – нээрх зээлийн дүн /төгрөгөөр/ |
|--|---------------|---|-------|---------------|--------------|--|--|
| Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл | ЖАЙКА | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | MNT | 06/12/2009 | 12/31/2017 | 11,964,477 | 11,964,477 |
| | ЖАЙКА | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | USD | 09/29/2006 | 12/31/2019 | 183 | 456,408 |
| | Дэлхийн Банк | Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /төгрөг/ | MNT | 10/18/2007 | 12/20/2017 | 112,000 | 112,000 |
| Бусад Засгийн газрын төслүүд | Засгийн газар | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | MNT | 09/29/2006 | 08/01/2026 | 18,641,784 | 18,641,784 |
| | Засгийн газар | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | MNT | 06/12/2015 | 03/05/2019 | 11,303,421 | 11,303,421 |
| | Засгийн газар | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр | MNT | 07/10/2012 | 12/31/2017 | 3,190,975 | 3,190,975 |
| | Засгийн газар | Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сангийн эх үүсвэр | MNT | 01/04/2012 | 12/04/2018 | 1,134,167 | 1,134,167 |
| | Засгийн газар | Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр | MNT | 06/13/2011 | 12/13/2019 | 1,090,321 | 1,090,321 |
| | Засгийн газар | Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр | MNT | 11/30/2016 | 11/30/2026 | 1,000,000 | 1,000,000 |
| | Засгийн газар | Бусад төслийн эх үүсвэр (гадаадын банкнаас авсан сургалтын зээл) | USD | 11/12/2009 | 05/01/2027 | 183 | 454,453 |
| | Засгийн газар | АХБ – Орон сууцны санхүүжилтийн төслийн эх үүсвэр | MNT | 11/01/2008 | 11/01/2017 | 417,213 | 417,213 |
| | Засгийн газар | 40,000 айлын орон сууц хөтөлбөрийн эх үүсвэр | MNT | 02/27/2008 | 03/15/2019 | 31,038 | 31,038 |

(б) Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын Банкнаас авсан 497,834,077 мянган төгрөгийн эх үүсвэр нь 2015 оны 12 дугаар сарын 21-нд 18 сарын хугацаатай ба 2016 оны 7 дугаар сарын 15-нд 24 сарын хугацаатай гадаадын Банкнаас авсан 200,000 мянган ам.долларын зээлийг илэрхийлнэ. Уг зээл нь Банкны тухайн Банкин дахь харилцах дансаар баталгаажсан. Дэлгэрэнгүйг тодруулга 11-с үзнэ үү.

Банк нь өөрийн харилцагчдын худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын Банк болон санхүүгийн байгууллагаас худалдааны зээлийн эрх авсан. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 102,195,250 мянган төгрөгийн (2015 оны 12 дугаар сарын 31: 91,427,003 мянган төгрөг) зээлийн шугамыг ашиглаж мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдын импортын үйл ажиллагаанд зориулан олгосон байна. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 3 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчдын мөнгөн урсгал хийгээд гадаадын Банк санхүүгийн байгууллагад хийх эргэн төлөлтийн хугацаа нь таарч байна. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдлийг хариуцдаг. Худалдааны эх үүсвэр өсөлт нь бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас болон гадаадын банкнаас шинээр фунт стерлинг болон иен-ээр авсан санхүүжилттэй холбоотой.

Бусад зээлийн эх үүсвэрийн задаргааг Тодруулга 41-с харна уу. Бусад зээлийн эх үүсвэрийн валютын, зээлийн хүүний болон эргэн төлөгдөх хугацааны шинжилгээг Тодруулга 37-с харна уу.

Эдгээр эх үүсвэрүүд нь зээлийн хугацаанд ямар нэгэн биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус хүлээсэн үүрэг байхгүй.

(в) Монголбанкнаас авсан эх үүсвэр

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Монголбанкнаас авсан эх үүсвэр нь Монголбанкнаас 2015 оны 12 дугаар сарын 25-нд авсан 245 тэрбум төгрөгийн жилийн 14 хувийн хүүтэй, 3 хүртэлх сарын хугацаатай зээлийг илэрхийлнэ. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк уг зээлийн эх үүсвэрийг гэрээний дагуу бүрэн төлсөн болно.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

26 Репо хэлцэл

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан репо хэлцэлд нь 7.5-17 хувийн хүүтэй (2015: 13-15 хувийн хүүтэй), 7-941 хоногийн хугацаатай (2015: 4-7 хоногийн хугацаатай) репо хэлцлүүд орно. Эдгээр репо хэлцлүүд нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан. Дэлгэрэнгүйг тодруулга 13 болон 39-аас үзнэ үү.

27 Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрийг дэлгэрэнгүй байдлаар дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 31,383,555 | 8,813,244 | 31,353,878 | 8,787,403 |
| Гүйлгээний төлбөр | 18,336,020 | 3,363,447 | 18,336,020 | 3,363,447 |
| МИК-д худалдсан буцаах нөхцөлтэй зээлийн өр төлбөр | 5,539,233 | - | 5,539,233 | - |
| Дансны өглөг | 1,315,093 | 585,070 | 1,315,093 | 580,828 |
| Бусад | 6,193,209 | 4,864,727 | 6,163,532 | 4,843,128 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 2,710,213 | 3,568,111 | 2,701,720 | 3,568,111 |
| Ажилтнуудад өгөх өглөг | 1,527,632 | 1,957,680 | 1,527,450 | 1,957,680 |
| Орлогын албан татвараас бусад татварын өглөг | 1,182,581 | 1,610,431 | 1,174,270 | 1,610,431 |
| Нийт бусад өр төлбөр | 34,093,768 | 12,381,355 | 34,055,598 | 12,355,514 |

Гүйлгээтэй холбоотой төлбөр нь 2016 оны 12 дугаар сарын сүүлчийн өдрүүдэд харилцагчийн хүсэлтийн дагуу хийгдсэн шилжүүлгийн гүйлгээ ба тэдгээр нь 2017 оны 01 дүгээр сард бусад Банкуудад шилжүүлэгдэнэ. Иймээс харилцагчийн данснаас гүйлгээний дүн нь хасагдаж бусад өр төлбөрийн хэсэг болох "Гүйлгээний төлбөр" тусгай дансанд 2016 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар орсон ба 2017 оны 01 дүгээр сард энэхүү гүйлгээ нь Банк хоорондын тооцоогоор хийгдэж дууссан.

2016 онд Банк 2 удаагийн 8 хувийн орон сууцны зээлийг буцаах нөхцөлтэйгээр худалдах МИК-ийн мөнгөжүүлэх гүйлгээнд оролцсон. Банк 2016 онд 2,218,966 мянган төгрөгийн болон 3,943,479 мянган төгрөгийн орон сууцны зээлийн багцаа зарж, 15 хувийн хүүтэй эх үүсвэр хүлээн авсан. Эдгээр МИК-д худалдсан орон сууцны зээлтэй холбоотой эрсдэл ба өгөөж нь Банкинд үлдсэн. Иймээс эдгээр хөрөнгө нь данснаас хасах шаардлагыг хангаагүй ба МИК-ээс авсан эх үүсвэрийг санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусад өр төлбөрт байгаа уг өр төлбөр нь холбогдох зээлийн эргэн төлөлтөөр буурсан байна.

Бусад санхүүгийн өр төлбөрийн дийлэнх нь тайлант хугацаанаас хойш арван хоёр сарын дотор төлөгддөг ба бүх санхүүгийн бус өр төлбөр нь шинж чанарын хувьд богино хугацаатай байдаг.

Голомт Банк Групп

28 Хоёрдогч өглөг

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|----------------------|----------------------|
| Мянган төгрөгөөр | | |
| Голомт Файнэншил Группээс авсан хоёрдогч өглөг | 87,733,803 | 70,060,229 |
| Нийт | 87,733,803 | 70,060,229 |

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх хоёрдогч өглөг:

| | Гэрээний дүн / ам.доллар/ 12/31/2016 | Үлдэгдэл / ам.доллар/ 12/31/2015 | Хүү 12/31/2016 | Хүү 12/31/2015 | Дуусах огноо |
|-----------------------------|--------------------------------------|----------------------------------|----------------|----------------|--------------|
| Голомт Файнэншил Групп (I) | 10,000,000 | 10,000,000 | 8.0% | 6.0% | 2023-12-31 |
| Голомт Файнэншил Групп (II) | 25,000,000 | 25,000,000 | 8.0% | 5.1% | 2024-12-08 |
| Нийт хоёрдогч өглөг | 35,000,000 | 35,000,000 | | | |

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (I)

2007 онд Голомт Банк нь Кредит Свисс-ийн Сингапур улс дахь салбараас 5 жилийн хугацаатай, 10 сая ам.долларын хоёрдогч өглөгийг авсан. Зээлийн хугацаа 2012 оны 12 дугаар сарын 19-ны өдөр дууссан бөгөөд энэ өдрөөр зээл нь хувьцаанд хөрвөөгүй эсвэл эргэн төлөгдөөгүй байсан.

2013 оны 12 дугаар сарын 31-ны өдөр Кредит Свисс-н хоёрдогч өглөгийг Бодь Интернэшнл ХХК-д шилжүүлэх гэрээний нэмэлт өөрчлөлт дээр компаний гол хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэшнл ХХК болон Голомт Банк ХХК гарын үсэг зурсан. Шилжүүлэх гэрчилгээн дээр 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Голомт Банк, Бодь Интернэшнл ХХК, Кредит Свисс Ай Жи буюу Сингапур улс дахь салбар гарын үсэг зурснаар Бодь Интернэшнл ХХК буюу Банкны гол хувьцаа эзэмшигч нь 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Шилжүүлэх тохиролцлын гэрээний дагуу Кредит Свисс-с авсан хоёрдогч өглөгийг худалдаж авсан.

Кредит Свисс-н хоёрдогч өглөгийн зээлийн гэрээнд зээлдэгч нь хүссэн үедээ урьдчилан тохирсон худалдаж авах үнээр зээлийг энгийн хувьцаа руу хөрвүүлж болох нөхцөл болон санхүүгийн заавал биелүүлэх гэрээний нөхцөлүүдтэй байсан ба Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцаа руу хөрвүүлэх болон гэрээний заавал биелүүлэх нөхцөлүүдийг гэрээний өөрчлөлтөөр хассан.

Гэрээний гол нөхцөлүүд:

- (а) Зээлийн хүү нь жилийн 8%.
- (б) Зээл нь 2023 оны 12 дугаар сарын өдөр үндсэн дүн болон хуримтлагдсан хүүний хамт төлөгдөнө

2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК –руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ толгой компани болох Голомт Файнэншил Групп ХХК –руу шилжүүлсэн. 2016 оны 9 сарын 30-ны өдөр Голомт Файнэншил Групп ХХК болон Голомт банкны хооронд байгуулагдсан гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу хоёрдогч өглөгийн дуусгавар хугацаа болон хүүний хувийг сунгасан болно. Хоёрдогч өглөгийн хүүний хувь 6 хувиас 8 хувь болж, дуусгавар хугацаа нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31 ны хүртэл сунгагдсан болно.

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (II)

2010 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Банк нь Абу Даби Инвестментс Консулын 100% эзэмшлийн Стэнхөл Инвестментсээс 5 жилийн хугацаатай 25 сая ам.долларын хөрвөх зээлийг дараах нөхцөлтэйгээр авсан.Үүнд:

- Зээлийн хүү нь ЛИБОР дээр 4.5%-ийг нэмсэнтэй тэнцэх хүүтэй байх ба улирал бүр төлөгдөнө.
- Стэнхөл Инвестментс нь зээлийн гэрээний хугацаанд хүссэн үедээ уг зээлийг урьдчилан тохирсон худалдах, худалдан авах үнээр Банкны энгийн хувьцааруу хөрвүүлэх эрхтэй.

- Хэрэв гэрээнд тусгасан санхүүгийн болон санхүүгийн бус шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд Стэнхөп Инвестментс нь Банкнаас зээлийг эргүүлэн төлөхийг шаардах эрхтэй.

2014 оны 04 дүгээр сарын 30-нд шилжүүлэх гэрчилгээн дээр Бодь Интернэшнл ХХК, Голомт Банк ХХК болон Стэнхөп Инвестментс гарын үсэг зурснаар Банкны толгой компани Бодь Интернэшнл ХХК уг зээлийг Стэнхөп Инвестментсээс худалдаж авсан. Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцааруу хөрвүүлэх болон биелүүлэх ёстой шаардлагуудыг гэрээний өөрчлөлтөөр хассан. 2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК -руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ толгой компани болох Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсэн.

Уг хоёрдогч өглөгийн хугацаа 2015 оны 06 дугаар сарын 08-нд дууссан ба Банк болон Голомт Файнэншил Групп гэрээний өөрчлөлтөд гарын үсэг зурснаар уг зээлийн дуусах хугацааг 2020 оны 12 дугаар сарын 08 болгож сунгасан. 2016 оны 9 сарын 30-ны өдөр Голомт Файнэншил Групп ХХК болон Голомт банкны хооронд байгуулагдсан гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу хоёрдогч өглөгийн дуусгавар хугацаа болон хүүний хувийг сунгасан болно. Хоёрдогч өглөгийн хүүний хувь 5.1 хувиас 8 хувь болж, дуусгавар хугацаа нь 2020 оны 12 дугаар сарын 08-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 08-ний хүртэл сунгагдсан болно.

2016 оны 12 дугаар сарын 31 ба 2015 оны 12 дугаар сарын 31-нээр эдгээр хоёрдогч өглөгүүдэд биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус хүлээсэн үүрэг байхгүй. Холбоотой талуудын ажил үйлчилгээний мэдээллийг тодруулга 43-аас үзнэ үү.

29 Хувьцаат капитал

| Хувьцааны тоо ширхэгээс бусад дүн нь Мянган төгрөгөөр | Нийт гаргасан хувьцаа | Энгийн хувьцаа | Нэмэгдэж төлөгдсөн капитал | Давуу эрхтэй хувьцаа | Нийт |
|---|-----------------------|-------------------|----------------------------|----------------------|-------------------|
| 2015 оны 01 сарын 01-нээр | 26,217,093 | 26,217,093 | 44,699,421 | 25,778,900 | 96,695,414 |
| Тайлант жилд гаргасан | 150,500 | 150,500 | 707,650 | - | 858,150 |
| Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөцөөс шилжүүлсэн | - | - | 1,176,486 | - | 1,176,486 |
| 2015 оны 12 сарын 31-нээр | 26,367,593 | 26,367,593 | 46,583,557 | 25,778,900 | 98,730,050 |
| 2016 оны 12 сарын 31-нээр | 26,367,593 | 26,367,593 | 46,583,557 | 25,778,900 | 98,730,050 |

Банкны гаргасан хувьцаат капиталын нэрлэсэн үнээр бүртгэгдсэн дүн нь 26,367,593 мянган төгрөг (2015: 26,367,593 мянган төгрөг) байсан.

Хувьцааны нэмэгдэл нь шинээр гаргасан хувьцааг борлуулахад нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн төлбөр юм.

Энгийн хувьцаа

2016 оны 12 дугаар сарын 31 байдлаар Банк нь нийт 26,367,593 ширхэг (2014 оны 12 дугаар сарын 31: 26,367,593) нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй (2015: 1000 төгрөг) энгийн хувьцаа гаргасан байсан. Гаргасан бүх энгийн хувьцаа нь бүрэн төлөгдсөн байсан.

2015 онд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150,500 хувьцааг ажилчдад олгосон ба нэг бүрийг нь 5,702 төгрөгөөр худалдан авах опционы хэрэгжилтээр гаргасан. Энгийн хувьцаа гаргахтай холбогдуулан 707,650 мянган төгрөгийг нэмэгдэж төлсөн капитал дансанд бүртгэсэн.

2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх хувьцаа эзэмшигчдийн хувийг доорх байдлаар харуулав:

| Хувьцаа эзэмшигч | 2016 | 2015 |
|----------------------------|-------------|-------------|
| | Хувиар | Хувиар |
| Голомт Файнэншил Групп ХХК | 83.76% | 83.76% |
| СВИС МО Инвестмент Эй жи | 9.98% | 9.98% |
| Трафигура Бэхээр Би.ви | 4.93% | 4.93% |
| Ажилчдын хувьцаа | 1.33% | 1.33% |
| Нийт | 100% | 100% |

Голомт Банк Групп

29 Хувьцаат капитал (үргэлжлэл)

Давуу эрхтэй хувьцаа

2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн давуу эрхийн хувьцаа гаргах хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн дагуу 2013 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Голомт Банк болон Ноён Зоригт (Ноён Баясгалангийн бизнес хамтрагч) нарын хооронд давуу эрхтэй хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан

Гэрээний дагуу Банкны давуу эрхтэй хувьцаанд олгож буй нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 15,000,000 ам.доллар бөгөөд хоёр үе шаттай хэсэгчилсэн төлбөр байна. (2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10 сая ам.доллар мөн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 5 сая ам.доллар). 2015 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар давуу эрхтэй хувьцааны нийт дүн 15,000,000 ам.доллар буюу 25,788,900 мянган төгрөгтэй тэнцэх 25,788,900 ширхэг давуу эрхтэй хувьцаа байна.

30 Хүүгийн орлого ба зардал

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---|----------------------|----------------------|----------------------|----------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Хүүгийн орлого | | | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 261,336,134 | 285,607,728 | 261,336,134 | 285,607,728 |
| Дуусгавар хүртэл нь эзэмших | | | | |
| санхүүгийн хөрөнгө | 36,554,231 | 20,363,290 | 36,346,553 | 20,214,647 |
| Богино хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас | 23,621,571 | - | 23,621,571 | - |
| Бэлэн мөнгө болон Төв Банкинд | | | | |
| байршуулсан мөнгө | 9,387,860 | 7,892,101 | 9,387,860 | 7,892,101 |
| Бусад банкинд байршуулсан | 867,077 | 464,926 | 867,077 | 464,904 |
| Урвуу репо хэлцэл | 340,315 | 650,174 | 340,315 | 650,174 |
| Нийт хүүгийн орлого | 332,107,188 | 314,978,219 | 331,899,510 | 314,829,554 |
| Хүүний зардал | | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | (193,233,346) | (162,978,505) | (193,237,793) | (162,980,356) |
| Зээлийн бусад эх үүсвэр | (38,531,051) | (36,988,454) | (38,531,051) | (36,988,454) |
| Хоёрдогч өглөг | (6,085,952) | (3,547,250) | (6,085,952) | (3,547,250) |
| Бусад банкуудын байршуулсан хөрөнгө | (5,148,134) | (6,997,540) | (5,148,134) | (6,997,540) |
| Репо хэлцэл | (3,412,605) | (2,781,742) | (3,412,605) | (2,781,742) |
| Бусад | - | (70) | - | - |
| Нийт хүүгийн зардал | (246,411,088) | (213,293,561) | (246,415,535) | (213,295,342) |
| Цэвэр хүүгийн орлого | 85,696,100 | 101,684,658 | 85,483,975 | 101,534,212 |

Мөнгө болон Төв Банкинд байршуулсан хөрөнгийн хүүний орлого 9,149,482 (2015: 7,323,473 мянган төгрөг) мянган төгрөг нь Монголбанкны журмын дагуу бүх банкуудад олгосон Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийг 2016 онд хангаж байсантай холбоотой урамшуулал юм.

Харилцагчид олгосон үнэ цэнэ буурсан зээлээс хүлээн зөвшөөрсөн орлого 10.1 орчим тэрбум төгрөг байсан (2015: 16.2 тэрбум төгрөг). Удирдлагын зүгээс эдгээр зээлүүд нь бүрэн төлөгдөх ба үнэ цэнэ нь буурсан зээлүүд нь өндөр дүнтэй барьцаа хөрөнгөтэй гэж үзсэн. Мөн СТОУС-ын дагуу буцааж төлөгдөхгүй гэж үзсэн зээлийн хүүний орлогыг 2016 болон 2015 оны орлого зардалд хүлээн зөвшөөрөөгүй.

31 Хураамж, шимтгэлийн орлого ба зардал

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|--------------------|--------------------|--------------------|--------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Хураамж, шимтгэлийн орлого | | | | |
| Карттай холбоотой шимтгэл хураамж | 13,014,091 | 9,658,642 | 13,014,092 | 9,658,642 |
| Гуйвуулгын ба бусад үйлчилгээний хураамж | 7,192,124 | 4,700,063 | 7,135,876 | 4,690,939 |
| Баталгаа болон бусад бичиг цаасны шимтгэл, хураамж | 3,494,876 | 3,160,316 | 3,494,876 | 3,160,316 |
| Дансны үйлчилгээний шимтгэл хураамж | 3,370,834 | 3,278,742 | 3,367,956 | 3,277,639 |
| Брокерийн болон бусад үйлчилгээний хураамж | 1,369,102 | 641,026 | 969,566 | 256,489 |
| Нийт хураамж, шимтгэлийн орлого | 28,441,027 | 21,438,789 | 27,982,366 | 21,044,025 |
| Хураамж, шимтгэлийн зардал | | | | |
| Картын гүйлгээний зардал | (5,753,370) | (4,599,836) | (5,753,370) | (4,599,836) |
| Банкны үйлчилгээний зардал | (1,686,488) | (2,198,496) | (1,596,299) | (2,135,101) |
| Онлайн гүйлгээний зардал | (259,157) | (151,074) | (259,157) | (151,074) |
| Нийт хураамж, шимтгэлийн зардал | (7,699,015) | (6,949,406) | (7,608,826) | (6,886,011) |
| Хураамж, шимтгэлийн цэвэр орлого | 20,742,012 | 14,489,383 | 20,373,540 | 14,158,014 |

32 Үйл ажиллагааны бусад орлого

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|------------------|------------------|------------------|------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Данснаас хасагдсан зээлийн эргэн төлөлт | 943,167 | 4,090,143 | 943,167 | 4,090,143 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз) | 42,174 | 29,822 | 42,174 | 29,822 |
| Бусад | 411,695 | 258,113 | 406,382 | 257,477 |
| Нийт үйл ажиллагааны бусад орлого | 1,397,036 | 4,378,078 | 1,391,723 | 4,377,442 |

Голомт Банк Групп

33 Удирдлага ба үйл ажиллагааны зардал

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|--|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Ажилчдын зардал | 30,908,674 | 29,408,654 | 30,747,704 | 29,271,218 |
| Удирдлагын зардал | 9,659,404 | 7,862,943 | 9,615,557 | 7,820,999 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 9,669,168 | 9,252,991 | 9,661,972 | 9,248,578 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 7,560,235 | 7,154,618 | 7,555,529 | 7,136,274 |
| Түрээсийн зардал | 5,786,325 | 7,265,572 | 5,733,987 | 7,214,344 |
| Програм болон биет бус хөрөнгийн элэгдэл | 2,845,311 | 4,503,962 | 2,845,311 | 4,499,708 |
| Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээ | 2,133,614 | 2,371,779 | 2,127,745 | 2,294,737 |
| Эзэл цуглуулалтын зардал | 1,790,959 | 704,649 | 1,790,959 | 704,649 |
| Орлогын албан татвараас бусад татварын зардал | 1,408,834 | 855,964 | 1,408,834 | 855,964 |
| Тээврийн зардал | 895,116 | 1,129,638 | 894,489 | 1,129,557 |
| Томилолтын зардал | 742,586 | 663,417 | 721,410 | 645,151 |
| Ашиглалтын зардал | 614,482 | 563,049 | 600,641 | 554,216 |
| Хүлээн авалтын зардал | 478,315 | 721,756 | 478,315 | 721,756 |
| Сайн дурын болон заавал даатгах даатгалын зардал | 466,151 | 919,361 | 466,151 | 918,591 |
| Хандивын зардал | 164,600 | 44,739 | 164,600 | 44,739 |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө | 17,209 | 15,152 | 17,209 | 15,152 |
| Бусад | 2,427,760 | 2,354,613 | 2,420,880 | 2,286,397 |
| Нийт удирдлагын ба үйл ажиллагааны зардал | 77,568,743 | 75,792,857 | 77,251,293 | 75,362,030 |

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---------------------------------------|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Ажилчдын зардал: | | | | |
| Цалин хөлс, урамшуулал | 26,834,382 | 25,336,368 | 26,691,584 | 25,216,756 |
| Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл | 2,880,108 | 2,693,948 | 2,864,401 | 2,680,780 |
| Ажилчдын тэтгэмж | 620,815 | 571,186 | 620,815 | 571,186 |
| Ажилчдын сургалт | 419,222 | 417,756 | 416,757 | 414,118 |
| Тэтгэврийн сан | 154,147 | 389,396 | 154,147 | 388,378 |
| Нийт ажилчдын зардал | 30,908,674 | 29,408,654 | 30,747,704 | 29,271,218 |

34 Орлогын албан татвар

Тухайн жилийн орлого, зарлагад бүртгэсэн орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---|------------------|------------------|------------------|------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Тайлант жилийн орлогын албан татвар | - | 8,073,023 | - | 8,072,835 |
| Хойшлогдсон орлогын татвар | 7,471,460 | (1,326,905) | 7,472,658 | (1,331,256) |
| Тайлант жилийн орлогын татварын зардал | 7,471,460 | 6,746,118 | 7,472,658 | 6,741,579 |

Банк орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон орлогын татварын орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 3 тэрбум (2015: 3 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10 хувийн, 3 тэрбумаас (2015: 3 тэрбум) давсан дүнгээс 25 хувь (2015: 25 хувь)-ийн орлогын албан татвар төлдөг.

Тооцоолсон болон бодит татварын зардлын тохируулалтыг доорх хүснэгтэнд харуулав:

| Мянган төгрөгөөр | Групп | | Банк | |
|---|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| | 2016 | 2015 | 2016 | 2015 |
| Татварын өмнөх ашиг | 13,059,208 | 32,788,569 | 12,746,219 | 32,726,389 |
| Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал (2016: 25%; 2015: 25%) | 3,264,802 | 8,197,142 | 3,186,555 | 8,181,597 |
| Татвар ногдохгүй орлого, татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын татварын нөлөө: | | | | |
| - Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө | (450,000) | (450,000) | (450,000) | (450,000) |
| - Татвар ноогдох орлогоос чөлөөлөгдөх орлого | (269,435) | - | (268,373) | - |
| - Хасагдахгүй зардал | 2,612,450 | 980,143 | 2,610,943 | 980,143 |
| - Өөр хувиар татвар ногдуулах ЗГ-н ҮЦ-ний орлого | (5,408,961) | (1,970,161) | (5,359,677) | (1,970,161) |
| - Ирээдүйд шилжүүлэн бүртгээгүй татварын тайлангийн алдагдал | 7,753,210 | - | 7,753,210 | - |
| - Бусад | (30,606) | (11,005) | - | - |
| Тайлант жилийн орлогын албан татварын зардал | 7,471,460 | 6,746,119 | 7,472,658 | 6,741,579 |

25 хувиар татвар ноогдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөө:

| Мянган төгрөгөөр | 2016 оны 01 сарын 01 | Ашиг, алдагдалд тусгасан | Эзэмшигчдийн өмчид шууд тусгасан | 2016 оны 12 сарын 31 |
|--|----------------------|--------------------------|----------------------------------|----------------------|
| Хасагдах/татвар ногдох түр зөрүүгийн татварын нөлөө | | | | |
| Харилцагчдад олгосон зээл болон | | | | |
| урьдчилгаа - 90 хоногос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого | (5,143,512) | (8,179,770) | - | (13,323,282) |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө (Хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт) | 1,036,375 | (733,774) | - | 302,601 |
| Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | (1,473,130) | - | (133,666) | (1,606,796) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт, холбогдох зээлийг цэвэршүүлсэн | (10,051,754) | (10,238,253) | - | (20,290,007) |
| Урьдчилсан орлого – зээл олголтын төлбөр | 1,045,622 | 246,328 | - | 1,291,950 |
| Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа - МБ болон СТОУС-ын эрсдлийн сангийн зөрүү | 11,495,335 | (12,716,843) | - | (1,221,508) |
| Ирээдүйд шилжүүлэгдэх татварын тайлангийн алдагдал | - | 24,511,500 | - | 24,511,500 |
| Бусад | 18,070 | (361,846) | - | (343,776) |
| Нийт хойшлогдсон татварын өглөг | (3,072,994) | (7,472,658) | (133,666) | (10,679,318) |

Голомт Банк Групп

34 Орлогын албан татвар (үргэлжлэл)

2015 оны 25 хувиар татвар ноогдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөө:

| Мянган төгрөгөөр | 2015 оны 01 сарын 01 | Ашиг, алдагдалд тусгасан | Эзэмшигчдийн өмчид шууд тусгасан | 2015 оны 12 сарын 31 |
|---|----------------------|--------------------------|----------------------------------|----------------------|
| Хасагдах/татвар ногдох түр зөрүүгийн татварын нөлөө | | | | |
| Харилцагчид олгосон зээл болон урьдчилгаа - 90 хоногоос дээш хугацаа хэтрэлтэй зээлийн хүүгийн орлого | (3,941,902) | (1,201,610) | - | (5,143,512) |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө (Хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт) | - | 1,036,375 | - | 1,036,375 |
| Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | (161,673) | - | (1,311,457) | (1,473,130) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | (1,521,619) | (8,530,135) | - | (10,051,754) |
| Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа - МБ болон СТОУС-ын эрсдлийн сангийн зөрүү | 1,664,373 | (618,751) | - | 1,045,622 |
| Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа - МБ болон СТОУС-ын эрсдлийн сангийн зөрүү | 808,017 | 10,687,318 | - | 11,495,335 |
| Бусад | 60,011 | (41,941) | - | 18,070 |
| Нийт хойшлогдсон татварын өглөг | (3,092,793) | 1,331,256 | (1,311,457) | (3,072,994) |

35 Өмчийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хүлээн зөвшөөрсөн бусад дэлгэрэнгүй орлого

Өмчийн бүрэлдэхүүн хэсэг дэх бусад дэлгэрэнгүй орлогын задаргааг дор үзүүлэв:

| Мянган төгрөгөөр | 2016 | 2015 |
|---|------------------|------------------|
| Өөрчлөлт орсон: | | |
| - Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт (хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийг оруулаад) | 534,662 | 6,539,214 |
| - Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | 2,738,497 | - |
| Шууд дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн татварын зардал | (295,339) | (1,311,457) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 2,977,820 | 5,227,757 |

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

36 Ногдол ашиг

| Мянган төгрөгөөр | 2016 | | 2015 | |
|--|----------------|----------------------|----------------|----------------------|
| | Энгийн хувьцаа | Давуу эрхтэй хувьцаа | Энгийн хувьцаа | Давуу эрхтэй хувьцаа |
| 1 сарын 1-нээрх төлөх ёстой ногдол ашиг | - | - | - | - |
| Тайлант хугацаанд зарласан ногдол ашиг | - | - | - | 1,488,679 |
| Тайлант хугацаанд төлсөн ногдол ашиг | - | - | - | 1,488,679 |
| 12 сарын 31-нээрх төлөх ёстой ногдол ашиг | - | - | - | - |
| Тайлант хугацаанд зарласан нэгж хувьцааны ногдол ашиг | - | - | - | 5% |

Бүх ногдол ашигийг Монгол улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр зарлаж мөн төлдөг. Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

37 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Банкны эрсдэлийн удирдлага нь санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, комплаенсийн эрсдэл, каунтерпарти эрсдэл, гуравдагч талын эрсдэл, хуулийн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, технологийн эрсдэл болон бусад цаг үеийн шинж чанартай тулгарах эрсдэлүүдийг хамардаг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (гадаад валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон бусад зах зээлийн үнээс хамаарсан эрсдэл), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэл багтдаг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дэмжигдэж батлагдсан банкны “Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон Эрсдэлийн аппетитын тунхаглал”-ын хүрээнд эрсдэл өгөөжийн тэнцвэрт байдлыг хадгалах явдал юм.

“Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон Эрсдэлийн аппетитын тунхаглал”-ийн үндсэн зорилго нь банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хил хязгаарыг тодорхойлоход орших ба энэхүү хил хязгаарын хүрээнд банк бизнесийн зорилгодоо хүрэх, стратеги хэрэгжүүлэхээр ажиллана. Энэ нь банкны үйл ажиллагаанд тулгарах эрсдэлүүдийн хамгийн ерөнхий хязгаарлалтуудыг тодорхойлж өгдөг ба тодорхой эрсдэлүүд дээр баримтлах нарийвчилсан лимит хязгаарлалтууд холбогдох бодлого, журмын хүрээнд ерөнхий хязгаарлалтуудтай нийцтэй байдлаар тогтоогдоно. Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон тунхаглалын баримт бичгийг жил бүр банкны стратеги төлөвлөгөө, төсөвтэй уялдуулж дүгнэн, шаардлагатай тохиолдолд шинэчлэнэ. Банканд шаардлагатай өөрийн хөрөнгө, стратеги төлөвлөгөөг эрсдэлийн түвшинтэй уялдуулж ажиллана.

Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үндсэн зорилгуудын нэг юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд эрсдэлийн засаглалын үндсэн бүрдүүлэгчид болох эрсдэлийн соёл, эрсдэлийн аппетитын хязгаар, эдгээрийн эрсдэл даах чадвар болон банкны нэгдсэн хяналт, баланстай үүсгэх уялдаа холбоог нэн тэргүүнд чухалчилна. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Гурван давхар хамгаалалтын шугам” бүхий эрсдэлийн засаглалын бүтцийг банканд хэрэгжүүлнэ. Ашгийн төлөө ажиллаж буй бизнесийн нэгжүүд нэгдүгээр хамгаалалтын шугам, Эрсдэлийн удирдлагын хороо ба Эрсдэлийн удирдлагын газрын захирал хоёрдугаар хамгаалалтын шугамыг үүсгэж, Дотоод аудитын газар гуравдугаар хамгаалалтын шугам болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон эрсдэлийн удирдлагын бодлого, хязгаарлалтын дагуу гүйцэтгэх түвшиний удирдлагууд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг. Дотоод аудитын газар болон Эрсдэлийн удирдлагын газар нь бизнесийн нэгжүүд болон бусад нэгжийн ажилчид хяналтын үүргүүдээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хараат бус хяналт тавихаас гадна ТУЗ-ийн Эрсдэлийн хороо, Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад харъяалагдах Удирдлагын хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Эрсдэлийн удирдлагын хяналт, шалгалт нь банкны холбогдох хорооноос баталсан эрсдэлийн лимит хязгаарлалтуудад суурилан хийгддэг. Эдгээр лимит хязгаарлалтууд нь банкны бизнесийн стратеги, зах зээлийн нөхцөл байдал болон бизнесийн үйл ажиллагаандаа хүлээн зөвшөөрөн ажиллаж байгаа эрсдэлийн түвшинд уялдаатай тогтсон байдаг. Хүү, гадаад валютын ханш болон бусад зах зээлийн үнийн хэлбэлзлээс шалтгаалан үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор стресс тест шинжилгээг хийж, банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын нэг хэсэг болгосон.

Зээлийн эрсдэл

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн эсвэл хэсэгчлэн биелүүлээгүйгээс шалтгаалж банк алдагдал хүлээхийг зээлийн эрсдэл гэж ойлгоно. Зээлийн эрсдэл зээлдэгч зээл төлөхгүй байх болон зээлийн төвлөрлийн эрсдэл гэсэн 2 төрөлд хуваагддаг.

Төлбөрийн эрсдэл

Эрсдэлийн удирдлагын газрын Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь бизнесийн нэгжүүдийн гүйцэтгэл эрсдэлийн аппеттийн хүрээнд байгаа эсэхийг хянаж, зээлийн бодлого, журмыг тогтмол сайжруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ зээлийн бүтээгдэхүүний үнийг тогтооход чухал ач холбогдолтойгоор оролцдог. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуудан зээлийн багцад стресс тест хийж, банкны түүхэн тоон мэдээлэлд тулгуурлан зээлийн багцын чанарын үзүүлэлтүүдийн прогноз гарган тогтмол судалгаа, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг хийх замаар эрсдэлийг хянаж удирддаг.

Зээлийн багцын эрсдэлийг ОУ-ын стандартын дагуу тогтмол үнэлдэг бөгөөд Базел III-ийн зөвлөмжүүд, СТОУС-9 стандартыг нэвтрүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Улирал бүр Эрсдэлийн Удирдлагын Хороонд банкны зээлийн багцын чанарын хяналт, Зээлийн бодлого журмын хэрэгжилт, цаашид үүсэх нөхцөл байдлыг танилцуулахын зэрэгцээ Банкны Удирдлагын багийг мэдээллээр ханган, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг.

Балансын гадуурх санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл гэдэг нь харилцагч тал зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас алдагдал хүлээхийг хэлнэ. Групп нь болзошгүй өр төлбөрийн хувьд мөн адил зээлийн бодлого, батлагдсан эрсдэлийн хязгаарлалтуудын хүрээнд санхүүгийн хэрэглүүрүүдийг удирддаг.

Банкны зээлийн эрсдэлийн хамгийн өндөр нөлөөлөл нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнээр тусгагдсан байна. Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд хөрөнгө ба өр төлбөрийг цэвэрлэснээс үүдэх томоохон нөлөөлөлгүй. Баталгаа болон үүргийн хувьд зээлийн эрсдэлд үзүүлэх нөлөөлөл нь Эрсдэлийн удирдлагын 37-р тодрууллагад тайлбарласан нийт өр төлбөртэй тэнцүү байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ болон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн зах зээлийн үнийн (санхүүгийн үүсмэл хэрэгслүүд) хэлбэлзэлээс шалтгаалан банканд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк зах зээлийн эрсдэлийг хэмжих түлхүүр үзүүлэлтүүд, эрсдэлийн лимитүүдийг дараах эрсдэлүүдийн хувьд тогтоодог. Үүнд:

- Зах зээлийн эрсдэл – арилжаа, гадаад валютын ханшийн эрсдэл
- Хүүгийн эрсдэл
- Эх үүсвэр, хөрвөх чадварын эрсдэл
- Хамтын санхүүжилт/Андеррайтинг ба Өөрийн хөрөнгийн үнэ цэнийн эрсдэл

Банк санхүүгийн зах зээлд явуулах үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг дундаж хэмжээнд хүлээн зөвшөөрөх ба энэ нь холбогдох бодлого, журмуудад тусгагддаг. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны эрсдэлийн удирдлагын стратегийг жил бүр тодорхойлж, зах зээлийн эрсдэлийн лимит хязгаарлалтуудыг санхүүгийн хэрэгсэл бүрийн хувьд тогтоодог. Банкны Актив, пассивын удирдлагын хороо нь хүү, гадаад валютын ханшийн эрсдэлд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгөх замаар Эрсдэлийн удирдлагын хорооноос баталсан эрсдэлийн лимит, хязгаарлалтуудын биелэлтийг хянадаг ба банкны үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдалд ирээдүйд учрах магадлалтай нөхцөл байдлууд хэрхэн нөлөөлөхийг мөн тодорхойлдог.

Нөөцийн удирдлагын газар нь банкны активын бүтцийг хянах, хөрөнгө оруулалтын хэрэгслүүд болон хеджи хийх санхүүгийн хэрэгслүүдийг Эрсдэлийн удирдлагын хороо болон Актив пассивын удирдлагын хорооноос баталсан бодлого журамд заасны дагуу, зөвшөөрөгдсөн лимит хязгаарлалтын хүрээнд ашиглах замаар зах зээлийн эрсдэлийг өдөр тутамд удирддаг.

Эрсдэлийн удирдлагын газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагыг бодлого, хяналтын түвшинд удирдаж Гүйцэтгэх захирал болон Актив пассивын удирдлагын хороонд шууд тайлагнаж ажилладаг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Зах зээл дээрх гадаад валютын ханшийн хэлбэлзэлээс шалтгаалан банкны эзэмшиж буй гадаад валютын актив, пассивын үнэ цэнэ өөрчлөгдөж, банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хэмжээнд сөрөг өөрчлөлт гарахыг гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Групп болон банкны санхүүгийн нөхцөл байдал болон мөнгөн урсгал нь гадаад валютын ханшийн хэлбэлзэлээс шалтгаалан эрсдэлд өртөмтгий байдаг. Аливаа валютын хувьд ханшийн эрсдэлээс хамгаалаагүй нээлттэй позиц нь банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг ихэсгэж байдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гадаад валютын ханшийн эрсдэлийн аппетитыг тодорхойлж, нийт валютын хувьд нээлттэй позицын дээд хэмжээ болон гадаад валютын багцын “Хамгийн их эрсдэл”-ийн лимитийг тогтоодог. Банкны Актив пассивын удирдлагын хороо нь ТУЗ-өөс баталсан гадаад валютын ханшийн эрсдэлийн аппетиттай нийцтэй байдлаар валютын арилжааны лимитүүдийг салбар тус бүрийн хувьд тогтоодог.

Банк гадаад валютын нээлттэй позицоос үүсэх ханшийн эрсдэлийг “Хамгийн их эрсдэл”-ийн аргыг ашиглан тооцоолж ажилладаг. Гадаад валютын ханшийн хэлбэлзэлээс шалтгаалан, тодорхой хугацааны турш үүсч болзошгүй хамгийн их эрсдэлийг өгөгдсөн итгэх магадлалын түвшинд вариаци-ковариаци, түүхэн үүсгэвэр болон Монте-карло симуляци гэсэн гурван төрлийн аргачлалыг ашиглан тооцдог. Хамгийн их эрсдэлийн үнэлгээг нэг болон арван өдрийн хугацааны интервалуудын хувьд тооцож, үнэлгээний үр дүнг бодит эрсдэлтэй харьцуулан өдөр тутамд буцаан шалгаж, баталгаажуулж ажилладаг. Монголбанкны дүрэм, журмын дагуу банк хамгийн их эрсдэлийн үнэлгээг 10 өдрөөр, 99 хувийн итгэх магадлалын түвшинд тооцоолж байна. Хамгийн их эрсдэлийн аргачлалаас гадна зах зээлийн онцгой нөхцөл байдалд үүсч болзошгүй хүлээгдээгүй эрсдэлийг илрүүлэх зорилгоор стресс тестийг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдахдаа банк дараах стратегиудыг баримталдаг. Үүнд:

- Гадаад валютын актив, пассивын зөрүүг аль болох бага байлгах;
- Гадаад валютын своп, форвард хэлцэлүүд болон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглан ханшийн эрсдэлийг бууруулах;
- Маржинал болон компонент “Хамгийн их эрсдэл”-ийг ашиглан гадаад валютын багцад диверсификаци хийх замаар ханшийн эрсдэлийг бууруулах;

Гадаад валютын ханшийн хэлбэлзэлээс шалтгаалан валютын зээлүүд чанаргүйдэх шууд бус эрсдэл нь зээлдэгчийн орлогын эх үүсвэр ямар валютаар илэрхийлэгдэхээс шалтгаалдаг. Зээл олгогдсон валют нь харилцагчийн орлогын эх үүсвэрийн валютаас ялгаатай байх тохиолдолд зах зээл дээрх валютын ханшийн хэлбэлзэл зээлдэгчийн зээлээ эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлж, улмаар зээл чанаргүйдэхэд хүргэх магадлалтай. Зээлийн багцад эзлэх гадаад валютын ханшийн эрсдэлтэй зээлийн хувь хэмжээ нь тодорхой эрсдэлийн лимиттэй ба уг лимитийг зах зээлийн нөхцөл байдал болон банкны бизнес төлөвлөгөөнөөс хамаарч тогтмол шинэчилдэг.

2016 оны 12 сарын 31-ний өдрийн Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр харуулав. Группын гадаад валютын ханшийн эрсдэл нь Банкны эрсдэлээс мэдэгдэхүйц зөрүүгүй.

| Мянган төгрөгөөр | Төгрөг | Ам.Доллар | Евро | Бусад | Нийт |
|---|----------------------|----------------------|-------------------|--------------------|----------------------|
| Санхүүгийн мөнгөн хөрөнгө | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад) | 62,526,270 | 181,803,360 | 37,552,013 | 34,919,549 | 316,801,192 |
| Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц | 166,053,150 | 149,579,945 | - | - | 315,633,095 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 358,339,356 | 37,038,100 | - | 45,138 | 395,422,594 |
| Урвуу РЕПО хэлцэл | 9,995,766 | - | - | - | 9,995,766 |
| Бусад банкуудын байршуулсан хөрөнгө | 75,696 | 705,512,457 | 12,494,372 | 74,072,030 | 792,154,555 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,710,846,910 | 308,724,550 | 4,645,178 | 10,643,117 | 2,034,859,755 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас | 41,979,911 | - | - | - | 41,979,911 |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 119,085,719 | - | 51,595 | 7,028,614 | 126,165,928 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 120,274,349 | - | - | - | 120,274,349 |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 44,660,926 | - | - | - | 44,660,926 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | 5,049,835 | - | - | - | 5,049,835 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 9,909,931 | 1,602,244 | 91,411 | 579,137 | 12,182,723 |
| Нийт санхүүгийн мөнгөн хөрөнгө | 2,648,797,819 | 1,384,260,656 | 54,834,569 | 127,287,585 | 4,215,180,629 |
| Санхүүгийн мөнгөн өр төлбөр | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 7,928,360 | 78,119,553 | 17,018,435 | 18,835,669 | 121,902,017 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | |
| - Харилцах | 371,150,294 | 329,197,842 | 10,823,065 | 64,082,691 | 775,253,892 |
| - Хугацаагүй хадгаламж | 298,843,585 | 200,098,382 | 8,668,624 | 18,947,154 | 526,557,745 |
| - Хугацаатай хадгаламж | 804,196,487 | 677,715,125 | 12,243,995 | 7,360,316 | 1,501,515,923 |
| РЕПО хэлцэл | 37,408,551 | - | - | - | 37,408,551 |
| Зээлсэн бусад эх үүсвэр | 593,876,110 | 588,226,156 | 5,251,559 | 8,516,172 | 1,195,869,997 |
| Хоёрдогч өглөг | - | 87,733,803 | - | - | 87,733,803 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 23,542,684 | 6,322,557 | 837,439 | 651,198 | 31,353,878 |
| Нийт санхүүгийн мөнгөн өр төлбөр | 2,136,946,071 | 1,967,413,418 | 54,843,117 | 118,393,200 | 4,277,595,806 |
| Үүсмэл хэрэглүүр | (491,784,150) | 619,892,970 | - | - | 128,108,820 |
| Балансын цэвэр позиц | 20,067,598 | 36,740,208 | (8,548) | 8,894,385 | 65,693,643 |

Голомт Банк Групп

37 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Гадаад валютын ханшийн эрсдэл (үргэлжлэл)

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны валютын эрсдлийг дор харуулав. Группийн валютын эрсдэл нь Банкны эрсдэлээс мэдэгдэхүйц зөрүүгүй.

| Мянган төгрөгөөр | Төгрөг | Ам.Доллар | Евро | Бусад | Нийт |
|---|----------------------|----------------------|-------------------|-------------------|----------------------|
| Санхүүгийн мөнгөн хөрөнгө | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад) | 106,306,098 | - | 26,657,454 | 25,160,735 | 158,124,287 |
| Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц | 187,241,047 | 73,498,365 | - | - | 260,739,412 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | - | 4,232,791 | - | 1,177,247 | 5,410,038 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 93,219 | 310,979,307 | 9,542,022 | 28,619,457 | 349,234,005 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,577,877,623 | 432,862,829 | 1,271,601 | 1,598,734 | 2,013,610,787 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас | - | - | - | - | - |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 62,404,024 | - | 43,217 | 5,640,809 | 68,088,050 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 592,831,917 | - | - | - | 592,831,917 |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 50,133,051 | - | - | - | 50,133,051 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 8,135,706 | 452,264 | 48,006 | 23,517 | 8,659,493 |
| Нийт санхүүгийн мөнгөн хөрөнгө | 2,585,022,685 | 822,025,556 | 37,562,300 | 62,220,499 | 3,506,831,040 |
| Санхүүгийн мөнгөн өр төлбөр | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 22,192,407 | 48,010,921 | 14,843,348 | 4,953,994 | 90,000,670 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | - | - | - | - | - |
| - Харилцах | 270,529,387 | 209,649,818 | 5,357,514 | 24,655,389 | 510,192,108 |
| - Хугацаагүй хадгаламж | 252,120,544 | 84,983,026 | 6,947,688 | 16,190,877 | 360,242,135 |
| - Хугацаатай хадгаламж | 729,860,747 | 464,189,226 | 9,188,387 | 6,127,991 | 1,209,366,351 |
| РЕПО хэлцэл | 174,280,920 | - | - | - | 174,280,920 |
| Зээлсэн бусад эх үүсвэр | 720,984,315 | 290,034,328 | 1,457,896 | 2,458,416 | 1,014,934,955 |
| Хоёрдогч өглөг | - | 70,060,229 | - | - | 70,060,229 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 6,782,059 | 1,453,365 | 172,298 | 379,681 | 8,787,403 |
| Нийт санхүүгийн мөнгөн өр төлбөр | 2,176,750,379 | 1,168,380,913 | 37,967,131 | 54,766,348 | 3,437,864,771 |
| Үүсмэл хэрэглүүр | (282,877,432) | 323,084,446 | - | - | 40,207,014 |
| Балансын цэвэр позиц | 125,394,874 | (23,270,911) | (404,831) | 7,454,151 | 109,173,283 |

Ханшийн хэлбэлзлээс бусад бүх хүчин зүйлсийг тогтмол үед тайлант хугацааны эцсийн ханшийн харьцангуй боломжит өөрчлөлт нь Банкны ашиг, алдагдалд үзүүлэх мэдрэмжийг доорх хүснэгтэд тусгав. Группын валютын эрсдэл нь Банкны эрсдэлээс мэдэгдэхүйц зөрүүгүй.

| Мянган төгрөгөөр | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|--|----------------------|----------------------|
| Ам.доллар 25%-иар чангарахад (2015 14%-иар чангарахад) | 9,185,052 | (3,257,928) |
| Ам.доллар 25%-иар сулрахад (2015 14%-иар сулрахад) | (9,185,052) | 3,257,928 |
| Евро 20%-иар чангарахад (2015 5%-иар чангарахад) | (1,710) | (20,242) |
| Евро 20%-иар сулрахад (2015 5%-иар сулрахад) | 1,710 | 20,242 |
| Юань 15%-иар чангарахад (2015 11%-иар чангарахад) | (11,824,800) | (155,818) |
| Юань 15%-иар сулрахад (2015 11%-иар сулрахад) | 11,824,800 | 155,818 |
| Хонгконг доллар 25%-иар чангарахад (2015 14%-иар чангарахад) | 1,392,926 | 986,690 |
| Хонгконг доллар 25%-иар сулрахад (2015 14%-иар сулрахад) | (1,392,926) | (986,690) |
| Бусад валют 25%-иар чангарахад (2015 1%-иар чангарахад) | 20,538,671 | 18,229 |
| Бусад валют 25%-иар сулрахад (2015 1%-иар сулрахад) | (20,538,671) | (18,229) |

Хүүгийн эрсдэл

Группын хувьд арилжааны бус үйл ажиллагаанаас үүсч буй гол зах зээлийн эрсдэл нь хүүгийн эрсдэл бөгөөд хүүгийн эрсдэлийн удирдлага нь банкны өөрийн хөрөнгө болон ашгийн түвшинд хүүгийн өөрчлөлтийн үзүүлэх сөрөг нөлөөг багасгах зорилготой. Группын хүүгийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь хүүгийн түвшинд гарах өөрчлөлтийн сөрөг нөлөөг хязгаарлаж, ашгийг нэмэгдүүлэх ба хүүгийн эрсдэлд өртөх боломжтой хөрөнгийг удирдах замаар хүүгийн цэвэр орлогыг нэмэгдүүлэх юм.

Групп хүүгийн эрсдэлд өртөж болзошгүй гол шалтгаан нь татсан эх үүсвэрээс өөр ялгаатай дүн ба хугацаагаар, тогтмол хүүтэйгээр зээл олгох үйл ажиллагаатай холбоотой байдаг. Практик дээр богино хугацаанд хүү тогтмол байдаг. Мөн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитой тусгахын тулд хөрөнгө болон өр төлбөрийн гэрээгээр тохиролцсон тогтмол хүүг дахин тохиролцох, өөрчлөх шаардлага үүсдэг. Банк нь боломжит хүүгийн эрсдэлийг тооцон хяналт тавьж, хүүгийн эрсдэлийг удирдах, бууруулахын тулд лимит тогтоох замаар хүүгийн эрсдэлийг удирддаг. Гап анализ (зөрүүний менежмент), хугацааны анализ (жигнэсэн дундаж дуусгавар болох хугацааны анализ) ба хүүгийн орлогын симуляци зэрэг аргыг хүүгийн эрсдэлийн түвшнийг тодорхойлоход ашигладаг. Үүнээс гадна банк нь хүүгийн зөрүүний менежмент, хүүгийн хэджинг, тогтоогдсон лимитийг дагаж мөрдөх замаар эрсдэлийг удирдаж бууруулдаг. Хүүгийн лимитийн процесс нь дараах зүйлсийг багтаадаг, үүнд (i) алдагдлын дээд лимит, (ii) хүүгийн зөрүүний лимит (iii) эх үүсвэрийг байршуулах хүүгийн хамгийн бага түвшин.

Банкны Актив Пассивын Удирдлагын Хороо хүүгийн түвшний зөрүүний өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэмжээнд лимит тогтоодог ба тогтмол хяналт тавьдаг. Хэджинг хийх боломжтой хэрэгсэл байхгүй тохиолдолд Групп нь өөрийн хүүгийн позицийг зөрүүгүй байлгахыг эрмэлздэг.

Доорх хүснэгтэнд Банкны болзошгүй хүүгийн эрсдэлийг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэнд банкны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ цэний нийлбэр дүнг хүүнд өөрчлөлт орох хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв. Группын болзошгүй эрсдэл ба Банкны болзошгүй эрсдэлийн хооронд материаллаг зөрүү байхгүй.

| Мянган төгрөгөөр | Хугацаагүй болон | | | | | Нийт |
|--|--------------------|----------------------|----------------------|---------------------|--------------------|----------------------|
| | 1-ээс бага сар | 1 – 6 сар | 6 – 12 сар | 1 – 5 жил | 5-аас дээш жил | |
| 2016 оны 12 сарын 31 | | | | | | |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,951,575,732 | 862,695,768 | 426,504,389 | 849,661,147 | 301,765,214 | 4,392,202,250 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,875,449,276 | 1,038,740,100 | 619,671,791 | 740,479,600 | 3,255,039 | 4,277,595,806 |
| 2016 оны 12 сарын 31-нээрх хүүгийн өөрчлөлтөнд нээлттэй цэвэр позиц | 76,126,456 | (176,044,332) | (193,167,402) | 109,181,547 | 298,510,175 | 114,606,444 |
| 2016 оны 12 сарын 31 | | | | | | |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,715,944,979 | 496,377,515 | 517,199,743 | 601,083,838 | 216,431,979 | 3,547,038,054 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,487,035,647 | 728,308,538 | 516,593,364 | 683,028,095 | 22,899,127 | 3,437,864,771 |
| 2016 оны 12 сарын 31-нээрх хүүгийн өөрчлөлтөнд нээлттэй цэвэр позиц | 228,909,332 | (231,931,023) | 606,379 | (81,944,257) | 193,532,852 | 109,173,283 |

Хүүгийн эрсдэл (үргэлжлэл)

Өр төлбөрийн хүүнээс илүү өндөр хүү төлдөг хөрөнгөөс шалтгаалан үүссэн хүүгийн зөрүүний мэдрэмжээс үүдэн Банкинд хүүгийн эрсдэл учирдаг. Бусад бүх хувьсагчийг тогтмол байна гэж үзвэл 2016 оны 12 сарын 31-ний байдлаар хүүгийн түвшин 10%-иар их (бага) байсан тохиолдолд 2016 оны санхүүгийн үзүүлэлт нь 11,460,645 мянган төгрөгөөр их (бага) (2015: MNT 10,917,328 мянган төгрөгөөр их (бага) байх байсан. Үүний үндсэн шалтгаан нь 2016 оны өндөр цэвэр хүүгийн зөрүүний мэдрэмж ба хүүнд гарсан өөрчлөлт юм.

Тайлант хугацааны эцэс дэх Банкны болзошгүй хүүгийн эрсдэл нь жилийн дундаж эрсдэлийн илэрхийлэл болохгүй. 2016 оны дундаж эрсдэлийн хувьд бусад бүх хувьсагчийг тогтмол байна гэж үзвэл хүүгийн түвшин 10%-иар их (бага) байсан тохиолдолд 2016 оны санхүүгийн үзүүлэлт 8,548,398 мянган төгрөгөөр их (бага) (2015: 10,153,422 мянган төгрөгөөр их (бага)) байх байсан.

Банк нь өөрийн санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинд тогтмол хяналт тавьдаг. Доорх хүснэгтэнд гол удирдлагын түвшний ажилчдын хянасан тайлангууд дээр үндэслэн харьяа тайлант хугацааны хүүгийн түвшнийг хураангуйлан үзүүлэв. Үнэт цаасны хувьд хүү нь тайлант хугацааны зах зээлийн үнэлгэн дээр үндэслэн гаргасан дуусгавар болох хугацаа хүртэлх өгөөжийн хувийг хэлнэ:

| Жилийн хувиар | 2016 | | | | 2015 | | | |
|---|--------|-----------|------|-------|--------|-----------|------|-------|
| | Төгрөг | Ам.доллар | Евро | Бусад | Төгрөг | Ам.доллар | Евро | Бусад |
| Хөрөнгө | | | | | | | | |
| Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц | 6.5% | - | - | - | 5.0% | - | - | - |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 8.0% | - | 6.7% | - | 1.6% | - | - | - |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 14.9% | 11.8% | 0.3% | 9.4% | 14.1% | 12.4% | 8.2% | 11.1% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас | | | | | | | | |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 10.2% | - | - | - | 12.2% | - | - | - |
| Өр төлбөр | | | | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 14.0% | 6.0% | 3.3% | 5.9% | - | 3.2% | 6.7% | 3.7% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | | | |
| - Харилцах | 1.9% | 0.9% | 0.7% | 0.0% | 1.4% | 0.8% | 0.3% | - |
| - Хугацаагүй хадгаламж | 8.1% | 3.1% | 1.9% | 1.3% | 6.4% | 3.3% | 1.9% | 1.5% |
| - Хугацаатай хадгаламж | 14.5% | 6.9% | 3.6% | 3.0% | 14.8% | 8.1% | 3.7% | 3.3% |
| РЕПО хэлцэл | 10.4% | - | - | - | 14.9% | - | - | - |
| Зээлийн бусад эх үүсвэр | 4.4% | 1.6% | 2.1% | 4.3% | 7.9% | 2.2% | 1.4% | 4.9% |
| Хоёрдогч өглөг | - | 8.0% | - | - | - | 5.3% | - | - |

“ - ” тэмдгийг тухайн валютаар холбогдох хөрөнгө, өр төлбөр байхгүй, эсхүл тухайн хөрөнгө өр төлбөр нь хүүгүй гэж ойлгоно.

Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл

Группийн бараг бүх санхүүгийн хөрөнгө 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад байршсан байсан. 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн гол санхүүгийн өр төлбөр Монгол улстай хамааралтай байсан. Группийн бүс нутгийн төвлөрлийн эрсдлийг харилцагчдын болон салбарын төрөлжүүлэлтээр бууруулж байгаа гэж удирдлага үзэж байгаа болно.

Бусад төвлөрлийн эрсдэл

Хэд хэдэн гэрээлэгч тал нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаанд оролцдог эсвэл нэг газарзүйн байршилд үйл ажиллагаа явуулдаг эсвэл эдийн засаг, улс төр ба бусад нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх чадварт нь ижил төстэй нөлөө үзүүлэх бизнесийн ижил төстэй шинж чанартай үед төвлөрөл үүсдэг. Төвлөрлийн түвшин нь аль нэг эдийн засгийн салбар эсвэл газарзүйн байрлалын нөхцөл байдалд нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүд нь Группын үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлэх болохыг хэмждэг.

Хэт өндөр төвлөрлийн эрсдэлээс зайлсхийхийн тулд диверсификаци өндөртэй хөрөнгийн багцтай байх талаар нарийн, тодорхой бодлого журмыг Группээс тодорхойлж өгсөн байдаг. Зээлийн эрсдэлийн төвлөрлийг тодорхойлж, тохирох эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Монголбанкнаас дараах лимийг тогтоож өгдөг:

- i. Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй;
- ii. Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн таван хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй;

Олгогдсон зээлийн эрсдэлийн тайлангуудаар дамжуулан удирдлагын зүгээс эрсдэлд хяналт тавьдаг ба мэдээлдэг. Эдийн засгийн салбарын төвлөрлийн эрсдэл зэрэг төвлөрлийн эрсдэлийн талаарх мэдээллийг Тодруулга 12-оос олж авах боломжтой.

Төлбөрийн чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдгээр байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд нь хүндрэл учрахыг хэлдэг. Хоногийн хугацаатай хадгаламж, харилцах данс, хугацаа нь дуусгавар болж буй хадгаламжууд, зээлийн ашиглалт, баталгаа батлан даалт болон бэлэн мөнгөөр тооцоо хийдэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүдтэй холбоотойгоор бэлэн мөнгөний гарах урсгалын хэрэгцээ Группын хувьд өдөр бүр гарч байдаг. Хугацаа нь дуусгавар болж буй эх үүсвэрийн тодорхой хувь нь гадагшлахгүй, хугацаа нь сунгагдах магадлал маш өндөр болохыг туршлагаас тогтоосон тул мөнгөний гарч болзошгүй гадагшаа урсгалын нийт дүнд хүрэлцэхүйц бэлэн мөнгөний нөөцийг Групп дээр байнга хадгалдаггүй.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага нь хөрвөх чадварын эрсдэлийг хугацаагаар нь ангилан нэгтгэдэг бөгөөд хэвийн болон стресстэй нөхцөл байдалд богино ба дунд хугацааны төлбөрийн үүргээ биелүүлэх чадвартай байхаар хөрвөх чадварыг удирддаг. Хөрвөх чадварын удирдлагыг банкны дотоод хязгаар лимит ба прогноз дээр үндэслэн бүх газар нэгж болон салбаруудаар дамжуулан Нөөцийн удирдлагын газраас бодит цаг хугацаанд авч хэрэгжүүлдэг. Томоохон хэмжээний зээл бүртэй холбоотой шийдвэр, түүний хөрвөх чадварт үзүүлэх нөлөөг НУГ-ын захиралтай хэлэлцэж зөвлөлддөг. ТУЗ-ын Эрсдэлийн удирдлагын хороо нь зохицуулагч байгууллагуудын тавьсан шаардлага болон олон улсын стандартын дагуу хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын стандартыг тогтоосноор банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог бүрдүүлдэг. Хөрвөх чадварын эрсдэлийн иж бүрэн үнэлгээний нэг хэсэг болгож Актив пассивын удирдлагын хороо нь дараах хүчин зүйлсийн үзүүлэх нийт нөлөөг тооцоолж, хяналт тавьдаг, үүнд: (i) богино ба дунд хугацааны бэлэн мөнгөний менежмент; (ii) санхүүгийн чадавхи сайтай тайлан тэнцэл, баланстай байх; (iii) гадаад валютын хөрвөх чадварын менежмент; (iv) санхүүжилтийн эх үүсвэрийн диверсификаци өндөр байх; (v) хөрвөх чадварын стресс тест тогтмол хийх; ба (vi) хөрвөх чадварын эрсдэл учирсан тохиолдолд хэрэгжүүлэх үр дүнтэй төлөвлөгөөтэй байх.

Монголбанкны шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааг Банк өдөр бүр тооцоолж гаргадаг. Жилийн туршид хөрвөх чадварын харьцаа доор үзүүлсний дагуу байсан:

| | 2016 | 2015 |
|-----------------------|--------|--------|
| 12 сарын 31 | 44.80% | 38.06% |
| Тайлант жилийн дундаж | 39.43% | 31.92% |
| Хамгийн их | 44.43% | 38.06% |
| Хамгийн бага | 30.33% | 25.57% |

Доорх хүснэгтэнд 2016 оны 12 сарын 31 болон 2015 оны 12 сарын 31-ний байдлаар хөрөнгө ба өр төлбөрийн дүнг гэрээгээр дуусгавар болоход үлдсэн хугацаагаар нь ангилан үзүүлэв. Хүснэгтэнд үзүүлсэн дүн нь гэрээний дагуу, бууралт хийгдээгүй бэлэн мөнгөний дүн юм. Энэхүү бууруулаагүй дүн нь бууруулсан бэлэн мөнгөний дүн дээр суурилж гаргасан санхүүгийн позицгийн тайлангын дүнгээс зөрүүтэй байна.

Голомт Банк Групп

37 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

2016 оны 12 сарын 31-ний байдлаар гэрээгээр хүлээсэн үүргийн бууруулаагүй дүн дээр суурилсан санхүүгийн хэрэгслүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь доор үзүүлсний дагуу байна:

| Мянган төгрөгөөр | Хугацаагүй болон 1-ээс бага сар | 1 – 6 сар | 6 – 12 сар | 1 – 5 жил | 5-аас дээш жил | Нийт |
|--|---------------------------------------|----------------------|----------------------|----------------------|--------------------|----------------------|
| Хөрөнгө | | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкнд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад) | 316,807,727 | - | - | - | - | 316,807,727 |
| Монголбанкнд байршуулсан заавал байлгах нөөц | 315,633,095 | - | - | - | - | 315,633,095 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 7,801,772 | 311,533,000 | 64,667,100 | 36,747,940 | - | 420,749,812 |
| Урвуу РЕПО хэлцэл | 10,004,234 | - | - | - | - | 10,004,234 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 792,149,433 | 30,677 | - | - | - | 792,180,110 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 268,585,986 | 497,622,590 | 405,893,684 | 938,812,129 | 465,244,433 | 2,576,158,822 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас | 42,000,000 | - | - | - | - | 42,000,000 |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 126,165,928 | - | - | - | - | 126,165,928 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 6,274,791 | - | - | 47,090,432 | 209,522,293 | 262,887,516 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл (хөрөнгө) | | | | | | |
| - Орох урсгал | 34,983,498 | 336,579,404 | - | 236,472,808 | - | 608,035,710 |
| - Гаргах урсгал | (26,228,050) | (248,585,770) | - | (156,200,269) | - | (431,014,089) |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 44,660,926 | - | - | - | - | 44,660,926 |
| Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө | 5,049,835 | - | - | - | - | 5,049,835 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 12,182,723 | - | - | - | - | 12,182,723 |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,956,071,898 | 897,179,901 | 470,560,784 | 1,102,923,040 | 674,766,726 | 5,101,502,349 |
| Өр төлбөр | | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 104,081,618 | 18,352,217 | - | - | - | 122,433,835 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | |
| - Харилцах | 775,253,892 | - | - | - | - | 775,253,892 |
| - Хугацаагүй хадгаламж | 526,557,746 | - | - | - | - | 526,557,746 |
| - Хугацаатай хадгаламж | 218,219,260 | 688,603,346 | 600,842,912 | 67,678,151 | - | 1,575,343,669 |
| Зээлийн бусад эх үүсвэр | 150,143,144 | 386,569,221 | 91,047,893 | 578,551,804 | 960,945 | 1,207,273,007 |
| РЕПО хэлцэл | 15,424,170 | - | - | 24,843,425 | - | 40,267,595 |
| Хоёрдогч өглөг | 600,253 | 3,485,342 | 4,979,060 | 132,161,986 | - | 141,226,641 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 26,014,719 | 270,411 | 346,493 | 3,543,257 | 5,286,196 | 35,461,076 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,816,294,802 | 1,097,280,537 | 697,216,358 | 806,778,623 | 6,247,141 | 4,423,817,461 |
| Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэг | | | | | | |
| Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэг | 320,829,812 | - | - | - | - | 320,829,812 |
| Батлан даалт, импортын аккредитив | 182,076,448 | - | - | - | - | 182,076,448 |
| Зээлийн шугам | 138,753,364 | - | - | - | - | 138,753,364 |
| Цэвэр зөрүү | (181,052,716) | (200,100,636) | (226,655,574) | 296,144,417 | 668,519,585 | 356,855,076 |
| Хуримтлагдсан цэвэр зөрүү | (181,052,716) | (381,153,352) | (607,808,926) | (311,664,509) | 356,855,076 | - |

2015 оны 12 сарын 31-ний байдлаар гэрээгээр хүлээсэн үүргийн бууруулаагүй дүн дээр суурилсан санхүүгийн хэрэгслүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь доор үзүүлсний дагуу байна:

| Мянган төгрөгөөр | Хугацаагүй болон 1-ээс бага сар | 1 – 6 сар | 6 – 12 сар | 1 – 5 жил | 5-аас дээш жил | Нийт |
|---|---------------------------------|----------------------|----------------------|----------------------|--------------------|----------------------|
| Хөрөнгө | | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад) | 158,124,287 | - | - | - | - | 158,124,287 |
| Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц | 260,739,412 | 1,752,388 | - | - | - | 262,491,800 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 5,410,038 | - | - | - | - | 5,410,038 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 349,203,676 | 30,761 | - | - | - | 349,234,437 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 389,804,501 | 518,892,703 | 480,262,195 | 754,237,082 | 234,492,343 | 2,377,688,824 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | - | - | - | - | - | - |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 68,088,050 | - | - | - | - | 68,088,050 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 429,446,068 | 11,347,717 | 102,147,865 | 35,865,138 | 148,253,545 | 727,060,333 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл (хөрөнгө) | - | - | - | - | - | - |
| - Орох урсгал | 60,135,749 | 71,527,567 | - | 191,421,130 | - | 323,084,446 |
| - Гарах урсгал | (57,002,050) | (63,927,221) | - | (161,948,161) | - | (282,877,432) |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 50,133,051 | - | - | - | - | 50,133,051 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 8,634,629 | 24,864 | - | - | - | 8,659,493 |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,722,717,411 | 539,648,779 | 582,410,060 | 819,575,189 | 382,745,888 | 4,047,097,327 |
| Өр төлбөр | | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 55,036,519 | 35,382,496 | - | - | - | 90,419,015 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | |
| - Харилцах | 508,811,279 | 1,380,829 | - | - | - | 510,192,108 |
| - Хугацаагүй хадгаламж | 360,242,135 | - | - | - | - | 360,242,135 |
| - Хугацаатай хадгаламж | 200,752,516 | 573,650,053 | 393,611,202 | 102,221,358 | - | 1,270,235,129 |
| Зээлийн бусад эх үүсвэр | 188,090,468 | 137,883,784 | 177,738,706 | 571,649,573 | 24,236,675 | 1,099,599,206 |
| РЕПО хэлцэл | 174,566,190 | - | - | - | - | 174,566,190 |
| Хоёрдогч өглөг | - | 2,072,160 | 1,871,231 | 82,290,838 | - | 86,234,229 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 4,832,919 | 2,431,067 | 1,437,822 | 85,595 | - | 8,787,403 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,492,332,026 | 752,800,389 | 574,658,961 | 756,247,364 | 24,236,675 | 3,600,275,415 |
| Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэг | | | | | | |
| Батлан даалт, импортын аккредитив | 169,622,565 | - | - | - | - | 169,622,565 |
| Зээлийн шугам | 118,044,485 | - | - | - | - | 118,044,485 |
| Цэвэр зөрүү | (57,281,665) | (213,151,610) | 7,751,099 | 63,327,825 | 358,509,213 | 159,154,862 |
| Хуримтлагдсан цэвэр зөрүү | (57,281,665) | (270,433,275) | (262,682,176) | (199,354,351) | 159,154,862 | - |

Голомт Банк Групп

37 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Групп нь дээр үзүүлсэн өр төлбөрийн гэрээгээр дуусах хугацааны бууруулаагүй дүнгийн хугацааны шинжилгээг хөрвөх чадварыг удирдахдаа ашигладаггүй. Үүний оронд Групп нь хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа болон хүлээгдэж буй бэлэн мөнгөний хэрэгцээний зөрүүнд хяналт тавьдаг. 2016 оны 12 сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн хэрэгслийн дуусгавар болох хугацааны шинжилгээг доор үзүүлэв. Банкны эрсдэл ба Группын эрсдэлийн хооронд материаллаг зөрүү байхгүй

| Мянган төгрөгөөр | Хугацаагүй болон 1-ээс бага сар | 1 – 6 сар | 6 – 12 сар | 1 – 5 жил | 5-аас дээш жил | Нийт |
|---|---------------------------------------|----------------------|----------------------|----------------------|--------------------|----------------------|
| Хөрөнгө | | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад) | 316,801,192 | - | - | - | - | 316,801,192 |
| Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц | 315,633,095 | - | - | - | - | 315,633,095 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 7,801,772 | 300,173,993 | 59,375,770 | 28,071,059 | - | 395,422,594 |
| Урвуу РЕПО хэлцэл | 9,995,766 | - | - | - | - | 9,995,766 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 792,124,555 | 30,000 | - | - | - | 792,154,555 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 264,170,800 | 474,498,141 | 367,128,619 | 700,635,181 | 228,427,014 | 2,034,859,755 |
| Богино хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас | 41,979,911 | - | - | - | - | 41,979,911 |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 126,165,928 | - | - | - | - | 126,165,928 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас | 6,253,781 | - | - | 40,682,368 | 73,338,200 | 120,274,349 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл (хөрөнгө) | | | | | | |
| - Орох урсгал | 34,983,498 | 336,579,404 | - | 236,472,808 | - | 608,035,710 |
| - Гарах урсгал | (26,228,050) | (248,585,770) | - | (156,200,269) | - | (431,014,089) |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 44,660,926 | - | - | - | - | 44,660,926 |
| Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө | 5,049,835 | - | - | - | - | 5,049,835 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 12,182,723 | - | - | - | - | 12,182,723 |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,951,575,732 | 862,695,768 | 426,504,389 | 849,661,147 | 301,765,214 | 4,392,202,250 |
| Өр төлбөр | | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 104,004,017 | 17,898,000 | - | - | - | 121,902,017 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | |
| - Харилцах | 775,253,892 | - | - | - | - | 775,253,892 |
| - Хугацаагүй хадгаламж | 526,557,746 | - | - | - | - | 526,557,746 |
| - Хугацаатай хадгаламж | 275,259,778 | 636,146,463 | 532,234,112 | 57,875,569 | - | 1,501,515,922 |
| Зээлийн бусад эх үүсвэр | 152,402,164 | 384,438,047 | 87,127,999 | 571,023,255 | 878,532 | 1,195,869,997 |
| РЕПО хэлцэл | 15,408,551 | - | - | 22,000,000 | - | 37,408,551 |
| Хоёрдогч өглөг | 600,253 | - | - | 87,133,550 | - | 87,733,803 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 25,962,875 | 257,590 | 309,680 | 2,447,226 | 2,376,507 | 31,353,878 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,875,449,276 | 1,038,740,100 | 619,671,791 | 740,479,600 | 3,255,039 | 4,277,595,806 |
| Санхүүгийн хэрэглүүрүүдийн цэвэр зөрүү | 76,126,456 | (176,044,332) | (193,167,402) | 109,181,547 | 298,510,175 | 114,606,444 |
| Хуримтлагдсан цэвэр зөрүү | 76,126,456 | (99,917,876) | (293,085,278) | (183,903,731) | 114,606,444 | - |

2015 оны 12 сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн хэрэгслийн дуусгавар болох хугацааны шинжилгээг доор үзүүлэв. Банкны эрсдэл ба Группын эрсдэлийн хооронд материаллаг зөрүү байхгүй.

| Мянган төгрөгөөр | Хугацаагүй болон 1-ээс бага сар | 1 – 6 сар | 6 – 12 сар | 1 – 5 жил | 5-аас дээш жил | Нийт |
|--|---------------------------------------|----------------------|--------------------|---------------------|--------------------|----------------------|
| Хөрөнгө | | | | | | |
| Бэлэн мөнгө ба Төв Банкнд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад) | 158,124,287 | - | - | - | - | 158,124,287 |
| Монголбанкнд байршуулсан заавал байлгах нөөц | 260,739,412 | - | - | - | - | 260,739,412 |
| Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө | 5,410,038 | - | - | - | - | 5,410,038 |
| Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө | 349,203,676 | 30,329 | - | - | - | 349,234,005 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 383,069,690 | 485,457,181 | 424,091,880 | 570,577,173 | 150,414,863 | 2,013,610,787 |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас | 68,088,050 | - | - | - | - | 68,088,050 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө | | | | | | |
| орруулалтын үнэт цаас | 429,408,447 | 3,264,795 | 93,107,863 | 1,033,696 | 66,017,116 | 592,831,917 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл (хөрөнгө) | | | | | | |
| - Орох урсгал | 60,135,749 | 71,527,567 | - | 191,421,130 | - | 323,084,446 |
| - Гарах урсгал | (57,002,050) | (63,927,221) | - | (161,948,161) | - | (282,877,432) |
| Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө | 50,133,051 | - | - | - | - | 50,133,051 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 8,634,629 | 24,864 | - | - | - | 8,659,493 |
| Нийт санхүүгийн хөрөнгө | 1,715,944,979 | 496,377,515 | 517,199,743 | 601,083,838 | 216,431,979 | 3,547,038,054 |
| Өр төлбөр | | | | | | |
| Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө | 55,006,000 | 34,994,670 | - | - | - | 90,000,670 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | |
| - Харилцах | 508,811,279 | 1,380,829 | - | - | - | 510,192,108 |
| - Хугацаагүй хадгаламж | 360,242,135 | - | - | - | - | 360,242,135 |
| - Хугацаатай хадгаламж | 200,061,384 | 556,548,049 | 362,040,270 | 90,716,648 | - | 1,209,366,351 |
| Зээлийн бусад эх үүсвэр | 183,801,010 | 132,953,923 | 153,115,272 | 522,165,623 | 22,899,127 | 1,014,934,955 |
| РЕПО хэлцэл | 174,280,920 | - | - | - | - | 174,280,920 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | 70,060,229 | - | 70,060,229 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 4,832,919 | 2,431,067 | 1,437,822 | 85,595 | - | 8,787,403 |
| Нийт санхүүгийн өр төлбөр | 1,487,035,647 | 728,308,538 | 516,593,364 | 683,028,095 | 22,899,127 | 3,437,864,771 |
| Санхүүгийн хэрэглүүрүүдийн цэвэр зөрүү | 228,909,332 | (231,931,023) | 606,379 | (81,944,257) | 193,532,852 | 109,173,283 |
| Хуримтлагдсан цэвэр зөрүү | 228,909,332 | (3,021,691) | (2,415,312) | (84,359,569) | 109,173,283 | - |

Голомт Банк Групп

37 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Дээрх шинжилгээ нь хүлээгдэж буй дуусах хугацаан дээр суурилсан тул борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө ангилалд багтсан нийт хөрөнгийн багц нь удирдлагаас гаргасан багцын хөрвөх чадварын үнэлгээний дагуу “Харилцах ба 1 сараас бага” хугацааны интервалд орсон.

Группын удирдлагын үзэж байгаагаар Группын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хөрөнгө ба өр төлбөрийн дуусгавар болох хугацаа ба хүүгийн тохируулга ба/эсвэл хяналттай зөрүү нь зайлшгүй шаардлагатай. Банкуудын хувьд гүйлгээ тодорхойгүй хугацаагаар, олон төрлөөр хийгддэг тул хугацаа ба хүүгийн ямар ч зөрүүгүй байна гэдэг маш ховор ихэнхдээ маш ховор тохиолдол байдаг. Зөрүүтэй позиц нь үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой боловч алдагдал хүлээх эрсдэлийг мөн ихэсгэх магадлалтай. Группын хөрвөх чадвар болон хүү ба валютын ханшинд өртөж болзошгүй эрсдэлийг үнэлэхэд хөрөнгө ба өр төлбөрийн дуусгавар болох хугацаа, хэт өндөр биш өртгөөр эх үүсвэрийг орлуулах чадвар нь чухал хүчин зүйлүүд болдог.

Харилцагчдын нэлээд хэсгийн данс нь харилцах данс байдаг хэдий ч хадгаламж эзэмшигчдийн тоо ба төрлийн диверсификацийн түвшин ба Группын туршлага нь эдгээр дансууд Группын хувьд урт хугацааны тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр болдог гэж удирдлагын зүгээс үзэж байна.

Баталгаа ба аккредитивын хувьд хөрвөх чадварын шаарлага нь холбогдох төлбөрийн үүргээс хамаагүй бага байдаг. Учир нь ихэнх тохиолдолд гуравдагч талын этгээд нь гэрээнд тусгагдсан эх үүсвэрээ эргүүлэн татахгүй гэж Группын зүгээс үздэг. Гэрээгээр хүлээсэн санхүүжилт олгох үүргийн нийт хэмжээ нь ирээдүйд шаардагдах бэлэн мөнгөний дүнг заавал илтгэдэггүй. Учир нь эдгээр санхүүжилт олгох үүргүүдийн зарим хэсэг нь олгогдохгүйгээр дуусгавар болдог эсвэл цуцлагддаг.

38 Капиталын удирдлага

Банк нь өөрийн хөрөнгийг удирдахдаа дараах зорилгуудыг баримталдаг. Үүнд: Монголбанкнаас тавьсан өөрийн хөрөнгийн шаардлагуудыг чанд мөрдөх, нэрлэвэл харилцагчийн харилцах хадгаламжыг эрсдэлгүй байлгах систем, Банкны үйл ажиллагаа өөдрөг төсөөлөлд үндэслэх мөн Монголбанкны шаардлагын дагуух нийт өөрийн хөрөнгө болон нийт активыг эрсдэлийн шинж чанараар тохируулсан дүнд суурилсан эрсдлээр жигнэсэн хөрөнгийн харьцааг хамгийн багадаа

14% (2015: 14%) байх шалгуурыг ханган ажиллах. Монголбанкнаас тавьдаг өөрийн хөрөнгийн харьцааны шаардлага хангасан эсэхийг өдөр бүрийн бодит мэдээлэл болон сар бүр өөрсдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн Банкны удирдлагууд болон Санхүү эрхэлсэн захирлаар хянуулдаг.

Банк нь Банкны ирээдүйн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зах зээлд болоод хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн итгэлийг хадгалан ажиллахын тулд өөрийн хөрөнгийн шаардлагатай түвшинг ханган ажиллах сонирхолтой байна. Монголбанкны тодорхойлсон өөрийн хөрөнгийн шаардлагын дагуу эрсдлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа нь (өөрийн хөрөнгийн харьцаа) заасан хамгийн бага түвшнээс дээгүүр байх ёстой.

Доорх хүснэгт нь Монгол Улсын хууль (Монголбанкны шаардлагын) тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн Банкны тайланд үндэслэсэн өөрийн хөрөнгийн бүтцийг харуулав:

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|---|----------------------|----------------------|
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт | 10.19% | 12.62% |
| Эрсдлээр жигнэсэн активын харьца | 14.77% | 16.62% |

| | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|---|----------------------|----------------------|
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | | |
| Энгийн хувьцаа | 26,367,593 | 26,367,593 |
| Нэмэгдэж төлөгдсөн капитал | 46,583,557 | 46,583,557 |
| Хуримтлагдсан ашиг | 240,438,730 | 247,534,836 |
| Өөрийн хөрөнгийн бусад хэсэг | 358,212 | 4,581,064 |
| Санхүүгийн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт 75% | (9,163,369) | (7,704,517) |
| Нийт 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | 304,584,723 | 317,362,533 |
| 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | | |
| Хоёрдогч өглөг | 87,133,550 | 69,859,300 |
| Давуу эрхтэй хувьцаа | 25,778,900 | 25,778,900 |
| Дахин үнэлгээний нөөц | 9,644,867 | 7,476,100 |
| Бусад нөөц | 17,401,574 | - |
| Санхүүгийн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт 25% | (3,054,456) | (2,568,172) |
| Нийт 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | 136,904,435 | 100,546,128 |
| Нийт өөрийн хөрөнгө / капиталын суурь | 441,489,158 | 417,908,661 |

Санхүүгийн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн байгууллагуудад хувьцаа хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалт юм. Дэлгэрэнгүйг тодруулга 14, 17-оос үзнэ үү.

39 Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Шүүн таслах ажиллагаа. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Групп өөрийнх нь эсрэг мэдүүлсэн нэхэмжлэл хүлээн авах тохиолдлууд байдаг. Өөрсдийн хийсэн тооцоолол ба Банкны дотоодын мэргэжлийн зөвлөгөөн дээр үндэслэн удирдлага нь Банкинд материаллаг хохирол үүсгэх шүүхийн нөхцөл байдал байхгүй гэж дүгнэсэн тул эдгээр санхүүгийн тайлангуудад үүнтэй холбогдуулан сан байгуулаагүй болно.

2014 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын (ШӨХТГ) Улсын байцаагч нарын дүгнэлтээр арилжааны Банкууд зээл олгохдоо зээл олголтын шимтгэлийг авч холбогдох хууль, журмыг зөрчиж байна гэж үзсэн. Гэсэн хэдий ч Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн дүгнэлтээр арилжааны банкуудын талд шүүхийн дүгнэлт гарсан. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ШӨХТГ-аас арилжааны Банкуудтай холбоотой ямар нэгэн шүүхийн нэхэмлэх улсын дээд шүүхэд хүргүүлээгүй байна. Удирдлагын зүгээс ШӨХТГ Улсын дээд шүүхэд нэхэмжлэл гаргахыг тооцож үзсэн бөгөөд уг нэхэмжлэхийн шүүхийн шийдвэртэй холбоотой гарах эрсдэл нь бага гэж үзсэн.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ШӨХТГ-аас арилжааны банкуудтай холбоотой шүүхийн нэхэмжлэх улсын дээд шүүхэд хүргүүлээгүй байна. Банкны эрх зүйн зөвлөхийн үнэлгээн дээр үндэслэн, ШӨХТГ арилжааны банкуудтай холбоотой шүүхийн нэхэмжлэх улсын дээд шүүхэд цаашид хүргүүлэхгүй тул удирдлагын зүгээс үүнтэй холбоотой сан санхүүгийн байдлын тайлан дээр байгуулаагүй болно.

Татварын хууль тогтоомж. Монгол Улсын татварын, валютын болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх магадлалтай. Эдгээр хууль тогтоомжуудыг Банкны ажил гүйлгээ болон үйл ажиллагаанд удирдлагын тайлбарлан хэрэгжүүлсэн байдал нь татварын байгууллагынхаас зөрөх магадлалтай.

Монгол Улсын татварын байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримтлаж болох бөгөөд өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын байгууллага үгүйсгэх боломжтой билээ. Үүний үр дүнд, мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулах магадлалтай. Татварын байгууллагууд шалгагдаж буй жилийн өмнөх таван жилийн татварыг эргэн сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд түүнээс өмнөх хугацааг хамран шалгах боломжтой.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын, ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутгагчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, шилжүүлэх үнэ болон бусад татварын хуулиудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Ийм зарим нэг тохиолдолд удирдлага нь эдгээр тайлбарлалт нь тодорхой бус байх боломжтой хууль тогтоомжуудыг Банкинд ногдох татварын хувь хэмжээг бууруулах байдлаар тайлбарлан үнэлдэг. Дээр дурдсаны дагуу сүүлийн үед бий болсон захиргааны болон шүүхийн практикийн шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь улам хатуу хяналт шалгалтанд өртөж болно. Хэдийгээр байгууллагын санхүүгийн байдал хийгээд нийт үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэх боломжтой боловч татварын байгууллагын байр суурийг урьдчилан баттайгаар таамаглах боломжгүй болно.

39 Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Банкны удирдлага нь холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан хэрэгжүүлсэн байдлаа зохистой бөгөөд Банкны татварын болон бусад хууль тогтоомжийн талаарх байр суурь тогтвортой гэж үзэж байгаа. Удирдлага нь татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэл бага гэж үзэж байна. Удирдлага татвараас үүсэх эрсдлүүдэд тогтмол эргэн хянаж байдаг ба өнөө үед баттайгаар урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас ирээдүйд Банкны байр суурь өөрчлөгдөж болно.

Үйл ажиллагааны түрээсээс хүлээх үүрэг. Банкинд урт хугацаатай, цуцлагдах боломжгүй үйл ажиллагааны түрээс байхгүй, харин харьцангуй богино хугацаанд цуцлагдах боломжтой жил тутмын үйл ажиллагааны түрээс болоод урт хугацааны газрын түрээс байгаа болно. Тиймээс удирдлага нь цуцлагдах боломжгүй хугацаа заасан үйл ажиллагааны түрээстэй холбоотойгоор хамгийн багадаа төлөх шаардлагатай төлбөрийн дүнг материаллаг бус гэж үзэж байна.

Зээлийн гэрээгээр шаардсан харьцаануудын биелэлт. Банк нь төслийн зээлээр авсан эх үүсвэрийн гэрээний заалтаар тодорхой харьцаануудыг хангасан байх үүрэгтэй. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь авсан эх үүсвэрийг нэн даруй буцаан төлөх нөхцөл байдалд хүргэх аливаа зөрчлийг гаргаагүй байна. Дэлгэрэнгүйг тодруулга 24-оос үзнэ үү.

Зээл олголттой холбоотой үүргүүд. Групп болон Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдлийг агуулж байдаг тул Групп болон Банкны нийт эрсдлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэгслүүдийн үндсэн зорилго нь харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэр бэлэн байлгахад оршино. Баталгаа болон нээлттэй аккредитив зэрэг нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болоход Банк өмнөөс нь төлбөр хийнэ гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн зээлийн эрсдэл агуулдаг.

Бичиг баримтын болон арилжааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг татан авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул шууд зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл олгохоор хүлээсэн үүргүүд нь зээл, баталгаа эсвэл аккредитивын хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглагдаагүй хэсгийг илэрхийлж байгаа. Зээл олгох үүргийн зээлийн эрсдлийн хувьд Банк нь ашиглагдаагүй зээлийг харилцагч авсан тохиолдолд ингэж авсан зээлийн нийт хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлд өртөнө. Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл биелүүлж байж зээл авах эрх олж авдаг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага юм.

| Мянган төгрөгөөр | 2016 оны 12 сарын 31 | 2015 оны 12 сарын 31 |
|---|----------------------|----------------------|
| Олгосон санхүүгийн баталгаа | 80,711,003 | 77,016,536 |
| Олгосон гүйцэтгэлийн баталгаа | 76,038,947 | 79,058,179 |
| Импортын аккредитив | 26,119,570 | 13,547,849 |
| Олгогдоогүй зээл | 138,753,364 | 118,044,485 |
| Хасах нь: зээл холбоотой хүлээсэн үүргийн эрсдэлийн сан | (793,072) | - |
| Нийт зээл олголттой холбоотой хүлээсэн үүрэг | 320,829,812 | 287,667,049 |

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитив хамаарагдана) нь тусгайлсан ажил гүйлгээнд ихэнхдээ бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлттэй аккредитив нь хэдийгээр болзошгүй шинж чанартай боловч зээлтэй ижил төрлийн эрсдлийг агуулдаг. Эдгээр ажил гүйлгээний үр дүнд материаллаг алдагдал байхгүй гэж таамаглаж байна.

